



СОЁЛЫН ЯАМ

БҮХ НИЙТИЙН СОЁЛЫН БОЛОВСРОЛ
“АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ БА СОЁЛЫН БОЛОВСРОЛЫН ЯЛГАА”
ЧАНАРЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

*Монгол соёл
Монголын баялаг*

Соёлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар

“АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ БА СОЁЛЫН БОЛОВСРОЛЫН ЯЛГАА” ЧАНАРЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ

2022 ОН

МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН ЯАМНЫ ЗАХИАЛГАТ СУДАЛГАА

Судалгааны баг:

Судалгааны багийн ахлагч:

Б.Цэцэнцолмон Доктор (Ph.D), МУИС-ийн багш. Соёлын антропологич, урлаг судлаач

Гишүүд:

1. Д.Хатанбаатар (Ph.D), дэд проф. ШУТИС-ийн дэд профессор. Археологич, түүхч.
2. Э.Энхжаргал. МА Тунамал ART студийн захирал. Урлаг судлаач.
3. Д.Гэрэлмаа. Боловсролын хүрээлэнгийн ЭША. Боловсрол судлаач.
4. Ч.Мөнхтуул (Ph.D). Нийгэм-Соёлын антропологич. БНХАУ-ын Бээжингийн Төвийн үндэсний их сургууль.
5. М.Ганжаргал. Докторант. СУИС-ийн Соёлын сургуулийн ахлах багш.

Зөвлөх:

Б.Пүрэвсүрэн. Доктор (Ph.D), проф. Философич. ШУА-ийн ФХ-ийн захирал.
Ж.Долгорсүрэн. Доктор (Ph.D), проф. Соёл судлаач. СУИС-ийн зөвлөх профессор.



АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.....	4
ЗУРАГЛАЛЫН ЖАГСААЛТ.....	4
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: УДИРТГАЛ.....	5-16
Нэгдүгээр зүйл: Судалгааны үндэслэл ба зорилго.....	5
1.1. Судалгааны үндэслэл.....	5
1.2. Судалгааны зорилго.....	5
1.3. Судалгааны хүрэх үр дүн.....	6
1.4. Судалгааны хамрах хүрээ.....	7-8
Хоёрдугаар зүйл: Судлагдсан байдал.....	9-11
2.1. Төрийн бодлогын баримт бичгүүд.....	9
2.2. Өмнөх ижил төст судалгаанууд.....	9
2.3. Онолын судалгаанууд.....	10
Гуравдугаар зүйл: Асуудлууд ба онолын тайлбар.....	11-16
3.1. Ойлголтуудын тодорхойлолт.....	11
3.2. Судалгааны гол асуудлууд.....	12
3.3. Онолын тайлбар.....	13-16
Дөрөвдүгээр зүйл: Судалгааны арга зүй ба бүтэц.....	17
4.1. Бодлогын бичиг баримт, судлагдсан байдлын судалгаа.....	17
4.2. Чанарын судалгаа.....	17
4.3. Дүрсийн судалгаа.....	17-18
4.4. Судалгааны хязгаарлагдмал байдал, эрсдэл.....	19
4.5. Судалгааны бүтэц.....	19-20
ХОЁРДУГААР БҮЛЭГ: ХҮН БАЙХ, ОРШИН БАЙХАД СУРАЛЦАХ	20-45
ГУРАВДУГААР БҮЛЭГ: МЭДЭХИЙН ТУЛД СУРАЛЦАХ.....	46-49
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ:ХИЙХИЙН ТУЛД СУРАЛЦАХ.....	50-52
ТАВДУГААР БҮЛЭГ: ХАМТДАА АМЬДРАХАД СУРАЛЦАХ.....	53-61
ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ	62-44
АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....	65-66
ХАВСРАЛТ 1, 2, 3.....	67-115

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БНСБ - Бүх нийтийн соёлын боловсрол

БОЯ – Байгаль орчны яам

БШУЯ – Боловсрол, шинжлэх ухааны яам

НҮБ - Нэгдсэн Үндэсний байгууллага

СӨБ - Сургуулийн өмнөх боловсрол

ТББ – Төрийн бус байгууллага

ХНХЯ – Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам

ЗУРАГЛАЛЫН ЖАГСААЛТ

Зураглал 1: Орон гэрийн гадаад байдал

Зураглал 1а: Орон гэрийн гадаад байдал (малчин өрх)

Зураглал 1б: Өрх гэрийн гадаад байдал (Хашаа байшин)

Зураглал 1в: Өрх гэрийн гадаад байдал (Нийтийн болон амины орон сууц)

Зураглал 2: Өрх гэрийн аж ахуй

Зураглал 3: Өрх гэрийн шүтээн

Зураглал 4: Өрх гэрийг “хамгаалагч”

Зураглал 5: Өрх гэрийн дотоод байдал

Зураглал 6: Өрх гэрийн хоол хүнс

Зураглал 7: Өрх гэрийн зочны ширээ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: УДИРТГАЛ

Нэгдүгээр зүйл: Судалгааны үндэслэл ба зорилго

1.1. Судалгааны үндэслэл

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, Засгийн газраас боловсруулж буй Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр, Соёлын яамнаас “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээний үзэл баримтлал боловсруулан, хэрэгжүүлэхээр зорин ажиллаж байгаа билээ. Энэ хүрээнд хувь хүний соёлын төлөвшил, нийгмийн харилцааны соёл, соёлын боловсрол, Монголын түүх, соёлын өв, ёс заншил хэмээн хүний хөгжлийн үечлэл бүрд тохирсон соёлын хүрээг тодорхойлж байна. Хүн амын дунд эдгээр соёлын хүрээний боловсролын ялгаатай байдлыг тодруулан нягтлах, бодит байдалд дүн шинжилгээ хийх, цаашид соёлын боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах бодлого, арга замыг тодорхойлох шаардлага урган гарч буй юм. Энэ нь өрх гэр, хувь хүний өдөр тутмын амьдралын ахуйн хэв маяг, соёлын хэвшил үйл ажиллагаанд чанарын судалгаа хийж соёлын боловсролын нийтлэг хийгээд ялгаатай байдал, тэдгээрт нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох бодит үндэслэл болсон юм.

Энэхүү судалгаанд “соёлын боловсрол” гэдгийг НҮБ-аас тодорхойлсон **"Соёлын боловсрол нь үндэсний болон хүн төрөлхтний соёлын үнэт зүйлийг хүртэх, эзэмших мэдлэг, ур чадвар, зөв хэвшлийн цогц чадамжтай болох үйл явц, түүний үр дүн"** гэсэн ойлголт болон НҮБ-аас тодорхойлсон боловсролын тулгуур 4 зарчмыг үндэс болгоно. Түүнчлэн гэр бүл-соёлын анхдагч орчин, цахим боловсролын талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, соёл, урлагийн байгууллагын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, судалгааг дэмжих зэрэг иргэний соёлын боловсролыг дээшлүүлэх арга зам, хэв маяг, ялгаатай байдлыг өрх гэрийн хүрээнд ажиглан, дүрсжүүлж судална.

1.2. Судалгааны зорилго

Аливаа нийгэм, соёлын судалгаа хоёр үндсэн чиглэл, талбараас бүрдэж байдаг. **Нэгд**, ямар нэгэн нийгэм, соёлын эсвэл байгалийн үзэгдлийг танин мэдэх, тэр талаарх судалгааг хөгжүүлэх зорилготой судалгаа **хоёрт**, аливаа оршин буй нийгэм-соёлын бодлогыг тодорхойлогч засаглалын байгууллага буюу Засгийн газрын захиалгаар эсвэл хамтарсан зорилтот судалгаа багтана. Энэхүү шинжлэх ухааны талбарын үйл ажиллагааны мөн чанарын үүднээс бидний хийсэн төслийн судалгаа нь энэ хоёр төрлийн судалгааг аль алийг нь агуулж байгаа нь онцлог юм. **Нэгд**, бид Монгол улсын хүн амын соёлын боловсролын өнөөгийн нөхцөл байдал, ялгаатай байдлыг соёлын боловсрол эзэмших мэдлэг, чадвар, хандлагыг нийгэм-соёлын ялгаатай хүрээнд ажиглах, чанарын судалгаа

хийх, дүрсээр баримтжуулах зэрэг юм. Өөрөөр хэлбэл, бид тус судалгаагаар дамжуулан Монгол Улсын өрх гэр, хувь хүний ахуйн хэв маягийн олон янз байдлын ерөнхий зураглал, онцлог дүр төрхийн нарийвчилсан дүрслэлийг хийх юм. Мөн хотын болон орон нутгийн төлөөллөөр соёлын боловсролын ялгарах хүрээ, суурь шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлсийг тодруулахад оршино. Энэ бол өмнө өгүүлсэн шинжлэх ухааны талбарын судалгааны эхний мөн чанарыг харуулах болно. Харин *хоёрт*, бид Соёлын яамтай хийсэн СОЯ 21/367 тоот гэрээний дагуу “Бүх нийтийн соёлын боловсрол”-ын үзэл баримтлалыг боловсруулахад шаардагдах судалгааг өрх гэрийн амьдралын хэв маяг, соёлын боловсролын ялгаатай байдлын хүрээнд дүрсийн болон ярилцлагын аргаар чанарын судалгаа хийж баримтжуулах, цаашид бүх нийтийн соёлын боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах арга замыг тодорхойлох зорилтыг дэвшүүлж байна. Энэ нь шинжлэх ухааны талбарын судалгааны хоёр дахь төрлийн мөн чанарыг харуулж байгаа юм.

1.3. Судалгааны хүрэх үр дүн

Нэг. Судалгааны үр дүнд Монгол Улсын өрх гэр, хувь хүний өдөр тутмын ахуйн хэв маягийн олон янз байдлын ерөнхий зураглал, онцлог дүр төрхийн нарийвчилсан дүрслэл тодорхой болно.

Хоёр. Хотын болон орон нутгийн төлөөллөөр соёлын боловсролын ялгарах хүрээ, суурь шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлсийг тодруулна.

Гурав. Ингэснээр хувь хүний хөгжил, гэр бүлийн боловсрол, нийгмийн харилцаанд чиглэсэн соёлын боловсролын үзэл баримтлалын тулгуур ойлголтууд, хэмжүүр хэмжээс (dimension), шалгуур үзүүлэлтийг тодорхой болгоно. Эдгээрт тулгуурлан Монгол Улсын Засгийн газраас боловсруулж буй Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр, Бүх нийтийн соёлын боловсролын үйл ажиллагаа зэрэг бодлогын хэрэгжилтийг хангах зөвлөмж боловсруулна. Ингэхдээ, нийгмийн бодит байдалд тулгуурласан, гэр бүл, нас насны бүлэгт чиглэсэн соёлын боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх суваг, арга зам, чиглэл саналыг тусгана. Бүх нийтийн соёлын боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх дизайныг дараах хүрээг хамруулан тодорхойлно. Үүнд:

- **Албан боловсролын хүрээнд** - сурагч бүрд соёлын боловсролыг хүртэх нээлттэй боломж олгох, соёлын мэдлэг, ойлголт, ур чадвар олгох чанартай хөтөлбөр, чадварлаг багш бэлтгэх
- **Албан бус боловсролын хүрээнд** - Соёл, урлагийн байгууллагуудын олон нийтэд, тэр дундаа нас насны бүлэгт чиглэсэн, гэр бүлд ээлтэй боловсрол,

танин мэдэхүйн хөтөлбөр, арга хэмжээ, чанар, хүртээмж, уялдаа холбоог сайжруулах, үүнд, соёлын төв, номын сан, музей, галерей, театр г.м.

- **Соёлын дэд бүтэц, түншлэл** - хүн амын соёлын амьдралыг баяжуулах, бие даан боловсрох нөхцөлийг бүрдүүлэх соёлын дэд бүтэц бий болгох; орон нутгийн удирдлага, боловсрол, соёлын салбарыг холбосон сүлжээ, хамтын хөтөлбөрүүд бий болгох, үүнд төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх хөшүүрэг олох.
- **Үндэсний болон орон нутгийн түүх, соёлын бахархлыг бий болгох** - үндэсний болон орон нутгийн соёлын онцлог, түүх, хэл соёлоор бахархсан залуу үеийг хүмүүжүүлэх боловсролын хөтөлбөр, тогтмол арга хэмжээ, наадам фестиваль зохион байгуулах.
- **Соёлын үйл амьдралыг баяжуулах авьяасыг тэтгэх, тусгай хэрэгцээт хүмүүст чиглэх** - Онцгой авьяастай болон амьдралын боломж нөхцөл тааруу зорилтот бүлэг, тусгай хэрэгцээт хүмүүст зориулсан онцгой хөтөлбөр боловсруулах.

1.4. Судалгааны хамрах хүрээ

Уг судалгааг өрх гэр, хувь хүний өдөр тутмын амьдралын хэв маягт тулгуурлан хийсэн болно. Судалгаанд оролцох өрх гэрийг сонгохдоо гэрээнд тусгасны дагуу соёлын боловсролын олон янз байдал илрэх магадлалаар түүвэр хийж, Монгол орны баруун, зүүн, төвийн, хангайн бүсийн төлөөлөл, Улаанбаатар хотын дүүрэг, алслагдсан дүүргийн төлөөллийг тус тус хамрууллаа. Үүнд: соёлын олон янз байдал, үндэсний цөөнх болон зах хязгаар нутгийн онцлог зэргийг хамруулах үүднээс өрхүүдийг сонгон оролцон ажиглалт, гэр бүлийн гишүүдээс сонгон ганцаарчилсан ярилцлага хийх байдлаар зохион байгуулсан юм.

Уг судалгаанд цөөн түүвэр хамруулж байгаа тул зорилтот түүврийн арга ашиглан, өрхийг сонгохдоо гэр бүлийн гишүүдийн тоо, байршил, боловсрол, орлогын түвшин, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн байр суурь, үндэсний цөөнхийн онцлог зэрэг ялгарах байдалд нөлөөлөх хүчин зүйлсийг харгалзан үзсэн болно.

Түүнчлэн уг судалгааны төслийн хүрээнд соёлын боловсролын асуудалд хамаарал бүхий салбарын эрдэмтэн, судлаач, туршлагатай удирдах ажилтан, мэргэжилтэн, экспертүүдээс бүрдсэн фокус бүлгийн уулзалт, ярилцлага зохион байгуулж, санал ярилцлагын судалгааны мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийсэн.

Хүснэгт 1. Судалгааны хамрах хүрээ, өрхөөр

Бүс, нийслэл	Аймаг, дүүрэг	Төвийн хороо	Захын хороо	Алсагдсан хороо	Онцгой нөхцөл бүхий	Нийт
Улаанбаатар	Хан-Уул	1	3	1*	2	7
	Баянзүрх	2	3	1		6
	Сонгино Хайрхан	-	1	1	-	2
	Баянгол	1				
Баруун бүс	Баянхонгор	-	1	1	1	3
	Ховд	2	-	1	1	4
	Увс	1	-	-	-	1
	Баян-Өлгий	1	-	-	-	1
Төвийн бүс	Дорноговь	2	-	1	2	5
Зүүн бүс	Дорнод	1	-	-	1	2
	Хэнтий	-	-	1	1	2
Судалгаанд хамрагдсан нийт 34 өрх						

*Туришлтын өрх

1. Тусгай зураглалыг Улаанбаатар болон ойрын аймгаас сонгосон нийт 10 өрхөд
2. Ерөнхий зургийг Улаанбаатар хот болон, Дорноговь болон бусад аймгийн нийт 12 өрхөд Суурин судлаачид 12 өрхөд ганцаарчилсан ярилцлага буюу нийт **34 өрхөд хийж** гүйцэтгэв.
3. Судалгааны хүрээнд 34 өрхийн нийт 1500 гэрэл зураг, 40 цагийн аудио ярилцлага, 350 МБ файл ажиглалт, ярилцлагын тэмдэглэлийн файл бий болсон бөгөөд үүнийг дараа дараагийн бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч, судлаач мэргэжилтнүүд эх сурвалж болгож ашиглах бүрэн боломжтой.
4. Судалгааг нийгэм, соёлын антропологийн дүрсийн судалгааны арга зүйгээр хийсэн бөгөөд энэхүү судалгааны аргыг эх орондоо нутагшуулах анхны оролдлого болсноор шинжлэх ухааны ач холбогдолтой юм.

Хугацаа: 2022-02-25-ны өдрөөс 2022-05-25 өдөр, нийт 3 сар

Хоёрдугаар зүйл: Судлагдсан байдал

Уг төслийн судалгааны ажлын бэлтгэл болон бусад үе шатад холбогдох судлагдсан байдлыг *нэгд*, тус сэдэвтэй хамаарал бүхий төрийн бодлогын баримт бичгүүд, *хоёрт*, сэдвийн хүрээний өмнөх судалгаа, ном зохиол, *гуравт*, онолын болон арга зүйн холбогдолтой судалгаа гэх байдлаар ангилж болох юм.

2.1. Тус сэдвийн хүрээнд холбогдох хууль эрх зүй, бодлогын баримт бичгүүд:

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992
2. Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал-2010
3. БСШУЯ, БХ, ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс. *Монгол улсын боловсролын суурь мэдээллийн тайлан*, Улаанбаатар хот, 2019
4. ҮСХ, УИХ. 2019. Монгол улс - НҮТС 2018
5. Монгол Улсын боловсрол, соёл, шинжлэх ухааны, спортын сайдын тушаал. 2019 оны 8 дугаар сарын 2 өдөр. Хөтөлбөр батлах тухай.
6. [АЛСЫН ХАРАА 2050 МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО.pdf \(nda.gov.mn\)](#)
7. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль [...: www.Legalinfo.mn - Хуулийн нэгдсэн портал сайт ::..](#)
8. Соёлын тухай хууль [СОЁЛЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ \(legalinfo.mn\)](#)
9. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр [Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр \(meds.gov.mn\)](#)
10. Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр /төсөл/

2.2. Тус сэдвийн хүрээнд хийгдсэн өмнөх судалгаа, ном зохиол:

1. Монголын маркетингийн судалгааны ассоциаци ТББ. Монгол үндэстний ижилслийг илтгэх бэлгэдэл, соёлын судалгаа, Улаанбаатар хот. 2019
2. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарын чанарын судалгаа, Эм Эм Си Жи ХХК, 2021, Улаанбаатар хот.
3. Ш. Ариунболд, Ц.Янжиндулам нар. *Монгол улсын аз жаргалын индексийг олон улсын түвшинтэй харьцуулсан судалгаа, 2016*. Улаанбаатар хот.
4. Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар. *Хүүхдийн хөгжил, төлөвшил, хүмүүжилд сөрөг нөлөө үзүүлж болох хүчин зүйлийг тодорхойлох судалгаа*. 2019. Улаанбаатар хот.
5. Соёл урлагийн их сургууль. *Монголчуудын үнэт зүйлийн судалгаа*. 2019. Улаанбаатар хот.
6. Санхүү эдийн засгийн их сургууль. *Монголчуудын үндэстний үнэт зүйлийн судалгааны тайлан*. 2015. Улаанбаатар хот.

7. У.Туяа нар. *Ерөнхий боловсролын болон их, дээд сургууль, мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагчдад зориулсан эрх зүйн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгааны тайлан*. 2021. Улаанбаатар хот.
8. О.Пүрэв, Г.Түвшинжаргал. *Түүхийн сургалтын хөтөлбөрт Монгол үндэстний нэгдмэл үнэт зүйлийг тусгах агуулга, арга зүйн судалгаа*, Улаанбаатар хот.
9. Mongolian Marketing consulting group. *Монгол хүний эрхэм чанар, зан суртахууны судалгаа*. 2019. Улаанбаатар хот.
10. Боловсролын хүрээлэн. *Боловсролын чанар, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн бодлогын судалгаа*. 2020. Улаанбаатар хот.

2.3. Тус сэдвийн хүрээнд ашиглагдах онол, арга зүйн бүтээлүүд:

1. Basis for Cultural Education: Guide for the future of school-based and extracurricular cultural education.
2. United Nations Educational, Scientific and Cultural Organization. 2014. *UNESCO Cultural for development indicators, Methodology Manual*.
3. Dawn Mannay. *Visual, narrative and creative research methods: application, reflection and ethics*. Routledge.
4. А.А. Возьмитель Г.И. Осадчая. *Образ жизни: Теоретико-Методологические основы анализа*.
5. United Nations Educational, Scientific and Cultural Organization, 2015. *Соёлын бодлогыг дахин тодорхойлох нь*. 2005 оны Конвенцийн дэлхийн тайлан.
6. Европейская экономическая комиссия. 2006 года. *Индикаторы для образования в интересах устойчивого развития*.
7. Н. Бэгз нар. 2018. *Хүүхэд залуучуудын хөгжлийн онол арга зүй*. Улаанбаатар.

Гуравдугаар зүйл: Асуудлууд ба онолын тайлбар

3.1. Ойлголтуудын тодорхойлолт

Тус судалгааны турш олон нийтийн болон судалгааны багийн тайланд тогтмол хэрэглэгдэх, судлагдах хэд хэдэн гол ойлголтууд байгаа билээ. Тэдгээрийг доор тодорхойлов. Үүнд:

ГЭР

Монгол хэлэнд *гэр* хэмээн хэрэглэгддэг энэхүү ойлголт бол орон зайн эзэмшлийн шинжтэй, нийгмийн соёлоор нөлөөнд бүрдэн бий болж, тасралтгүй хувьсан өөрчлөгдөж байдаг ойлголт юм. Дэлхийн олон үндэстний соёлд *house/home, jia* гэх мэт олон янзаар нэрлэгдэх уг ойлголт нь шашны зан үйл, ураг төрөл, эдийн засаг, улс төрийн үйл ажиллагааны дүнд бүтэн бий болдог байна. Монгол хэлний *гэр* гэх ойлголт бол зөвхөн ураг төрлийн олон янзын бүлгийн амьдарч байгаа орон зайгаас гадна тодорхой нутаг ус, цаашлаад улс эх орны хэмжээний дотоод орон зайг хэлдэг. Харин шашны зан үйлийн үүднээс *гэр* бол танил дотно орон зай буюу муу муухай, ад зэтгэрээс ангид орших орон зай гэж ч болох юм.

ГЭР БҮЛ

Монгол хэлтний хүрээнд *гэр бүл* гэдэг бол аав, ээж, хүүхэд төвтэй, “цусан төрөл”-ийн харилцааг тулгуур болгон бүтээн цогцлоодог ойлголт юм. Энэхүү ойлголт нь дэлхийн олон нийгэм-соёлд *family, jiating* гэх мэтээр өргөн хүрээндээ *mop, state, guojia* гэх мэтийг бүтээдэг ураг төрлийн бүлгийн нэр юм.

АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ (LIFESTYLES)

Амьдралын хэв маяг гэдэг нэр томьёо сүүлийн арваад жилд олон нийтийн дунд тархан, өргөн хэрэглэгдэх болсон хэдий ч түүнээс өмнө нийгмийн шинжлэх ухааны судалгааны хүрээнд хэрэглэгддэг ойлголт юм. Тус ойлголт нь судлаачид дэлхийн олон нийгэм-соёлыг судлахдаа тухайн судлуулж буй хүмүүсийн амьдарч буй орон зайн ялгаатай байдлаар физик хүчний, эдийн засгийн, соёл болон мэдээллийн, бэлгэдлийн баялгийг хэрхэн ялгаатай байдлаар хүртэж, баялгийг хуваарилж, бас нэгтгэж байгаагаар өөрийн орон зайгаа хэрхэн бүтээж байгаа үйл явцыг судлахдаа ашигладаг нэр томьёо юм. Өөрөөр хэлбэл, амьдралын хэв маяг гэдэг бол антропологич Pierre Bourdieu-гийн “Төрийн тухай” зохиолдоо хэлсэнчлэн хувь хүн болон нийгмийн бүлгүүд өмнө дурдсан дөрвөн төрлийн баялгийг хэрхэн хүртэж байгаа тухай асуудал юм.

СОЁЛЫН БОЛОВСРОЛ (CULTURAL EDUCATION)

Уг ойлголт бол Монголын хувьд уугуул соёлд байсан уламжлалт ойлголт төдийлөн биш ч НҮБ, ЮНЕСКО зэрэг олон улсын *universalism*-ийн орон зайн төсөл,

хөтөлбөрүүдээр дамжин Монголын төрийн бодлогын болон эрдэм шинжилгээний орон зайд сүүлийн жилүүдэд түгэн нэвтэрч буй ойлголт юм.

НҮБ-ийн тодорхойлолтоор “Соёлын боловсрол нь үндэсний болон хүн төрөлхтний соёлын үнэт зүйлийг хүртэх, эзэмших мэдлэг, ур чадвар, зөв хэвшлийн цогц чадамжтай болох үйл явц, үүний үр дүн” гэж үзэж байна. Судалгаанд энэхүү тодорхойлолт болон түүний “тулгуур дөрвөн зарчим”-ыг үндэс болголоо. Үүнд, 1. Хүн байх, орших байхад суралцах, 2. Мэдэхийн тулд суралцах, 3. Хийхийн тулд суралцах, 4. Хамтран амьдрахад суралцах гэсэн боловсролын тулгуур дөрвөн зарчмыг мөрдлөг болгон шалгуур үзүүлэлт, хэмжүүр, судалгааны асуулгыг боловсруулсан.

Түүнчлэн олон нийтэд чиглэсэн “соёлын боловсрол”-ын төрийн бодлого, үйл ажиллагааны олон улсын шилдэг туршлага, шалгуур үзүүлэлтийг ч харьцуулан шинжилсэн. Тухайлбал, сургуульд суурилсан албан болон хичээлийн хөтөлбөрөөс гадуурх үйл ажиллагаагаар соёлын боловсрол олгох Нидерландын үндэсний бодлогын туршлага (Basis for Cultural Education 2017)-д төрөөс хувь хүн, хүүхэд залуучуудын оршин байх, суралцах “соёлын баялаг орчин”, “соёлын дэд бүтэц” байгуулах урьдач нөхцөлийг бүрдүүлэхийг чухалчилсан байна. Мөн Европын эдийн засгийн зөвлөлөөс гаргасан “Тогтвортой хөгжлийн боловсролын шалгуур үзүүлэлт, хэмжүүр асуултууд”-ыг анхааралтайгаар судалсан. Соёлыг хувь хүний төлөвшил, нийгмийн хөгжлийн тулгуур гэж үзэхдээ ЮНЕСКО-оос тодорхойлсон эдийн засаг, боловсрол, засаглал, нийгмийн оролцоо, жендерийн тэнцвэртэй байдал, холбоо харилцаа, өв соёлын гэх мэт олон тулгуурт шалгуур үзүүлэлтүүдийг харгалзан үзэв (Culture for Development Indicators 2014). Үүнээс гадна хүний үйл ажиллагаа, нийгмийн харилцааг танин мэдэх үндэс болгодог “амьдралын хэв маяг” (А. А. Возмитель, Г. И. Осадчая 2009) гэсэн философи, эдийн засаг, антропологи, социологи зэрэг нийгэм, хүмүүнлэгийн салбар дундын ойлголтыг үндэслэв.

3.2. Судалгааны гол асуудал

Бид өмнө хэсгүүдэд дурдсан тус судалгааны эцсийн хамгийн гол зорилго бол бүх нийтийн соёлын боловсролын бодлого боловсруулахад шаардлагатай өнөөгийн бодит байдлыг тодруулж, дүн шинжилгээ хийхэд оршино. Үүний тулд бид Монгол улсын өөр өөр бүс, орон нутгийн гэр бүлийн жишээг дүрсийн болон ярилцлага, оролцон ажиглалт гэх мэт нийгмийн шинжлэх ухааны судалгааны арга зүйгээр судалж, тэдний амьдралын олон талт хэв маяг буюу дурдан буй өнөөгийн бодит байдал болон соёлын боловсролыг хүртэх, эзэмших байдлыг судлах юм. Тиймээс энэхүү судалгааны хувьд дараах хоёр асуудлыг бүхий л судалгааны явцад тодруулж, хариулт өгөхийг хичээсэн болно. Үүнд:

- Монголын өнөөгийн нийгэм дэх амьдралын хэв маягийн олон янз байдал, тэдгээрийн онцлог
- Соёлын боловсролыг хүртэх, эзэмших байдал нь ямар байгаа гэх мэт юм.

3.3. Онолын тайлбарууд

Энэхүү судалгааны явцад бидний гол зорилго бол нийгмийн шинжлэх ухааны судалгааны арга зүй тэр дундаа хүн судлалын арга зүйгээр өнөөгийн Монголчуудын өдөр тутмын амьдралын олон хэв маяг дахь соёлын боловсролын хүртээмжийн ялгаатай байдлыг тодруулах явдал болно. Энэ нь эцэстээ онолын талаасаа биднийг өдөр тутмын амьдралын хэв маяг гэх ойлголтыг судлах болгож байгаа юм. Нийгмийн шинжлэх ухааны түгээмэл тайлбарт “амьдралын хэв маяг (lifestyle) гэдгийг нь хувь хүн, бүлгийн соёлын сонирхол, үзэл бодол, зан төлөв, зан үйлийн чиг баримжаа”¹ хэмээн тодорхойлсон байдаг. Энэ нэр томъёог анх Австрийн сэтгэл судлаач Альфред Адлер 1929 онд хэвлэгдсэн “Хатагтай Р-ийн хэрэг” хэмээх номдоо “хүний бага наснаасаа эхлэн тогтсон үндсэн зан чанар” гэсэн утгаар сэтгэл судлалын үүднээс тодорхойлолт хийсэн байдаг. Цаашилбал амьдралын хэв маягийг “амьдрах арга зам” юм уу эсвэл “хэв маяг” гэж ойлгодог байдал 1960-аад оноос хойш нийгмийн шинжлэх ухаанд түгэх болсон. Энэ мэт эхэлсэн нийгмийн шинжлэх ухааны олон салбарын судалгаанд уг ойлголт нь дэлхийн олон улс орны нийгэм, соёлын жишээгээр баяжсан байдаг. Тэдгээр судалгаануудыг ерөнхийд нь авч үзвэл амьдралын хэв маягийг *нийгмийн байдал талаас* нь судалсан судалгаа, *сэтгэлгээний хэлбэр талаас* нь судалсан судалгаа, *үйлдлийн зүйл болох тухай судалсан судалгаа* гэж гурав ангилах боломжтой байгаа юм. Эдгээрийг дор дэлгэрүүлж авч үзье.

Амьдралын хэв маяг нийгмийн байдал болох нь

Амьдралын хэв маягийн талаарх өмнөх судалгаанууд нь нийгмийн бүтэц, түүний доторх хувь хүмүүсийн харьцангуй байр суурийг шинжлэхэд чиглэгддэг. Торштейн Веблен ([Thorstein Veblen](#)), “өрсөлдөхүй”-н талаарх үзэл баримтлалаараа энэ хэтийн төлөвийг нээж, хүмүүс нийгмийн доод давхарга болон нийгмийн давхаргаас ялгарах хүслээс хамааран тодорхой “амьдралын схемүүд”, ялангуяа “бусдад харуулах хэрэглээ” (conspicuous consumption)² тодорхой хэв маягийг баримталдаг гэж баталжээ. Макс Вебер амьдралын хэв маягийг тодорхойлохдоо “нэр хүндийг хүлээн зөвшөөрөх диалектикийн нягт холбоотой бүлгүүдийн статусын өвөрмөц элемент” гэжээ. Түүнийхээр амьдралын

¹ [Lynn R. Kahle](#); Angeline G. Close (2011). *Consumer Behavior Knowledge for Effective Sports and Event Marketing*. New York: Routledge.

² Энэ нь бусдад ил харуулж, нийгмийн байр сууриа тодорхойлох зорилгоор бодит хэрэгцээнээс илүү үнэтэй, их хэмжээний бараа бүтээгдэхүүн худалдаж авдаг үйлдлийг хэлнэ.

хэв маяг нь нэг нийгмийн давхаргад ч нийгмийн ялгааны хамгийн тод илрэл бөгөөд ялангуяа хувь хүмүүсийн итгэдэг нэр хүндийг харуулдаг. Георг Симмел амьдралын хэв маягт албан ёсны дүн шинжилгээ хийсэн бөгөөд тэрээр энэ ойлголтын гол цөм нь “босоо” үйл ажиллагаа явуулдаг, амьдралын хэв маягийг бий болгох үйл явц, түүний үр нөлөө гэж ойлгогдох хувь хүнчлэх, таних, ялгах, хүлээн зөвшөөрөх үйл явцууд байдаг гэжээ. Мөн Францын социологич, антропологич Пьер Бурдьё энэ ойлголтыг судалсан байна. Тэр бээр энэхүү хандлагыг илүү нарийн төвөгтэй загварын хүрээнд шинэчилж, гол төлөв нийгмийн дадал зуршил (*habitus*)-аас бүрдэх, хувь хүний таашаалтай нягт уялдаатай амьдралын хэв маяг гэгч зүйл нь тухайн талбарын бүтэц, амьдрах орчинтой холбоотой үйл явц хоорондын огтлолцлын үндсэн цэгийг төлөөлдөг гэсэн байна.

Амьдралын хэв маяг нь сэтгэлгээний онцлог болох нь

Амьдралын хэв маягийг гол төлөв сэтгэлгээний онцлогтой холбон тайлбарладаг нь сэтгэлзүйн шинжилгээнд суурилсан хандлага гэж болно. Анх Альфред Адлераас эхлээд амьдралын хэв маягийг хувь хүний ахуйн онцлог гэж ойлгодог болсон бөгөөд энэ нь хувь хүний залуу насандаа бий болгодог үнэт зүйл, зарчмуудын хүрээ нь аажимдаа насан туршийн үйлдэл болон тогтож, зарчмын тогтолцоог тодорхойлдог гэсэн утгаараа авч үзжээ.

Амьдралын хэв маяг нь үйл ажиллагааны онцлог болох нь

Амьдралын хэв маягийг үйл ажиллагааны профайл болгон шинжлэх нь үйл ажиллагааны түвшнийг амьдралын хэв маягийн энгийн дериватив, эсвэл наад зах нь тэдний хажуугийн бүрэлдэхүүн хэсэг гэж үзэхээ больсон, харин түүнийг бүрдүүлэгч элемент гэж үздэгээрээ онцлог юм. Эхэндээ энэ үзэл баримтлал нь голчлон хэрэглэгчийн зан төлөвт төвлөрч, олж авсан бүтээгдэхүүнийг хувь хүний өөрийн дүр төрх, нийгэм дэх байр сууриа хэрхэн хардаг материаллаг хавтгайд илэрхийлэгддэг объект гэж үздэг байв. Дараа нь үзэл баримтлал нь өдөр тутмын амьдралын түвшинд илүү төвлөрч, Жоффре Дюмазедиер, Антоон Гидденс зэрэг социологичдын адил цагийг ашиглах, ялангуяа лузер дээр анхаарлаа төвлөрүүлж, сонголтын идэвхтэй хэмжигдэхүүн хоорондын харилцан үйлчлэлийг судлахыг оролдсон.

Бид энэ удаагийн судалгаанд монголын нийгэм дэх хүн амын амьдралын хэв маягийг антропологич Пьер Бурдьегийн тайлбарт дурддаг “хабитус” буюу ухамсарласан ухамсарлаагүй дадал мэт нэгэн зүйлийн гол төлөв нийгмийн дадлын шинжтэй, хувь хүний таашаалтай нягт уялдаатай зүйл гэдэг талаас нь авч үзлээ. Ингэж үзэхийн учир нь амьдралын хэв маяг бол олон талт шинжтэй, тасралтгүй хувирч өөрчлөгдөж байдаг зүйл. Хүмүүс түүнийг тэр бүр ухамсарладаг зүйл ч биш. Тэрчлэн бүтцийн онолд хэлдэгчлэн тогтсон бүтэцтэй ч юм биш учраас энэ бол Бурдьегийн хэлсэн хабитусын зүйл юм.

Амьдралын хэв маягийг тодорхойлох суурь судалгааны аргачлал

Амьдралын хэв маягийг тодорхойлох суурь аргачлалыг Арнольд Митчелийн VALS (Value and Lifestyle) сегментийн аргачлалтай холбон боловсруулсан байдаг. АНУ-д анх 1980-аад онд, хожим нь Баруун Европ: Их Британи, Герман, Итали, Францад сэргээн хэрэгжүүлсэн байна. Түүнчлэн А.Маслоугийн хэрэгцээний шатлалын онол, Д.Рисмений нийгмийн зан суртахууны онол хандлагад тулгуурлажээ. Эдгээр 2 үзэл хандлагын нийлбэр дээр амьдрал-үйл ажиллагааны 3 суурь загвар, амьдралын 9 хэв маягийг тодруулсан байна. Үүнд:

1. Анхдагч хэрэгцээндээ хөтлөгдөн амьдардаг хүмүүс (need-driven)
 - Амьд үлдэхийн төлөөх, дээшлэн дэвших боломжгүй хүмүүс (survivor)
 - Өөрийн амьдралаа аваад явдаг, тэмцдэг, өгсдөг, өөдрөг үзэлтэй залуу хүмүүс (sustainer)
2. Уламжлалт буюу гадагш чиглэсэн үйлдэлтэй (traditional, outer-directed developmental path)
 - Хуучинсаг үзэлтнүүд, ялгарахыг хүсдэггүй дундаж анги, нийгмийн бүтцийн салшгүй хэсэг (belongers)
 - Дээд хэв маягийн эсрэг, нийгмийн илүү дээд түвшний статус руу тэмүүлдэг бүлэг (emulators)
 - Амжилтаар хөтлөгдсөн, нэр хүндтэй, чинээлэг хангалуун хүмүүс (achievers)
3. Орчин үеийн, дотогш чиглэсэн үйлдэлтэй хүмүүс (contemporary, inner-directed developmental path)
 - Гадагшаа болон дотогшоо чиглэсэн хүмүүсийн завсрын шинжтэй, залуу, шийдэмгий, нацист, зан байдал амьдрал дээр өвөрмөц бүлэг (I-Am-Me's)
 - Дотоод үнэт зүйлдээ хөтлөгдөх боловч, дээрх (I-Am-Me's) хэв маягийн хүмүүстэй харьцуулахад аминч бус. Үзэл хандлага, ойлголт, асуудлыг шийдвэрлэх болон аливаа үйл ажиллагааны салбарт идэвхтэй. Моод болон бүлгийн үйл ажиллагаанд чухал үүрэгтэй, аливаа шинэ санаа, бүтээгдэхүүнийг хэрэгжүүлэхэд голлох үүрэгтэй (experimentals)
 - Дотоод ертөнцийн дээд зэргийн хөгжилтэй, нийгэм, улс төр, оюун санааны үнэт зүйлийн талаар эргэцүүлэн боддог хүмүүс. Бүхэллэг тогтолцооны үнэт зүйл, нэгдмэл ертөнцийг үзэхүйн үндсэн дээр янз бүрийн салбарын үйл ажиллагаанд маш идэвхтэй оролцдог. Амьдралын хэв маяг нь оюунлаг, дотоод ертөнцийн хөгжилд илүү анхаардаг, хувь хүний үнэт зүйлийн хөгжлийг дээдэлдэг (societally conscious).

4. Гадагшаа чиглэсэн арга хэрэгслийн эрх мэдлийг дотоод сэтгэлийн мөн чанартай нэгтгэсэн. Удирдах байр суурьтай, аливаа зөрчил мөргөлдөөнийг зохистой шийдвэрлэдэг, бусдын үзэл санаанд хүлээцтэй ханддаг (integrated) (Возьмитель, 2017).

Эдгээр амьдралын хэв загварууд нь дотоод логик уялдаатай, тэдгээрийн үндсэн дээр улс орны социографик дүр зургийг боловсруулан харьцуулсан судалгаанд ашиглах боломжтой юм. Энэ судалгааны хүрээнд өрх гэрийн өдөр тутмын ахуйн хэв маягийн олон дүр төрхийг тодорхойлохдоо уг загварчлалыг баримтлан зураглах оролдлого хийсэн.

Дөрөвдүгээр хэсэг: Судалгааны арга зүй ба бүтэц

Тус судалгааны хувьд хамгийн сайн арга гэж үгүй, харин асуудал бүрийг тодруулахад хамгийн тохирсон арга зүйг баримтлах зарчмаар ажилласан. Өөрөөр хэлбэл, тус судалгаа бол нийгмийн шинжлэх ухааны нэгэн судалгаа түүнээс биш тодорхой нэг салбар шинжлэх ухааны онол, арга зүйн хүрээнд асуудлыг хумихгүй. Учир нь өнөөгийн монголын төдийгүй аль ч нийгэм соёлын талбарт судалгаа хийхэд тодорхой салбар шинжлэх ухааны ялгаатай арга зүйгээр судлах нөхцөл улам бүр хомс болсныг бид мэднэ. Энэ утгаараа бидний тус судалгаанд хэрэглэсэн судалгааны аргазүйг:

1. Судалгааны баримт цуглуулах
2. Судалгааны үр дүнг боловсруулах гэж ерөнхийд нь хоёр ангилж болох юм.

Судалгааны баримт цуглуулах арга зүйг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

Баримт бичгийн судалгаа: Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эрхзүйн актууд, бодлогын баримт бичиг, хөгжлийн бодлого төлөвлөлтөд бүх нийтийн соёлын боловсролын асуудал хэрхэн туссан талаар мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийнэ.

Ажиглалтын судалгаа – нийгэм, соёлын антропологийн үндсэн арга болох этнограф судалгаа, оролцон ажиглах, ганцаарчилсан ярилцлага хийх замаар судалгааны мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийнэ.

Дүрсийн судалгаа - гэрэл зураг, дүрс бичлэг, нягтшил байршил тодорхойлох газрын зураг (mapping), нарийвчилсан зураглал (snapshot), сэдэвчилсэн зурган цуврал (фото эссэ), дүрсэн ажиглалт, баримтжуулалт арга зэргийг тус тус ашиглан дүрсэн мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийнэ.

Фокус бүлэг, экспертний ярилцлага - соёлын боловсролд хамаарал бүхий салбарын эрдэмтэн, судлаач, туршлагатай удирдах ажилтан, мэргэжилтэн, экспертүүдээс бүрдсэн фокус бүлгийн уулзалт, ярилцлага зохион байгуулах замаар судалгааны мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийнэ. Түүнчлэн ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлагын чиглүүлэх асуулт, удирдамж, дүрсийн судалгааны удирдамж тус тус боловсруулан гаргана. Сонгогдсон өрхийн гишүүнээс авах ганцаарчилсан ярилцлагын загварыг боловсруулахдаа “Бүх нийтийн соёлын боловсрол”-ын арга хэмжээнд заасан хувь хүний соёл, Монгол хүний төлөвшил, нийгмийн харилцааны соёл, эко соёл, цахим соёлыг төлөвшүүлэх үндсэн зорилгод нийцүүлэв. Мөн өмнө дурдсанчлан НҮБ-аас тодорхойлсон: 1. Хүн байх, орших байхад суралцах, 2. Мэдэхийн тулд суралцах, 3. Хийхийн тулд суралцах, 4. Хамтран амьдрахад суралцах гэсэн боловсролын тулгуур дөрвөн зарчмыг мөрдлөг болгон шалгуур үзүүлэлт, хэмжүүр, судалгааны асуулгыг боловсруулав.

Судалгааны үр дүнг боловсруулах, асуудлыг задлан шинжлэх аргазүйн хувьд бид **онол-судалгаа-онол-судалгаа-онол** гэсэн дарааллыг баримталсан болно. Өөрөөр хэлбэл бид судалгааны эхний шатанд арга зүйн болон онолын хэлэлцүүлгийг судалгаатай холбогдуулан удаа дараа зохион байгуулсан. Судалгааны дизайн боловсруулах хэлэлцүүлгүүдийн дараа туршилтын судалгааг Улаанбаатар хот болон хот орчмын аймаг, орон нутагт хийсэн. Туршилтын судалгааны явцад үүссэн асуудлуудыг эргэн мөн хэлэлцэж, задлан шинжилж судалгааны удирдамж, зөвлөмжөө сайжруулж байв. Сайжруулан боловсруулсан удирдамжийн дагуу үндсэн судалгаанд гарсан. Судалгааны багийн гишүүд хуваарилагдан үндсэн судалгааг авч, баримт цуглуулсны дараа үр дүнг боловсруулж, холбогдох онолуудаар дахин шүүн тунгаах, боловсруулалт хийх замаар уг судалгааны тайлан бичигдсэн билээ.

4.4 Судалгааны хязгаарлагдмал байдал, эрсдэл

Уг судалгааг өрх гэрийн хүрээнд ажиглалт хийж явуулсан бөгөөд албан боловсрол, соёл, урлагийн үйлчилгээний байгууллагын хүрээнд явуулаагүй. Гэр бүл бол аж төрөх, ахуйн соёлын бүхий л мэдлэгийн үндэс болж байдаг ураг төрлийн, нийгмийн, шашны, улс төрийн бүлэг. Нөгөө талаас түүх, соёл, хүчний нэгдэл болсон бүлэг. Орон зайн эзэмшлийн хувьд энэ бол “хувийн орон зай”-г харуулж байдаг. Энэ утгаараа тухайн талбарын орон зайг судлахын тулд судлаач аль болох урт хугацаанд дотор нь орж, “гүн тайлбар”(tick a description) хийх ёстой байдаг. Гэвч бидний судалгаа захиалагчийн санал болгосон богино цаг хугацаанд асуудлыг гүн гүнзгий олж мэдэх ёстой байсан. Энэ байдлаас үүдэн судлаач богино хугацаанд олон асуудлыг үнэн бодитой олж тодруулахад бэрхшээлтэй байсныг энд дурдах нь зүйтэй. Тухайлбал,

1. Судалгаанд оролцогч хувь хүн, өрх гэрийн үйл ажиллагаатай холбоотой зарим мэдээллийг өгөхөөс цааргалах, татгалзах,

2. Дүрсийн судалгаанд хувь хүн, өрх гэрийн үйл ажиллагаатай холбоотой зураг дүрс авхуулахаас татгалзах, зөвхөн хүн оролцоогүй хэсгийн зураг авхуулах, дүрсийн мэдээлэл цуглуулахад техникийн хүртээмжтэй холбоотой доголдол үүсэх

3. Мэдээлэл цуглуулах ажил төлөвлөсөн маршрут, өрхийн тоо, заасан хугацаандаа багтахгүй байх зэрэг хүндрэл үүсэж байв.

4.5. Судалгааны тайлангийн бүтэц

Тус төслийн судалгааны тайлан нь удиртгал, үндсэн дөрвөн бүлэг, дүгнэлт, хавсралт, санал зөвлөмж, ном зүй гэсэн хэсгээс бүрдэнэ. Удиртгал хэсэгт бид судалгааны үндэслэл, зорилго, судлагдсан байдал, аргазүй, онолын тайлбар гэх мэт агуулгыг хамарсан бол үндсэн бүлгүүд болох хоёроос тавдугаар бүлгүүдэд төслийн хүрээнд хийгдсэн үндсэн судалгааны тайлангуудыг танилцуулж задлан шинжлэх болно. Харин дүгнэлт хэсэгт эдгээр тайлангуудын үр дүнгээс үүдсэн судалгааны багийн ерөнхий дүгнэлтийг танилцуулж байгаа болно. Харин хавсралт хэсэгт судалгааны явцад судлаачдын боловсруулсан асуулга болон бусад баримт бичгийг хамруулав. Зөвлөмж хэсэгт тус судалгааны үр дүнд үндэслэн захиалагч болон бодлого боловсруулагчдад зориулсан зөвлөмжийг оруулав.

ХОЁРДУГААР БҮЛЭГ: ХҮН БАЙХ, ОРШИН БАЙХАД СУРАЛЦАХ

Энэ бүлэгт бид уг төслийн судалгааны гол судлагдахуун буюу соёлын боловсролын нэг гол ай болох “хүн байх, оршин байхад суралцах” тухай хэсгийн судалгааны үр дүнг танилцуулах болно. “Хүн байх, оршин байхад суралцах” гэдэг бол НҮБ-аас тодорхойлсон соёлын боловсролын үндсэн дөрвөн зарчмын нэг юм. Энэ нь хүний оршин байх анхдагч хэрэгцээтэй уялдаатай суралцаж буй нийгэм, соёлын мэдлэгийн төрөл зүйл юм. Үүнийг тодорхойлох хүрээг *хувь хүн, гэр бүлийн гишүүн* болон Монгол Улсын *иргэн* болж төлөвших үйл явцаар тодорхойлохыг зорьсон болно. Үүнд *нэгд*, хувийн соёлыг төлөвшүүлэх зорилтын хүрээнд хүн байх оршин байхад гэр бүлийн орчинд өдөр тутам суралцдаг арга замыг тодорхойлсон. Тухайлбал, хувь хүний өдөр тутмын амьдралын хэвшил дадал, гэр бүлийн өмнө хүлээсэн үүрэг, харилцаа, амьдралын чанар, хэрэгцээ шаардлага, хүүхдийн хүмүүжил зэрэг асуудлыг ажиглан тодруулсан.

Өнөөгийн Монголын гэр бүл “цөм гэр бүл” буюу “эхнэр, нөхөр, хүү/охин”-оос бүрдэх бүтэц давамгайлж байгааг харж болно. Үүнтэй зэрэгцэн эмээ, өвөө, авга, нагацыг багтаасан “өргөтгөсөн гэр бүл”-ийн хэлбэр мөн тохиолдоно. Цаашилбал, гэр бүлийн бүтцийн хувьд анхаарвал зохих асуудал бол амьжиргааны болон нийгмийн элдэв шалтгаанаар цөм гэр бүлийн аль нэг гишүүн гэр бүлээсээ урт болон богино хугацаагаар алслагдсан дүр зураг олонтоо тохиолдож байлаа. Малчдын хувьд 18-аас доош насны хүүхдүүд нь сургуульд сурахаар аймаг, сумын төв, нийслэлд суудаг, зарим тохиолдолд тэднийг дагаад эмэг эх, өвөг эцэг, эс бөгөөс эх нь хамтдаа төв суурин газарт суудаг. Харин хот суурин газрынхны хувьд эхнэр, нөхрийн аль нэг нь уул уурхайн салбарт ээлжээр ажилладаг эсвэл гадаад улсад сурч, хөдөлмөрлөдөг байна. Гэр бүлийн гишүүд хамтдаа бус, удаан хугацаагаар алслагдах байдал нийгмийн үзэгдэл болсон нь соёлын боловсролын хүртээмж, хүртэх, эзэмших арга зам, эргэх холбоо сул байх суурь шалтгааны нэг гэж үзэж байна. Учир нь хүүхдийн хүмүүжил, өдөр тутам суралцах, нийгэмших, соёлыг үе дамжуулан уламжлах үндэс хөрс нь гэр бүлийн орчин байдаг.

Зураглал 1. ОРОН ГЭРИЙН ГАДААД БАЙДАЛ

		
<p><i>Хэнтий аймаг. Цэнхэрмандал сум. Хужхан баг. Малчин өрх</i></p>	<p><i>Улаанбаатар хот. Баянзүрх дүүрэг, 20-р хороо. Хувийн хэвшилд ажиллагч</i></p>	<p><i>Ховд аймаг. Ховд хот. 1-р баг. Магсаржав. Их сургуулийн багш</i></p>
		
<p><i>Улаанбаатар хот. Сонгинохайрхан дүүрэг, 19-р хороо. Дунд сургуулийн багш.</i></p>	<p><i>Улаанбаатар хот. Хан уул дүүрэг 17-р хороо “River Garden 2”. Эрүүл хооллолтын багш</i></p>	<p><i>Улаанбаатар хот. Хан уул дүүрэг. Нүхт хотхон. Хувиараа бизнес эрхлэгч</i></p>

Хоёрт, монгол хүний хүмүүжил төлөвшлийн зорилтын дор монголын түүх, өв соёл, ёс зүй, зан заншлын тухай мэдлэг олж авдаг арга замыг тодорхойлохыг зорьсон. Үүний тулд монгол ёс уламжлалаа хэр зэрэг/хэрхэн дээдэлдэг? ямар ёс заншлыг дагаж мөрддөг вэ (ахмадаа ачлах, мэндлэх хүндлэх, баяр ёслол, тэнгэр хангай, уул усаа шүтэх, төрөө дээдлэх г.м.), монгол хэл, бичгээрээ зөв ярьж бичихийг чухалчилдаг эсэх, хүүхдээ монгол хүн болгож хүмүүжүүлэхийн учир, уламжлалт тоглоом наадгай, үлгэр домог, оньсого таавар, зүйр үг, дуу хөгжим хүүхдүүддээ зааж сургаж, хамт тоглодог эсэх, монгол хүнд байдаг/ байх ёстой/ хамгийн сайн сайхан чанар зэргийг тодруулан ярилцаж, ажиглалт, дүрсжүүлэлт хийлээ. Дор хэсэгт бид эдгээр асуудлуудын үр дүнг боловсруулж, задлан шинжлэх болно. Ингэхдээ зорилт тус бүрийг зүйлчлэн дугаарлаж, асуудлын хүрээнд сэдэвчлэн хэлэлцэж, дор бүр нь тулгамдсан асуудал, шалтгаан, үр дагавар, шийдэл гэсэн загварчлалаар дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

2.1. Хувийн соёл төлөвшүүлэх тухайд

Өдөр тутмын амьдралын хэмнэл

Иргэдийн өдөр тутмын амьдралын хэв маягийг боловсрол, орлогын түвшин, оршин суугаа газар орон, эрхлэх аж ахуй зэрэг уламжлалт хүчин зүйлүүд тодорхойлох нь зүйн хэрэг. Түүнээс гадна орчин үед *хөдөлгөөн* ба *хурд* амьдралын хэв маягийг тодорхойлох чухал хүчин зүйлсийн нэг болсон гэж болохоор байна. Тухайлбал, хот, хөдөөгийн соёлын ялгааг илэрхийлэх нэгэн гол үзүүлэлт нь энэ болж байна. Хотын иргэдийн сурч боловсрох, ажиллаж хөдөлмөрлөх, хүүхдээ хүмүүжүүлэх зэрэг соёлын боловсролын олон талт үйл ажиллагаа нь “замын хөдөлгөөний аясаар (хурдаар)” явдаг бол малчин иргэдийн амьдрал “малын аясаар” явдаг гэж болно.

Амьдралын хэвшлийн хувьд судалгаанд оролцогчдын унтаж амрах, ажиллаж хөдөлмөрлөх, чөлөөт цаг гарах хуваарь хот, хөдөөгөөр ялгарч байна. Жишээ нь, хот суурин газар оршин суугчид орой 23 цагт унтаж, 6-8 цагийн хооронд босдог. Хүүхэдтэй хүмүүс хүүхдээ сургууль, цэцэрлэгт нь хүргээд 9-18 цагийн хооронд ажиллах байдал түгээмэл байдаг. Улаанбаатар хотынхны хувьд өдөрт дунджаар 2-4 цагийг замын түгжрэлд өнгөрүүлдэг тул гэр бүл, чөлөөт цаг, амралт, хувь хүн өөрийн болон үр хүүхдийнхээ хөгжил, соёлын үйл амьдралд зарцуулах цаг нь тэр хэрээр багасдаг гэсэн нийтлэг дүр зураг ажиглагдаж байна. Оролцон ажиглалт болон ярилцлагаас үзвэл хүн байх оршин байх суурь үндэс болсон нойр, хоол, ажлын ачааллын тэнцвэр, зохистой түвшин зэрэг суурь асуудлуудад төдийлөн анхаарал хандуулдаггүй байдал хот, хөдөөгүй, орлогын түвшин зэрэг үзүүлэлтээс үл хамааран нийтлэг ажиглагдаж байна.

Харин аймаг, сумын төв, суурин газрын иргэд 18-цагаас хойш олонх нь гэр бүлтэйгээ цагийг өнгөрөөх байдал түгээмэл байна. Ажиглалтаас харахад хөдөөгийн малчин иргэдтэй харьцуулах юм бол орой унтах цаг нь нэлээд хожуу байна. Малчин өрхийн гишүүдийн орой унтах цаг нь ихэнхдээ 9 цагаар хязгаарлагдах бөгөөд өглөө хотын иргэдтэй харьцуулбал 5-6 цагт босдог байдал түгээмэл байна. Хавар мал төллөх үе бол малчдын хувьд оргил ачааллын үе байдаг. Тухайлбал, Ховд аймгийн Дарви сумын Хөшөөтийн уурхайн орчимд хаваржиж буй Б.Уламбаярын гэр бүл: “Өглөө эрт босож, зарим шөнө унтахгүй шахуу ажиллаж байна. Бүх зүйл малын аясаар явагддаг”³ хэмээн ярьсан. Түүнчлэн хөдөөд эрэгтэйчүүд нь гол төлөв адуу малд явах, хонь хариулах гэх мэт гадаад ажлыг амжуулдаг бол эхнэр нь гол төлөв хоол ундаа базаах, төл малаа маллах, хот хороогоо цэвэрлэх гэх мэт гэр зуур дотоод ажлыг хийдэг. Энэ уламжлалт хүйсийн ялгаанд тулгуурласан хөдөлмөрийн хуваарь зонхилж буйг харж болно.

Малчин өрхөд хийсэн судалгаанаас үзвэл монгол малчдын мал маллах, хэв маяг байгаль, цаг уурын байдлаас цэвэр хараат байдалтай, онолын хувьд “байгалийн эрхэнд” хэмээх тодорхойлолтод багтахуйц байна.⁴ Энэ нь эрчимжсэн мал аж, ахуйгаас эрс ялгаатай амьдралын хэв маягийг бий болгох нөхцөлийг бүрдүүлжээ. Хэдий тийм ч малчин өрхүүд хот, суурин газрын иргэдтэй харьцуулахад орлогын түвшин нь их бага ямар байлаа ч амьдралдаа сэтгэл хангалуун байдаг болох нь судалгаанаас харагдаж байна. Мөн чөлөөт цаг гэх мэт ойлголтын тухайд малчин өрхүүдийн хувьд чөлөөт цаг, соёл, урлагийн үйл ажиллагаанд хамрагдах, гадуур зугаалах, хооллох зэрэг ойлголт байхгүй. Соёлын үйлчилгээ авах, соёлын үйл ажиллагаанд оролцох боломж хомс байдаг.

Албан боловсрол ба гэр бүлийн орчин

Монголчууд эрдэм мэдлэгийг эрхэмлэн, эрдэмтэй хүнийг дээдэлж ирсэн уламжлал, социализмын үеийн албан боловсролын тогтолцоо, нийгмийн зохион байгуулал (сэхээтэн, ажилчин г.м.) зэрэг олон хүчин зүйлийн нөлөөтэйгөөр хүүхдийг албан боловсролд хамруулах, дээд боловсролтой болгохыг хүн бүр тэмүүлж ирсэн. Түүнчлэн албан боловсролд хамрагдах нь ядуурлыг бууруулах, нийгмийн тэгш бус байдлыг арилгах, улс орны эдийн засгийг сайжруулах гэх мэт олон эерэг нөлөөтэй тухай ойлголт

³ Ховд аймгийн Дарви сумын 3-р багийн малчин, 26 настай эрэгтэйтэй 2022 оны 03 дугаар сарын 13-нд хийсэн ярилцлагаас.

⁴ Гэхдээ төв суурин газарт ойрхон малчдын хувьд мал маллагааны хэрэгсэл, малчны амьдралын хэв маяг ихээр өөрчлөгдөж байгаа нь ч мөн харагдаж байна. Тухайлбал, машин, мотоциклоор малаа хариулдаг гэх мэт. Өөрөөр хэлбэл, үйлдвэрлэлийн юмуу эсвэл суурин газрын мал аж ахуйгаас илт өөр ч уламжлалт онцлог чанараа улам бүр алдаж байгаа нь тус асуултын ярилцлага дунд харагдаж байна гэсэн үг. Энэхүү өөрчлөлтөнд нь байгаль цаг уурын нөхцөлд зохицуулан, сүргийн бүтэц болон малын тоо толгойг зохистой байлгах олон улсын болон дотоодын төрийн бодлого ч бас нөлөөлж байгаа нь ажиглагдаж байгаа юм.

түгээмэл байдаг. Хэдий тийм ч энэ нь сургуульд хүүхдийн хүмүүжил, боловсрол, соёлтой бүх зүйлийг даатгах, боловсрол эзэмшсэн бол “соёлтой”, “хүмүүжилтэй” болно гэж ойлгох гэх мэт сөрөг хандлагыг бий болгосоор ирсэн. Цаашилбал хүүхдийг сургуульд явуулахтай холбоотойгоор малчин гэр бүлийн орчинд маш олон сөрөг үр дагавар гардаг нь эргээд гэр бүлийн ажил үүргийн хуваарь, өрхийн амьжиргаа, жендерийн тэнцвэргүй байдал, нийгэм, соёлын үнэт зүйлийн зөрчил гэх мэт олон зүйлд муу нөлөөтэй явж ирсэн. Бидний судалгааны сэдвийн хүрээнд гэр бүлийн орчин дахь хувь хүний соёл, хүмүүжилд сөрөг нөлөөтэй байгааг дурдахгүй өнгөрөх аргагүй.

Хүүхэд төв, суурин газар сургуульд сургахтай холбоотой малчин өрхийн дунд хэд хэдэн хэлбэрийн өөрчлөлт гарч байгааг судлаачид анзаарсан байна. Үүнд, нэгд, эхнэр хүүхдээ аваад сумын төв орж, гэр юм уу байшин авч, хичээлийн жилийн туршид тэндээ байрладаг. Энэ тохиолдолд аав нь гэртээ үлдэж, малаа хариулан өвөлждөг. Хоёрт, гэр бүлээрээ төв рүү нүүж, малаа ах дүү, хамаатан садандаа даатган үлдээдэг. Гуравт, дээрхийн адил гэр бүлээрээ нүүж, малчин гэрээгээр хөлсөлж, малаа харуулдаг. Дөрөвт, хүүхдээ найз нөхөд, хамаатан садандаа захиад, сургуулийн дотуур байранд оруулдаг (Ahearn & Bumochir 2016, 91). Энэ мэт албан боловсролд хамрагдах үйл явцаас үүдэлтэй гэр бүлд гарч буй өөрчлөлтүүд нь эргээд гэрийн хүмүүжил, хүүхдийг амьдрах ухаан, мал маллах аргад сургах соёлын боловсролыг алдагдуулж байна. Өөрөөр хэлбэл, энэ тохиолдолд албан боловсрол, хувь хүний хөгжил хоёр эсрэг хамааралтай болж, албан бус боловсрол алдагдаж байна гэсэн үг. Учир нь соёлын боловсрол гэдэг нь нийгэм, соёлын утгыг мөн давхар агуулж байдаг. Судлаач Марцлүф (2015) ч мөн социализмаас өмнөх гэрийн сургууль нь тоглоом наадгай, шүлэг найраг, дуу хуур, Төвд Монгол ном зохиол, угийн бичиг, зан үйл зэрэг албан бус сургууль, сургалтад тулгуурлаж байсныг онцолсон байдаг. Иймд албан бус боловсролын үнэлэмжийг нэмэгдүүлэх, тогтолцоог сайжруулах нь соёлын боловсролыг хүртээх чухал сувгийн нэг мөн.

Судалгааны хүрээнд хийсэн ганцаарчилсан ярилцлагаас:

“Охин хүүхдээ сургууль соёлд явуулна, хүү яах вэ өөрийгөө болгоод явна, малчин болно л гэдэг юм.” (Хэнтий Эрдэнэ сумын малчин Г.Уранбилэгтэй хийсэн ярилцлагаас)

“Хүүхэд шуухад бүгд сурахаар явсан, одоо нөхөр бид 2 л мал дээр байна. Ер нь тэгээд мал дээр байх хүн улам л ховордож байна даа.” (малчин С.Ариунжаргалын ярилцлагаас)

“Том охин Улаанбаатарт их сургуульд сурдаг, нэгдүгээр ангиасаа хойш нөхрийн эгчийнд сууж хотод сурсан, бага хүү эмээгийн хамт сумын төвд сууж сургуульд сурдаг,

нөхрийн хамт мал дээр байдаг” (Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Хужхан багийн малчин Ариунзаяагийн ярьснаар)

“Гурван хүүхдийн бага нь цэцэрлэгт орсон тул эхнэр бага хүүхдийн хамт суманд суух болсон, өнжөөд нэг адуу үхрээ эргэдэг, бог малаа дүүгийндээ тавьсан, тэгж байж гурвуул хамт байх нөхцөл бүрдүүлж байна. Том 2 хүүхэд 12, 11 анги хоёул ахлах сургуульгүйн улмаас Улаанбаатар хотод хамаатныд суудаг” (Мөн сумын төв дээр амьдардаг адуучин Ганбатын ярилцлагаас)

Зураглал 1а. ОРОН ГЭРИЙН ГАДААД ОРЧИН (МАЛЧИН ӨРХ)



*Баянхонгор аймаг. Жинст сум. Уулан баг.
Малчин өрх*



*Ховд аймаг. Дарви сум. Хөшөөтийн
уурхай. Малчин өрх*



*Баянхонгор аймаг. Өлзийт сум. Суурин. Хувийн
хэвшилд ажиллагч, малчин өрх*



Зураглал 16. ОРОН ГЭРИЙН ГАДААД БАЙДАЛ (ХАШАА БАЙШИН)



Ховд аймаг. Дарви сум. Сумын төв, 4-р баг
Мөнгөн аяга. Хувиараа бизнес эрхлэгч



Улаанбаатар хот. Баянзүрх дүүрэг, 20-р
хороо. Хувийн хэвшилд ажиллагч



Ховд аймаг. Ховд хот. 1-р баг. Магсаржав.
Их сургуулийн багш



Зураглал 1в. ОРОН ГЭРИЙН ГАДААД БАЙДАЛ (Нийтийн болон амины орон сууц)



*Баянхонгор аймаг. Баянхонгор хот.
Онцгой байдлын албан хаагчдын орон
сууц. Хувиараа бизнес эрхлэгч гэр бүл*



*Улаанбаатар хот. Хан уул дүүрэг 17-р
хороо "River Garden 2". Herbalife сүлжээ*



*Улаанбаатар хот. Сонгинохайрхан дүүрэг,
19-р хороо. Дунд сургуулийн багш.*



*Улаанбаатар хотын гэрийн хорооллын
төлөөлөл болох
СХД. 18-р хорооны оршин суугч
Нэргүйн гэр*



Зураглал 2. ӨРХ ГЭРИЙН АЖ АХУЙ



Баянхонгор аймаг. Баянхонгор хот. 4
одтой зочид буудал.



Ховд аймаг. Дарви сум. Сумын төв, 4-р баг Мөнгөн
аяга. Хувийн мал эмнэлгийн эмийн сан



Баянхонгор аймаг. Жинст сум. Уулан баг



Баянхонгор аймаг. Өлзийт сум. Суурин

Хувийн соёл төлөвшүүлэхийн бас нэг үндсэн хэсэг нь хүүхэд хүмүүжлийн асуудал юм. Улаанбаатар хотынхны хувьд хөдөлмөрийн насны эцэг эхчүүдийн хэн нэг нь албан ажил хийлгүйгээр зөвхөн хүүхдүүдээ сургууль, цэцэрлэгт нь зөөх ажлыг амжуулдаг. Хоёул ажиллаж буй тохиолдолд хүүхдүүдээ хувийн цэцэрлэг сургуульд өгдөг нийтлэг дүр зураг шинээр бий болжээ. Аймаг, сумын төвд төстэй хэв маяг ажиглагдах ч малчин өрхийн хувьд байдал эрс ялгаатай юм.

“Хоёулаа гадуур малын ажилтай үедээ хүүхдээ зууханд хүрэхгүйгээр уяж, орхидог. Тэгэхдээ миний хүү дуугай байж байгаарай л гэж хэлж үлдээдэг. Олон цагаар гадаа ажиллах тохиолдол бий. Хадам ээж ихэнхи тохиолдолд хүүхдүүд харахаар сумын төвд байдаг учраас хүүхдээ ганцаар орхихоос аргагүй үе олон байдаг.”

(Ховд аймгийн Дарви сумын 3-р багийн малчин, 26 настай эрэгтэйтэй 2022 оны 03 дугаар сарын 13-нд хийсэн ярилцлагаас)

Хүүхдийн хүмүүжлийг хот суурин газарт голдуу албан боловсролын байгууллага буюу цэцэрлэг, сургуульд даатгах нь түгээмэл байгаа бол хөдөө, орон нутагт эмээ, өвөөгийн хүмүүжил чухал хэмээн үзжээ. Хот ч, хөдөөд ч аль газарт хүүхдийн хүмүүжил, боловсролыг өнөөгийн хүүхэд хүмүүжүүлэх үндсэн орчин бол гэр бүлээс илүү “албан”, “орчин үеийн” гэгддэг боловсролын байгууллагад шилжсэн нь тодорхой харагдаж байгаа юм. Гэр бүлийн орчинд хүүхдийн төлөвшил, хүмүүжил, соёл, боловсрол олгох гол үүрэгтэй хүмүүс бол ээж, эмээ нар байдаг. Тэд хүүхдийг хүнлэг энэрэнгүй, ажилч, хөдөлмөрч, тусч, үнэнч байдал болон өөртөө итгэлтэй байдлыг хүүхдэдээ заахыг чухалчилдаг гэжээ. Хэдий тийм ч зааж сургах арга барилын хувьд “загнаж, үглэж”, “соц аргаар” гэх мэтчилэн хариулах нь элбэг. Мөн судалгаанд оролцогчид хүнд гай болохгүй байх, хамгийн чухал нь нэр бүтэн байх, олонд тустай байхын хичээх хэрэгтэй гэж үзжээ. Цөөхөн тохиолдолд өөрийгөө болон бусдыг хайрлах хамгийн чухал хэмээсэн байна.

Хувь хүний төлөвшлийн хувьд үнэт зүйл, ёс зүйн хэм хэмжээний зөрчил ажиглагдана. Үүнд Буддын шашны уламжлалт ёс зүйн хэм хэмжээ, өөрийн бие сэтгэлийг таних, бусдыг энэрэх, эд мөнгөнд шунахгүй гэх мэт ойлголтуудтай зэрэгцэн зах зээлийн нийгэм, иргэний нийгмийн үзэл санаа зэрэгцэн оршиж байна. Тухайлбал, эрүүл саруул, дутагдах гачигдах зүйлгүй амьдрах нь хүссэнээрээ амьдарч байгаа байдал гэж үзэх ч чухам хүссэнээрээ амьдрахад “мөнгө” л чухал байгаа тухай өгүүлнэ. Харин сэтгэл санаа, санхүүгийн дэмжлэг авах байдал нь өөрийн аав, ээж эсвэл төрсөн ах, эгч, нөхөр, эхнэр эсвэл үр хүүхэд (голдуу настай иргэд) гэсэн гэр бүлийн орчинд байх нь түгээмэл. Цөөн тохиолдолд нийгмийн ажилтан болон бусад хүнийг дурдсан байна.

Хувь хүний төлөвшил ба гэр бүл

“Өглөө 06 цагт босч, галаа түлнэ, цайгаа чанаж ууна. Гэрээс бараг гардаггүй. 6, 3-р ангийн охидоо сургуульд нь хүргэж өгдөг /5 сартай хүүхдээ тэврээд явдаг/. Сургууль хүртэл бараг 1 цаг шахам алхдаг. Бага охин орой 6 өнгөрөөж тарна, өвөл хэцүү, эрт харанхуй болоод нохойд уруулчих гээд. Тэгээд орой гэрт ирээд хоолоо хийнэ. Гэр орноо өөд нь татаж явах, арчаатай явахад л болно доо. 9-р ангийн 1 хүү, 6-р анги, 3-р ангийн 2 охин, бага охин 5 сартай ингээд тавуулаа амьдарч байна. Нөхөр маань элэгний өвчнөөр нас барсан. Хүнсний талон авдаг байсан, энэ өвөл хассан байна билээ. Хүүхдийн мөнгөнөөс өөр орлогогүй ээ. Хүнд хэцүү үед багийнхаа нийгмийн ажилтанд ханддаг. Ганц эгч маань байдаг боловч нэг их харж үздэггүй ээ...”

(Дорноговь аймгийн төвд оршин суух 43 настай өрх толгойлсон эмэгтэйтэй 2022 оны 3 дугаар сарын 4 нд хийсэн ярилцлагаас)

Тулгамдсан асуудал: Монгол хүний эрхэмлэн дээдэлбэл зохих үнэт зүйлсийн хоёрт тодорхойлсон “Монгол гэр бүл” буюу нийгэм, соёлын суурь нэгж болох өрх гэр нь хувь хүний төлөвшил, хүмүүжил, соёлын боловсролын үндэс суурь нь байдаг. Монгол улс социалист нийгмээс ардчилсан нийгэмд шилжих өнгөрсөн 30 жилийн хугацаанд хүний хөгжил, гэр бүлд хандсан цогц уялдаатай, залгамж халаатай бодлого явуулж чадаагүй. Энэ мэт алдаатай бодлого болон нийгмийн бусад олон хүчин зүйлсээс шалтгаалан гэр бүлийн бүрэн бүтэн байдал алдагдах болсон. Үүний дүнд гэр бүл нь соёлын боловсрол олгох үүргээ бүрэн гүйцэтгэж чадахгүй болсон.

Шалтгаан: Мөн “соёл”-ыг явцуу болон дайвар хүрээнд ойлгож ирсэнтэй холбоотойгоор өрх гэрийн хүрээнд соёлын боловсрол олгогдохгүй байна. Тухайлбал, соёл ба соёлын боловсрол гэдгийг соёл, урлагийн байгууллага, үйл ажиллагааны явцуу хүрээнд ойлгох, эс бөгөөс боловсролын дайвар мэтээр ойлгох (“сургууль соёл” г.м.) буюу шат шатны албан боловсролын байгууллагад сургаснаар соёлын боловсролыг авдаг мэтээр бүрэн даатгах байдал нийтлэг ажиглагддаг. Үүнийг зэрэгцээ боловсролын тогтолцооны доголдол, сургууль, цэцэрлэгийн хүртээмж, сургалтын хөтөлбөрийн чанар, багшийн ур чадвар муу зэрэг нь соёлын боловсролыг сургуулийн хүрээнд ч хангалттай авч чадахгүй байх шалтгаан болж байна. Гэр бүлийн бүрэн бүтэн байдал нийгмийн сэтгэл зүй, гэр бүлийн гишүүдийн аз жаргал, хүүхдийн хүмүүжил, төлөвшилд үзүүлэх үр нөлөөг дутуу үнэлдэг. Өрх гэрийн бүрэн бүтэн байдлаас илүүтээ амьжиргаа залгах, ахуй амьдралаа сайжруулах гэсэн материаллаг хэрэгцээг чухалчилдаг.

Үр дагавар: Хүний хөгжлийн суурь үе болох хүүхэд ахуй насандаа эцэг эхтэйгээ хамт өсөхгүй, гэр бүлийн соёлд суралцахгүй, гэр бүлийн орчинд хувь хүний хүмүүжил авахгүй, хүн байх, оршин байхын үнэ цэнийг мэдрэхгүй бүтэн үе бий болж байна. Үүнээс улбаалан эцэг эх, нутаг ус, ах захыг хайрлан хүндлэх зэрэг ёс суртахууны төлөвшлийн доголдол бий болж байна. Монголчуудын эрхэмлэн дээдлэх үнэт зүйлсэд багтах

уламжлалт “Монгол ёс суртахуун” буюу Монгол соёлын салшгүй хэсгийг үе дамжин өвлүүлэх уламжлал тасарч байна.

Шийдэл: Гэр бүлийн гишүүд алс хол суух, хөдөлмөрлөх, байнгын хөдөлгөөнд орших нь орчин үед зөвхөн Монголд болж байгаа үйл явц бус дэлхий нийтэд түгээмэл болсон үзэгдэл мөн. Хэдий тийм ч Монгол Улсын Засгийн газраас гэр бүл гэх үнэт зүйл, үүнийг бүрэн бүтэн байлгах нийгмийн суурь нөхцөлүүдийг бүрдүүлэхэд анхаарлаа хандуулах нь зүйтэй. Үүнд:

- Соёлын тухай хуулийн 11.2-д заасан “Хүүхэд өөрийн хүсэл, сонирхолд нийцсэн соёлын боловсрол эзэмших эрхтэй ба эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүүхдийн хүсэл, сонирхолд нийцүүлж соёлын боловсрол олгох үүрэгтэй” гэсэн заалтыг хэрэгжүүлэхэд анхаарах
- “Соёл” хийгээд “соёлын боловсрол” гэсэн ойлголтыг албан боловсролоос ялган ойлгуулах, таниулан түгээхэд анхаарах. Тухайлбал, зөвхөн сургуульд хамрагдсанаар соёлын боловсрол бүрэн эзэмших боломжгүйг ойлгуулах, гэр бүлийн гишүүдийн үүрэг оролцоог таниулах үйл ажиллагаа явуулах
- Гэр бүлийн хүрээнд эзэмшдэг соёлын боловсролын талууд буюу хувь хүний төлөвшил, хүмүүжил олгох гэр бүлийн гишүүдийн үүргийг ухуулан таниулах
- Хот, суурин газар болон хөдөөгийн малчдын ахуйн хэв маягийн онцлог, өдөр тутмын амьдралын хэмнэл, ялгаатай байдлыг тооцоолон тэдгээрт тохирсон хөтөлбөр, арга хэмжээг боловсруулах
- Малчдын хүүхдийг бага насандаа эцэг, эхтэйгээ хамт өсөх нөхцөл бололцоогоор хангах, багийн бага сургуулийн системийг орон даяар хэрэгжүүлэх, багийн бага сургуулийн багш нарыг бэлдэх.
- Гэр бүлийн хүмүүжил, хувь хүний төлөвшилд чиглэсэн албан бус боловсролын орон зай, үнэ цэн, арга хэлбэр, сургагч багшийг аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд бүрдүүлэн хөгжүүлэх
- Гэр бүлд чиглэсэн соёлын боловсролын үйл ажиллагааг сайжруулах, нэмэгдүүлэхэд анхаарах, үүнд, ээж, эмээд чиглэсэн хүүхэд хүмүүжүүлэх, ёс зүйн сэдэвт сургалт, үйл ажиллагаа, контент боловсруулах, цөм гэр бүлийн (эцэг, эх, хүүхэд) гишүүдэд чиглэсэн соёлын боловсролын үйл ажиллагааг дэмжих (музейн боловсролын хөтөлбөр, соёл, урлагийн байгууллагын үзвэр, үйлчилгээ г.м.)
- БШУЯ, ХНХЯ-тай хамтарсан “Гэр бүлийн орчин ба соёлын боловсрол” сэдэвт хөтөлбөр боловсруулах

Амьдралын хэмнэл ба чөлөөт цаг

Тулгамдсан асуудал: Өмнө дурдсанчлан иргэдийн амьдралын хэв маягийг тодорхойлох хүчин зүйлсийн нэг нь хөдөлгөөн, хурд болж байна. Хотын иргэдийн өдөр тутмын үйл ажиллагаа замын хөдөлгөөнөөс хамаарч байхад, малчин иргэдийн амьдрал малын аясаар тодорхойлогдоно. Энэ дунд ажил, амралтын тэнцвэртэй байдал, ажлын бүтээмж, сэтгэлзүйн тогтвортой байдал, нийгмийн харилцааг зохицуулах чухал хүчин зүйлсийн нэг болох чөлөөт цагийн соёлын ойлголт дутмаг, соёл-чөлөөт цагийн үйлчилгээ авах боломж хомс байдаг. Хот, хөдөөгийн иргэдийн дийлэнх нь чөлөөт цаг, хоббигоо хөгжүүлэх боломж хомс, өдөр тутмын амьжиргаагаа залгуулахад л бүх анхаарлаа хандуулдаг. Чөлөөт цагийн соёл нь хувь хүний хүмүүжлийн чухал хэсэг юм.

Шалтгаан: Соёлын талаарх бүх нийтийн ойлголт ерөнхийдөө төлөвшөөгүй тул соёл, чөлөөт цагийн үйл ажиллагааны ач холбогдлын талаарх ойлголт тун тааруу байдаг. Боловсролын байгууллагын хүртээмж муу, ачаалал ихтэй байдгаас албан боловсролын хөтөлбөрт анхаарлаа хандуулахаас биш хүүхдийн авьяас сонирхлыг хөгжүүлэх, хичээлээс гадуурх дугуйлан секц ажиллуулахад тэр бүр онцгойлон анхаардаггүй. Орон нутгийн соёлын үйлчилгээний төрөл, хэлбэр орчин үеийн хүний хэрэгцээ, сонирхлыг татдаггүй. Соёлын үйлчилгээ өрсөлдөхүйц сонголт нь байж чаддаггүй. Сумын соёлын төвийн шинэ байр байдаг ч үйл ажиллагаа тогтмол бус, хурал хуй, сонгуулийн сурталчилгаа явахаас хэтрэхгүй. Соёлын төвийн ажиллагсад мэргэжлийн бус, дээд сургууль төгссөн л бол ямар ч мэргэжлийн хамаагүй хүн тавьдаг. Төвөөс алслагдсан малчин өрхөд хүргэх соёл, урлагийн үйлчилгээ байхгүй. Жилдээ ганц удаа “Малчдын өдөрлөг”-өөр соёлын үйлчилгээ авдаг. Сурагчид авьяасыг нээн хөгжүүлэх дугуйлан сургалтад хамрагдах хүсэлтэй хэдий ч хөгжмийн зэмсэг худалдан авах санхүүгийн боломж байхгүй зэрэг олон шалтгаан байна.

Үр дагавар: Ажил амралтын тэнцвэртэй байдал алдагдаж, нийгмийн бухимдал нэмэгдэх, уур бухимдлаа бусдад гаргах, хорт зуршилтай болох, амьдралын чанар муудах зэрэг хор хөнөөлтэй. Цаашилбал сурч боловсрох, хөгжих сонирхолгүй, цахим орчин, дэлгэцийн хамаарал бүхий, бүтээлч бус хүмүүс олшроход хүрнэ.

Шийдэл: Чөлөөт цаг, соёлын үйл ажиллагааны үр өгөөж, үнэ цэнийг ойлгуулах, таниулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах, хот хөдөөгийн иргэдэд соёлын үйл ажиллагааг ойртуулахад анхааран ажиллах нь чухал. Үүнд:

- Орон нутгийн эрх баригчид болон энгийн иргэдийн чөлөөт цагийн соёлын талаарх ойлголтын түвшнийг дээшлүүлэх, соёлын хэрэгцээг бий болгоход анхаарах

- Аймаг, нийслэлийн соёлын газар, сум, дүүргийн соёлын төвийн үйл ажиллагааг Соёлын тухай хуулийн 25.1.1.-д заасны дагуу “иргэний соёлын эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлэх” үүргийг биелүүлэхэд анхаарах
- Аймаг сумын төвүүд дэх соёлын төвүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, тэдгээрийн эрхлэгч, ажилчдыг чадваржуулах, шаардлагатай мэргэжилтнээр хангах.
- Иргэдийн амьдралын хэв маягийг идэвхтэй бүтээлч болгох олон сонголтод соёл-чөлөөт цагийн үйл ажиллагаа зохион байгуулах,
- Соёлын ажлын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, үүний тулд соёлын ажилтнуудын мэргэжил, чадварыг дээшлүүлэх, сургах, соёлын төвд орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангах, цахим орчинд үйл ажиллагаагаа сурталчлах, хүнд хүрч ажиллах боломжоо нэмэгдүүлэх хэрэгтэй.

Эрүүл мэндийн боловсрол

Тулгамдсан асуудал: Бүх нийтийн эрүүл мэндийн боловсрол дутмаг, урьдчилан сэргийлэх үзлэгт ордог гэсэн хариулт цөөн.

Шалтгаан: Нийтлэг урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгооны ач холбогдлыг мэддэггүй. Ялангуяа малчдын хувьд урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах нөхцөл бололцоо, цаг зав гардаггүй

Шийдэл:

- Эрүүл ахуйн соёл, эрүүл мэндийн боловсролыг дэмжих тал даар ЭМЯ-тай хамтран ажиллах. Үүнд урьдчилан сэргийлэх үзлэгийн ач холбогдлыг таниулах.
- Түүнчлэн ЭМЯ, ХНХЯ-ны зүгээс малчдын урьдчилан сэргийлэх үзлэгийг тэдэнд хүргэх тал дээр цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

2.2. Монгол хүний хүмүүжил төлөвшил

Монгол соёл “хоймрын гоёл”

Энэ хэсэгт бид Монгол хүн болон хүмүүжин төлөвшихөд Монголын түүх, өв соёл, зан заншил, ёс уламжлалын ямар мэдлэгийг ямар арга хэлбэрээр хэрхэн авдгийг тодруулахыг зорьсон билээ. Өмнөх ижил төст судалгаа болон энэ судалгааны тоон болон чанарын судалгааны дүнд оролцогчдын олонх нь уламжлалт соёлын олон зүйлийг эрхэмлэн дээдэлдэг хэмээн хариулсан байдаг ч энэ удаад бид асуудлыг өөр өнцгөөс харахыг хичээлээ. 1990-ээд оноос хойш Монгол Улсын суурь үзэл санаа нь үндэсний үзэл болж (Munkh-Erdene 2008) үндэсний ухамсар, үндэсний соёлын сэргэлт эрчимтэй явагдсаны дүнд түүх, уламжлалт соёлын зүйлсийг оюуны суурь дархлаа, үнэт зүйл, хөгжлийн үндэс, сайхан амьдралын эх сурвалж хэмээн тодорхойлж, Соёлын тухай хууль болон бусад бодлогын бичиг баримтдаа дурдсаар ирсэн. Энэ нь өмнөх нийгэмд дарагдсан соёлын зүйлсийг сэргээх, даяаршлын давлагаа, гадаад соёлын нөлөөнөөс хамгаалах, үндэсний эв нэгдлийг хангах үндэс суурь болсон сайн талтай. Хэдий тийм ч улс төр, эдийн засгийн гадаад, дотоод хүчин зүйл, нийгэм, цаг үеийн өөрчлөлт, үнэт зүйлийн зөрчил, түүнчлэн төрөөс уламжлалт соёл, ёс заншлыг “үнэт зүйл” болгож, “эрхэмлэн, дээдлэх” чиглэлтэй бодлого хэрэгжихийн хэрээр уламжлалт соёлын зүйлс өдөр тутмын амьдралаас холдож, хэрэглээ хэлбэр нь өөрчлөгдөж байгаа нь ажиглагдаж байна. Жишээ нь, морин хуур, бурхан тахил, Чингис хааны хөрөг, Монголын нууц товчоо зохиол, монгол бичгийн уран бичлэгийн бэлэг дурсгал, мөнгөн аяга, домбо гэх мэт соёлын эд өлөг нь өдөр тутмын ердийн хэрэглээний зүйлс бус хоймрын гүнгэрваанд хадгалах, хананд өлгөх, гэрийн гоёл, тансаг хэрэглээний илэрхийлэл болж хувираад байна. Нөгөө талдаа уламжлалт хүнс боловсруулах технологи (тараг бүрэх, булууны ясны шөл гаргах, хүүхдээ бор хоолонд оруулах гэх мэт) нь орлогын түвшин өндөр хотын иргэдийн “тансаг хэрэглээ” болж байна гэж болно.

Харин уламжлалт соёлын хувьд биечлэн оролцдог, үйлддэг зүйлс нь баяр ёслол, тахилгын зан зүйл гэж болно. Үүнд, цагаан сарын баярыг ёс дэгийн дагуу тэмдэглэдэг, уул овоо тахих баярт оролцдог, цай сүүний дээжээ өргөдөг, шинийн 15-н хүртэл зул өргөдөг, мэндлэх хүндлэх ёсыг эрхэмлэдэг зэргээр ёс заншлаа дагадаг нь нийтлэг ажиглагдсан. Нэн ялангуяа орон нутгийн оршин суугчид нутгийн уул овоогоо шүтэх, тахих байдал түгээмэл байна.

Мөн уламжлалт албан бус буюу гэрийн сургуулийн онцлог нь ардын тоглоом наадгай, зүйр үг, зугаа үг, оньсого таавар, угийн бичиг зэргийг өдөр тутамдаа хэрэглүүлж, мөн чанарыг нь мэдрүүлж, ур чадвар суулгаж байсан. Тухайлбал, оньсого таавар гэхэд зүйрлэх, бэлгэдэх, сэтгэх бодох, гүйлгэн бодох зэрэг чадварт суралцахад оршихоос бус ном, сурах бичгээс бэлэн цээжлэхэд оршихгүй. Энэ мэтээр уламжлалт соёлын мөн чанар шилжиж, агуулга хэлбэр нь өөрчлөгдсөн. Өрх гэрийн орчинд түгээмэл байдаг уламжлалт тоглоом наадгайн зүйл нь шагайгаар л хязгаарлагдаж байна гэж болно.

“Хоол тэжээл, хүүхдийн асаргаа сувилгаа, уламжлалт аргаар бор хоолонд оруулах, тараг бүрэх, шүүх, шар сүүнээс салгах, ашигтай бактери, ааруул, сүүл, ясны шөл, адууны шөлөөр зутан хийх сургалтанд сууж Монгол хоол, ахуйн бүх юмаа сурсан. Барааны савангаар угаах, монгол тос хэрэглэдэг, шампунь, органик бүтээгдэхүүн хэрэглэдэг.”

(Улаанбаатар хотын Нүхтэд суух 42 настай эмэгтэйтэй 2022 оны 3 дугаар сарын 16-нд хийсэн ярилцлагаас)

Шагайн хэрэглээ нь цагаан сарын үеэр шагай няслах, морь уралдах, шагай шүүрэх зэргээр хязгаарлагдах болсон нийтлэг дүр зураг ажиглагдав. Аман тоглоом буюу оньсого таалцах, үлгэр ярих уламжлал алдагдаж байгаа ерөнхий дүр зураг байна. Мөн ерөөл, магтаал цол дуудах зэрэг нь өдөр тутмын амьдралаас улам холдон хөндийрсөн бөгөөд нутаг оронд цөөхөн тооны ерөөл магтаалч байдаг гэж ярьж байлаа. Малчдын хувьд өвлийн улиралд шагайнаас гадна монгол уламжлалт бус даалуу, хөзөр хааяа тоглодог байна.

Монгол эх орныхоо байгаль, соёл, үндэсний хувцас, монгол хүний тусч, цайлган сэтгэл, зочломтгой зан чанар монгол орны хамгийн бахархалт зүйл гэдэг нийтлэг саналтай байв. Тэрчлэн монгол хүнд байх ёстой хамгийн чухал занг гүндүүгүй байх, шударга байх, үнэнч байх гэж хариулсан байна.

“Нүүдэлчний амин сүнс нь газар юм, өөрийн гэсэн газартай байж эзэн сэтгэл төрж, эх нутагаа гэсэн сэтгэлтэй болно. Монгол хүний хамгийн чухал чанар, эцэг эхдээ хайр энэрэлтэй, газар нутгаа хайрладаг, нэг голынхондоо элэгтэй байх явдал буюу өөрөөр хэлбэл нутаг усныхантай амь нэг, нэг нэгнээ түшсэн халуун дулаан харьцаатай байх”

(Дорнод аймгийн Баянтүмэн сумын фермер Лхагвасүрэнтэй хийсэн ярилцлагаас)

Монгол хэл ба соёлын зөрчил

Монгол хэл бичгээ зааж сургахын гол зорилго бол Монгол хүн байх, Монгол улс байхын үндэс ба “Монгол хүн үндэсний ухамсартай байх нь чухал” гэж үзэх нь нийтлэг байна. Хэдий тийм ч монгол хэл, бичгээ хүндэтгэдэг, “мэдэж эзэмших ёстой зүйл” гэж үзэх болон өдөр тутмын хэрэглээ хооронд харилцан зааг ялгаа бий. Үүнд мөн л монгол бичгийг эрхэмлэн дээдэлбэл зохих зүйл мэт ойлгож, уран бичлэгийн бэлэг дурсгалын зүйл хадгалан өлгөхөөс цааш монгол бичгээр унших, бичих чадвар өдөр тутмын

“Нутаг орондоо ирж суурьшсанаас хойш 9 жилийн турш нөлөөллийн ажлыг хийж, үлгэр дуурилал болон, нүүдэлчин ахуй соёлд тохирсон багийн бага сургуулийн төсөл хөтөлбөрийг боловсруулж холбогдох зөвшөөрлүүдийг авснаар энэ 2022 оны хавраас эхний багийн бага сургууль байгуулах ажил Дорнод аймгийн Матад сумын 2 баг дээр эхлээд явж байна”

(Дорнод аймгийн Баянтүмэн сумын фермер Лхагвасүрэнтэй хийсэн яриллагаас)

хэрэглээнд хомс байна. Энэ нь хот, хөдөө, боловсролын түвшин, орлогын түвшин, эрхэлдэг аж ахуй зэргээс хамааран харилцан адилгүй байна. Тухайлбал, зарим хөдөө орон нутгийн оролцогчид: “Малын дансаа байнга хөтөлж бичдэг. Фейсбүүкт кириллээрээ бичдэг гэх мэтээр их анхаардаг даа.”⁵ гэх мэтээр хариулсан байхад Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын адуучин Ганбат дунд охин Пүрэвжаргалаа сумын сургуулийн дунд ангид байхад охины хамтаар монгол бичгийн “Гоо бичигтэн” тэмцээнд оролцон түрүүлж байсан тухайгаа ч дурсан ярьж байх жишээтэй. Судалгаанаас харахад малчин өрхүүд монгол хэлээр мэдээлэл авдаг бол боловсролын түвшин өндөр өрхүүд орос, англи, герман болон бусад хэлээр мэдлэг мэдээлэл авах тохиолдол байна. Тэрчлэн зарим малчдын хувьд хүүхдээ Монгол хүн болгож өсгөхөд анхаарах гол зүйл бол “хэдэн малаа л өсгөж байхад болно доо” гэх хандлагатай байна. Энэ нь тэдний амьдралын ахуй, хэв маяг нь хүүхдийг нь Монгол хүн болгож өсгөж чадна гэдэгт итгэж байгааг харуулж байна гэж үзэж болно.






Монгол хэлний хувьд хотын залуу иргэд, нэн ялангуяа орлогын түвшин өндөр өрхийн хүүхдүүд буюу хувийн сургуулийн сурагчдын хувьд анхаарал татсан асуудал болоод байна. Мөн гадаадад ажиллаж, сурч байгаад ирсэн гэр бүлийн хүүхдүүд өдөр тутам англи хэлээр харилцдаг нь эцэг эх, эмээ өвөөтэйгөө ойлголцох, цаашлаад нийгмийн харилцаанд сөрөг нөлөөтэй байна. Энэ зааг ялгааг арилгахад анхаарах, монгол хэлний хэрэглээг нэмэгдүүлэх, сургалт контентыг олшруулах шаардлага тулгамдсан асуудал болж байна.

“Би 16 настай, 9 настай 2 дүү, аав ээжийн хамт амьдардаг. Дүү нар зуны амралтаараа Сингапурт англи хэлний сургалтанд 3 удаа явсан. Гэр бүлийн харилцаанд англи хэлээрээ ярилцдаг. Ээж англи хэлээр сайн ойлгохгүйн улмаас үзэл бодол, сонирхол дээр тогтмол зөрчилддөг. Аав англи хэлтэй, бүх зүйлийг харилцан ярилцаж ойлголддог болохоор их амар байдаг. Аав ямар ч шүтлэггүй учраас бид нарыг лам, бурхан ярихад дургүй байдаг (шаардлагатай үед ээж аавд хэлэхгүйгээр лам дээр очиж ном засал хийлгэдэг). Монголоор ярихад үгийн баялаг муутай хэцүү, англи хэл нь амар. Манай аав их чөлөөт сэтгэлгээтэй хүн, Европ соёлыг эрхэмлэдэг. Мэдээ мэдээллийг YouTube, e-mail, Instagram, гадаад ТВ мэдээллээс авдаг, монгол тв үздэггүйдээ хэмээв.”

(Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг, Ривер Гарден хотхоны оршин суугч 29 настай Энхжинтэй хийсэн яриллагаас)

⁵ Дорноговь аймагт 37 настай эмэгтэйтэй хийсэн 2022 оны 02 сарын 26-нд хийсэн яриллагаас.

Зураглал 3. ӨРХ ГЭРИЙН ШҮТЭЭН

	<p>Баянхонгор хот. Хувиараа бизнес эрхлэгч. Бурхан тахил болон нутгийн чулуу</p>	
	<p>Дорноговь Эрдэнэ. Дөрвөлж баг. Малчин өрх. Шүтээн</p> <p>Баянхонгор аймаг. Өлзийт сум. Суурин. Бөөгийн эрхи</p>	
	<p>УБ. БЗД. 18-р хороо. Маникюрчин</p> <p>УБ. БЗД. 20-р хороо. Хувийн хэвшилд ажиллагч. Арвай буудай</p>	
	<p>Хэнтий. Цэнхэрмандал Малчин өрх. Бурхан шүтээн.</p> <p>ХУД 17-р хороо "River Garden 2</p>	



*Хэнтий.
Цэнхэрмандал.
Малчин өрх.
Бурхан
шүтээн.*

*УБ. БЗД. 2-р
хороо.
Маркетингийн
менежер*



Зураглал 4. ӨРХ ГЭРИЙГ ХАМГААЛАГЧ

	
<p><i>Баянхонгор аймаг. Баянхонгор хот. Хувиараа бизнес эрхлэгч. Тарни, Хөрөө</i></p>	<p><i>Ховд, Дарви, Хөшөөтийн уурхай. Малчин өрх. Хөрөө</i></p>
	
<p><i>УБ.СХД. Өрх толгойлсон эмэгтэй. Зарааны үс, Хонх</i></p>	<p><i>Баянхонгор, Өлзийт, Суурин. Малчин өрх. Сахиус</i></p>
	<p><i>УБ. СХД. 19-р хороо. Дунд сургуулийн багш. Навч</i></p>

Зураглал 5. ӨРХ ГЭРИЙН ДОТООД БАЙДАЛ

	<p>УБ. ХУД 17- р хороо “River Garden 2</p>	
	<p>Хэнтий. Цэнхэр- мандал. Малчин өрх.</p>	
	<p>Баянхон- гор аймаг. Баянхон- гор хот. Хувиараа бизнес эрхлэгч.</p>	

ДУГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Уламжлалт соёл ба хэрэглээ

Тулгамдсан асуудал 1: Өрх гэрийн орчинд Монгол соёлын зүйлс хүний үнэт зүйлс, бэлгэдэл, бэлэг дурсгалын төдий хойморт залдаг гоёл чимэглэл, үзмэрийн хэлбэрт шилжиж, өдөр тутмын амьдрал, хэрэглээнээс улам бүр шахагдаж байна. Тухайлбал, биет соёлын өвийг гэртээ залах, хадгалах, баяр ёслолын үед л ёслолын хэлбэрээр хэрэглэдэг, биет бус соёлын өвийг ТВ болон мэдээллийн хэрэгсэл, ном, сурах бичгээс уншиж харах төдийхнөөр хязгаарлаж байна. Түүнчлэн орлогын түвшин өндөр хүмүүсийн тансаг хэрэглээ, нийгмийн статусаа илэрхийлэх хэрэгсэл, бусдад харуулах хэрэгцээ шаардлага болж хувирсан байна. Харин орлого багатай өрхийн хувьд сурч эзэмших хүсэл байвч боломж бололцоо хомс байна. Жишээ нь, орон нутгийн сурагчид морин хуур сурах хүсэлтэй ч хөгжмийн зэмсэг, заах багш байхгүй тул сурах боломж байхгүй гэх мэт.

Шалтгаан: Монгол соёл уламжлал – Монгол үндэсний хувцас хэрэглэл зэрэг материаллаг эд зүйлс буюу биет өв гэж үзэх ойлголт нийгэмд түгээмэл ажиглагдаж байна. Төрөөс Монгол соёл, уламжлалыг сэргээх, дэмжих бодлого нь уламжлалт өв соёлыг “эрхэмлэн дээдэлбэл зохиолтой үнэт зүйл” байлгахад чиглэсэн байдаг (“Морин хуураа дээдлэн дэлгэрүүлэх тухай”, “Төрийн хан хуур залах тухай”, “Монголын нууц товчоог мөнхөд эрхэмлэн дээдлэх тухай” гэх мэт) нь өдөр тутамдаа эзэмших, хэрэглэх, хүртэх зүйл гэдэг ойлголтоос холдуулж байна. Түүнчлэн албан болон албан бус сургалтын орчин, нийтийн соёлын орчинд “мэргэжлийн ур чадвар”, “институцийн хэв загвар”, “үндэсний үзэл”, ном, сурах бичигт тулгуурласан хийсвэр, даган дуурайх сургалт давамгайлснаас бие даан суралцах, эзэмшин хөгжүүлэх боломжийг хаадаг.

Үр дагавар: Монгол ёс заншил, уламжлал улам бүр алдагдах, бэлгэ тэмдэг, хэлбэр төдий үлдэх, хойч үед уламжлахгүй, устан үгүй болох уршигтай.

Шийдэл: Үндэсний соёлын боловсролыг хот, хөдөө, өдөр тутмын амьдралын хэв загварт тохирсон ялгаатай бодлогоор зөвхөн ном, сурах бичгээс уншдаг, хоймортоо тахин хадгалдаг зүйл “үнэт зүйл”-ийн хэлбэрээс өдөр тутмын энгийн хэрэглээ болгох, хүүхдийн хүмүүжил төлөвшилд нэвтрүүлэх, хэрэглэх эзэмших боломжийг хангасан үйл ажиллагаа явуулах шаардлагатай. Үүнд:

- Албан болон албан бус боловсролын сургагч багш, боловсон хүчнийг энэ чиглэлд чадавхжуулах, хүүхдийн нас, сэтгэхүйн онцлог, аман зохиолын төрөл бүрийн онцлогт тохирсон сургалт, хөтөлбөр, уралдаан тэмцээн зохиох ажлыг дэмжих (Жишээ нь үлгэрийг номоос унших биш ярьдаг болгох, үлгэрийг дуурайн зохиодог болгох, ерөөл, магтаалыг өөрийн нь хэрэгцээ шаардлагад нийцүүлэн

амьдралд хэрэглүүлэх, дуурайн зохиодог болгох, оньсогыг номоос уншиж таах бус оньсого, хийсвэрлэх аргад суралцан өөрсдөө зохиох гэх мэт)

- Уламжлалт соёл, ёс заншлыг өнгөрсөн цагт байсан, мэргэжлийн ур чадвартай хүн эзэмшиж, “өв тээгч” болдог соёлыг халж, аль болох орчин үеийн сэдэв, хэрэглээ, хэрэгцээнд нийцүүлсэн бодлого, хөтөлбөр, контент боловсруулж, хэрэгжүүлэх
- Уламжлалт соёлын арга ухаан, технологийг орчин үеийн концепцтой хослуулсан сургалт, хөтөлбөр, контент боловсруулах, олон нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх. (Жишээ нь уламжлалт хоол хүнсний технологийг орчин үеийн “эрүүл хооллолт”, “экологийн цэвэр бүтээгдэхүүн”, тэжээллэг чанар (nutrition), “био хүнс” гэх мэт ойлголттой хослуулсан хэлбэрээр олон нийтэд таниулах гэх мэт.)
- Өрх гэрийн орчинд монгол ёс, зан заншил, соёлын өвийг тайлбарлан таниулах, дадал хэвшил болгоход чанартай цаг хугацаа гаргах чиглэлээр эцэг эхэд хандсан, хамтдаа хийх, турших боломжийг хангасан хөтөлбөр хэрэгжүүлэх, соёлын үйл ажиллагаа зохион байгуулах
- Уламжлалт соёлын өвийг мэргэшсэн, бэлтгэгдсэн хүн хийдэг гэхээс илүүтээ “хүн бүр соёлын тээгч” байх, турших, оролдох, сонирхол төрүүлэх, тээх хүсэл суулгах ажлыг бүх нийтэд чиглэн хийх

Тулгамдсан асуудал 2: Өрх гэр бүлийн хүрээнд уламжлалт тоглоом наадгайн зүйл дан ганц шагайгаар хязгаарлагдаж байна гэж болно. Гэртээ шагай хадгалдаг ч тоглох хэрэглэх нь мөн хязгаарлагдмал. Уламжлалт тоглоом наадгай нь хүүхэд хүмүүжүүлэх, гэр бүлийн гишүүд хамтдаа хөгжилдөх олон үүрэгтэй зүйл боловч уламжлалт тоглоом наадгайн хэрэглээ, орчин өөр зүйлд шилжиж, үгүй болсон байна.

Шалтгаан: Хүүхдийг хүмүүжүүлэх, хүүхдийг хөгжүүлэх тоглоом наадгайн талаарх эцэг эх, насанд хүрэгчдийн мэдлэг дутмаг. Уламжлалт тоглоом наадгай орчин үеийн хүүхдийн эрэлт хэрэгцээ, сонирхолд бүрэн нийцэхгүй, хангахгүй тэр үүргийг гар утас, компьютер тоглоом зэрэг бусад зүйлс гүйцэтгэж байна. Хотжилт болон техник технологийн хөгжлийг дагаад гадаа задгай орчин, байгальд тоглох тоглоом /чулуун тоглоом, хөдөлгөөнт тоглоом г.м./-ыг тоглохоо байснаар мартагдахад хүрсэн. Мэдэх, заах хүнгүй уламжлал тасрахад хүрч байна.

Үр дагавар: Төрөлх соёлоосоо хамгийн идэвхтэй суралцдаг бага насандаа уламжлалт тоглоом наадгайг гэр бүл болон боловсролын байгууллагын орчинд хангалттай сурч, мэдэж, өвлөж авч чадаагүйн улмаас дижитал орчинд цаг өнгөрүүлэх, ухаалаг гар утасны хэрэглээ нь хэтийдсэн, өөрийн соёлдоо ээнэгшээгүй, үндэсний соёлын ижилслийн мэдрэмж сул, гаднын соёлын нөлөөнд өртөмхий нэгэн үе гарч ирсэн.

Шийдэл: Уламжлалт тоглоом наадгайн төрлүүд болох аман тоглоом, хөдөлгөөнт тоглоом, чулуун тоглоом, хөлөгт тоглоом зэргийг залуу гэр бүл эцэг эхчүүдэд зааж сургах, хүүхдүүдэд хичээлээс гадуурх үйл ажиллагаа сургалт, дугуйлангийн хэлбэрээр зааж сургах өвлүүлэх, Соёлын төвд энэ чиглэлийн мэдлэг, мэдээлэл, ур чадвар олгох олон төрлийн арга хэмжээ зохион байгуулах. Нөгөө талаас цахим эрин үед уламжлалт тоглоом наадгайн утга санаа, дүр, дүрмийг харуулсан контент, цахим тоглоом зохиох, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх ингэснээр орчин цагийн хүүхэд багачуудад үндэсний уламжлалт тоглоом наадгайн тоглох ухаан, арга, технологийг өвлүүлэх боломжтой.

Монгол хэл ба харилцааны зөрчил

Тулгамдсан асуудал: Боловсролын тэгш бус байдал, орлогын түшингийн хэт ялгарал, дэлгэцийн хэт их хэрэглээ зэргээс үүдэлтэй бас нэгэн хямрал бол Монгол хэлний хэрэглээ юм. Нийслэл хот болон орон нутгийн хүүхдүүдийн хэл ярианы хөгжил, үгийн баялаг эрс ялгаатай байна. Нийслэлд хувийн сургуулийн сурагч хүүхдүүд англи хэлээр өдөр тутам ярилцдаг нь нийгмийн харилцаа төдийгүй гэр бүл дотор эцэг, эхтэйгээ харилцахад хүндрэл үүсэж байгааг ажиглаж болно.

Шалтгаан: Боловсролын системийн гажуудал, тэгш бус байдал, нийгмийн давхрааны хямрал, орлогын хэт ялгаатай түвшин, гадаад соёлын давамгайлал, Монголоор хэлээр хүүхдийн нас, сэтгэхүйн онцлог, сонирхолд нийцсэн контент хомс зэрэг олон хүчин зүйлсийн үр дүнд энэ байдал бий болсон. Эцэг эхийн хувьд гадаад хэлний ач холбогдлыг хэт үнэлэн, үндэсний хэлний үнэ цэнийг бууруулсан нийтлэг дүр зураг харагддаг. Мөн монгол соёл, ахуйгаас холдох тусам хэлний хэрэглээ, өдөр тутмын хэрэглээний үгсийн сан өөрчлөгдөх гэсэн хэлний зүйн шалтгаанууд бас бий.

Ур дагавар: Эх хэлээрээ өөрийгөө бүрэн илэрхийлэх чадваргүй, хэл ярианы баялаггүй, Монгол хэлний сэтгэхүйгээс холдсон үе өсөн торниж байна. Үүний дүнд нийгмийн бүлэг хоорондын ялгарал (хот- хөдөөгийн, “Зайсангийн”-хотын захын, улсын сургуулийн-хувийн сургуулийн г.м.) төдийгүй гэр бүл дотор эцэг эх, эмээ өвөөтэйгөө харилцахад бэрхшээл тулгарч үе хоорондын ялгарал улам ихсэж байна.

Шийдэл: Нас насны онцлог, сэтгэхүйд тохирсон, сонирхол татахуйц Монгол хэлээрх чанартай цахим болон бусад контентыг үйлдвэрлэх, хэлний үндэсний зөвлөл, хэл шинжлэлийн эрдэмтэд, контент үйлдвэрлэгч, маркетеруудтай хамтран бүх нийтийн хэлний хэрэглээнд хандсан Монгол хэлний хялбаршуулсан сургалт, хөтөлбөр, контент гаргах, компанит ажил зохион байгуулах.

ГУРАВДУГААР БҮЛЭГ: МЭДЭХИЙН ТУЛД СУРАЛЦАХ

Тус бүлэгт бид уг төслийн судалгааны гол судлагдахуун буюу соёлын боловсролын нэг гол ай болох “мэдэхийн тулд суралцах” хэсгийн судалгааны үр дүнг танилцуулах болно. “Мэдэхийн тулд суралцах” гэдэг бол НҮБ-аас тодорхойлсон соёлын боловсролын үндсэн дөрвөн зарчмын нэг бөгөөд ямар нэгэн нийгэм соёлын хүний зориудаар эзэмшиж буй мэдлэгийн төрөл зүйл юм. Үүнийг тодорхойлох хүрээг монгол хүний суралцах арга барил, танин мэдэхүйн онцлог, мэдээлэл авдаг суваг, хувь хүний хөгжил, насан туршийн боловсролын өнөөгийн байдлаар тодорхойлохыг зорьсон. Үүнд танин мэдэх, суралцах арга барилын онцлогийг тодруулахын тулд өдөр тутмын буюу мэдээлэл авдаг арга хэрэгсэл, чөлөөт цагийн соёлыг тодорхойлсон. Тухайлбал, хувь хүний өдөр тутамдаа мэдээлэл авдаг суваг, хэрэгсэл, өөрийгөө нээж хөгжүүлдэг байдал, чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлдэг байдал, сурч хөгжихдөө зориулдаг цаг, зав зэрэг асуудлыг өөр өөр амьдралын хэв маяг бүхий өрх гэрийн гишүүдээс судалгаа авч, ажиглан тодруулав.

4.1. Танин мэдэхүйн соёлд суралцах

Мэдээллийн хүчтэй урсгал бүхий хурдтай өөрчлөгдөн буй орчин үеийн соёлын хөгжлийн үед иргэдийн мэдлэг, мэдээлэл авах, танин мэдэх, хөгжих хэрэгцээ шаардлага газар зүйн байршил, оршин байгаа газрын онцлог зэргээс хамааран өөр өөрөөр хангагдаж байгаа нь судалгаанаас харагдана. Судалгаанд оролцогчдын насны байдлаас хамааран мэдээлэл авдаг хэл, агуулга, хэрэгсэл, суваг өөр өөр байна. Тухайлбал, судалгаанд оролцогчдын хувьд ялангуяа орлогын түвшин өндөр эсвэл залуу үеийн төлөөлөл мэдээ мэдээллийг англи юм уу өөр хэлээр авдаг гэсэн хариултыг өгсөн байх нь түгээмэл байна. Ерөнхийдөө оролцогчид орчин үеэ дагаад өөрчлөгдөх ёстой ч үндэсний соёлыг хамгаалах хэрэгтэй гэж үзэж байгаа юм. Мөн түүнчлэн судалгаанд оролцогчид хүүхдээ сонирхсон зүйлд нь сургах, хоббиг нь хөгжүүлэх, албан бус сургалтад хамрагдах цаг гаргахыг хичээдэг ч өмнөх бүлэгт өгүүлсэнчлэн замын түгжрэл саад болох нэг хүчин зүйл нь болдгийг олон хүн дурдсан. Өөрийн биедээ ч мөн адил.

“Хөдөө суманд сургалт дугуйлан бараг байхгүй. Хүүхдүүдээ сургаж, хөгжүүлмээр л байна. Манай суманд хүүхэд хөгжүүлэх зүйл маш дутагдалтай.”
(Дорноговь аймгийн Эрдэнэ сумын иргэн, 42 настай Мөнхтуяатай хийсэн ярилцлагаас)

Гэхдээ тэдний хариулт дундаас нэг сонирхолтой эсвэл түгээмэл байгаа зүйл нь орлогын түвшин өндөр байгаа хотын оршин суугчдын хувьд ажилдаа сэтгэл хангалуун, дуртай учраас төвлөрдөг гэсэн хариултыг бүгд өгсөн байсан. Малчин өрхийн болон аймаг, сумын төвийн иргэд өөрийгөө хөгжүүлэх сургалт, дугуйланд хамрагддаггүй, Ковид-19 гарахаас өмнө сумын төв дээр зохион байгуулагдсан ганц нэг хөдөлгөөнд

оролцсон байв. Үүнд шашны зан үйл, сонгуулийн сурталчилгааны хурал, хөдөлгөөн, тэмдэглэлт ойн арга хэмжээ үйл ажиллагаа нь нийгэм, соёлын амьдралд оролцох, бусдаас суралцах арга зам болдог нь харагдана. Малчин өрхүүдийн хувьд арьс, ширний юм уу мал аж ахуйн зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн сургалтад хамрагдах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн зүйл цөөнгүй байгаа нь мал аж ахуй үйлдвэрлэлийн талаасаа мах, ноос, ноолуураас бусдаар мал аж ахуйн үйлдвэрлэл хөгжихгүй, уламжлалт арга технологи тасарсныг илтгэж байгаа юм. Цаашилбал сум, орон нутагт хүүхэд хөгжүүлэх сургалт их хомс байна гэдгийг бүгд онцолжээ.

Харин хотын төвийн оролцогчдын хувьд хариулт олон талтай байна. Олонх нь үйлчилгээний сургалтууд болон гадаад хэлний, уран зураг, иог, мэргэжлийн зураг авах сургалт, магистрантурт суралцах (голдуу дунд сургуулийн багш нар) гэх мэтээр хариулж байна.

Чөлөөт цагийн соёл нь тодорхой мэдлэг, үнэт зүйл, хэм хэмжээний системийг эзэмших замаар бие хүн өөрийгөө хөгжүүлэхэд чиглэсэн бүтээлч идэвхтэй үйл ажиллагаагаар илрэх цагийг ашиглах чанарын түвшин юм. Эндээс авч үзвэл өнөөгийн монголын нийгэм соёлын орчинд иргэд, өрх гэрийн гишүүдийн чөлөөт цагийн тухай ойлголт, түүнийг бүтээлчээр ашиглах боломж, соёлын үнэт зүйлээс хүртэх эзэмших нөхцөл нь харилцан адилгүй байгаа нь судалгаанаас харагдана. Тухайлбал, төв суурин газрын иргэд, гэр бүлийн хувьд чөлөөт цагаа өөрийн сонирхсон зүйлдээ зориулах сонголт, боломж баялаг байхад хөдөө орон нутгийн иргэдийн хувьд хязгаарлагдмал, сонголт байхгүй, хүнд чиглэсэн чөлөөт цагийн үйл ажиллагаа, орчин нөхцөл хангалтгүй байна.

4.2. Мэдлэг мэдээлэл авах сувгууд

Нийслэл хот болон аймгийн төвийн өрхүүд юнивишн гурвалсан үйлчилгээтэй, малчдын хувьд 12 суваг гардаг телевизийн DDISH төхөөрөмжтэй, гол төлөв Үндэсний Телевиз, ТВ9 болон Малчин сувгаар мэдээлэл авдаг бол гар утасны сүлжээ орсон байршлуудад гэр интернэттэй.

Зурагтаар оройн мэдээ, ялангуяа орон нутгийн малчин иргэдийн үздэг гол нэвтрүүлэг нь “Монгол коммент” гэдгийг харж болно. Боловсролын түвшнээс хамааран цөөн нэг нь интернэтээр гадаад болон дотоод мэдээ мэдээллээ авдаг. Телеграмм аппликэйшн, BBC, CDF, IRD зэрэг сувгаас англи дээр үндсэн мэдээллээ авч, герман, орос монгол хэлээр харьцуулан нягталдаг гэсэн байна.

Малчдаас Дорнод, Баянтүмэн сумын фермер Л.Лхагвасүрэнгийнхээс бусад айлд ном байсангүй. Ном уншдаг эсэх талаар асуухад дийлэнх нь хүүхэд ахуйдаа уншдаг байсан ч

одоо уншдаггүй гэж хариулж байлаа. Аймаг, сумын төвийнхөн фейсбүүкээр сургалт авдаг, “Хөдөөгийн айл” влогоос маш их зүйл суралцдаг гэж байсан бол малчдын хувьд унших болон ямар нэгэн хэлбэрээр шинэ зүйлд суралцах зав байдаггүй, нутаг орныхон, нэг голынхон дундаа бие биеэсээ өдөр тутмын амьдралд хэрэгцээт зүйлсээ суралцдаг хандлага ажиглагдсан.

Судалгаанд оролцогч цэргийн юм уу эсвэл төрийн сүлжээний ажилтнуудаас бусад тохиолдолд иргэд огт хэвлэл захиалж уншдаггүй гэсэн байна. Зарим орон нутгийн оролцогчид сонгуулийн үеэр л сонин тараагдаж ирдэг гэсэн байна.

“Та өдөр тутмын сонин, хэвлэл захиалж уншдаг уу? гэхэд “Үгүй. Харин сонгуулийн үеэр тараасан сонин, сэтгүүлийг уншдаг.”

(Дорноговь аймгийн Сайншанд сумын иргэн, 43 настай Ариунжаргалтай хийсэн ярилцлагаас)

Мөн орон нутгийн оролцогчид радио бараг сонсдоггүй, эдгээр хуучны мэдээллийн хэрэгслийг огт хэрэглэхгүй болсон тухайгаа ярьж байсан бол нийслэлийн оролцогчдын хувьд замын хөдөлгөөнд оролцох, түгжрэх зуур ФМ радиог тогтмол сонсдог гэж хариулж байлаа. Гар утасны сүлжээтэй олонх нь сүүлийн үеийн мэдээллийн сувгуудыг ашигладаг гэсэн байна. Түгээмэл байдлаар өдөрт 3-4 цаг онлайнд өнгөрөөдөг тухай онцолж байна. FB, youtube, instagram гэх мэтийг хамгийн түгээмэл мэдээлэл хуваалцах хэрэгслээр дурдаж байна. Ихэнх оролцогчид өдөр тутмын мэдээллийг фейсбүүкээс тогтмол авдаг ба энэхүү аппликэйшний байнгын хэрэглэгчид байв. Орон нутагт аймаг, сумын төв, малчны хотонд ч мэдлэг болон мэдээлэл авах гол суваг нутаг усныхан нь бөгөөд амаас ам дамжиж ирсэн мэдээллээр танин мэдэхүйн хэрэгцээгээ хангадаг уламжлалт дүр зураг мөн ажиглагдаж байлаа. Энэхүү байдал нь албан ёсны мэдээллийн веб хуудас, ТВ сувгаас илүү Фейсбүүк түлхүү хэрэглэх гол шалтгаан гэж ажиглагдаж байна.

Дүгнэлт, зөвлөмж

Тулгамдсан асуудал: Ном хэвлэл, сонин сэтгүүл уншдаг иргэдийн тоо улам цөөрсөөр байна. Иргэд уншихаа больсон, танин мэдэхүйн соёлын түвшин буурсан, мэдээлэл авах эх сурвалж нь цахим орчин болсон. Чөлөөт цагийн соёлын төлөвшил, хөгжил хангалтгүй байна.

Шалтгаан: Сумын төвөөс алслагдсан малчдын хувьд тогтмол хэвлэл, сонин захиалах боломж хомс, номын сангаар үйлчлүүлэх боломжгүй, зөөврийн номын сан ажилладаггүй. Ном унших соёлд суралцаагүй, номын сангаар бараг үйлчлүүлдэггүй. Иргэдийн ерөнхий боловсролын түвшин доогуур байгаа нь унших үйлд нөлөөлж байна.

Уншлагыг дэмжсэн олон талт арга хэмжээг сумын соёлын төв, сургууль, цэцэрлэг хангалттай зохион байгуулдаггүй. Чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэх хүсэл эрмэлзэл байвч боломж нөхцөл хязгаарлагдмал.

Үр дагавар: Танин мэдэхүйн соёл, ерөнхий боловсрол, соёлын боловсролын чанар хүртээмжид сөргөөр нөлөөлнө. Амьдралын ялгаатай хэв маягтай хэдий ч ном уншихгүй байгаа нь нийтлэг дүр төрх болсон байна. Чөлөөт цагийн соёлын төлөвшил тааруу байгаа нь хөдөлмөрийн бүтээмжит, бүтээлч хүнийг төрүүлэхгүй байна.

Шийдэл:

- Уншихгүй бол сэтгэхгүй гэдэг тул уншиж байж танин мэдэхүйн соёлд суралцах тул унших үйлийг бүр бага балчраас нь өдөр тутмын үйл болгон хэвшүүлэхэд гэр бүл эцэг эхчүүд онцгойлон анхаарах хэрэгтэй.
- Уншлагыг дэмжсэн олон талт ажлыг зохион байгуулах. Номын сангийн үйл ажиллагаа, орчин нөхцөл, ялангуяа сургуулийн номын санг зөвхөн сурах бичиг тараадаг газар бус харин уншдаг, хөгждөг газар болгоход төрөөс бодлогоор чиглүүлэх шаардлагатай байна.
- Иргэдийн насан туршдаа, өдөр тутмын амьдралдаа танин мэдэхүйд тэмүүлдэг, ой санамж, сэтгэлгээгээ хөгжүүлдэг, аливаа сонирхон судлахыг тэмүүлдэг соёлыг бий болгоход анхаарах
- Алслагдсан баг, сумын малчин өрхөд зөөврийн номын сангаар үйлчлэх ажлыг тогтмол зохион байгуулах, цаашилбал үндэсний хэмжээнд уншдаг ард түмэн болох талаар цогц бодлого хэрэгжүүлснээр ном уншлагын соёл түгэн дэлгэрэх боломжтой юм.
- Төр, хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагын түншлэлээр (TomYo Edu Tech, Magic Vox, “Хөдөөгийн айл” контент г.м.) бэлэн жишиг загвараар хувь хүний хөгжил, бодол сэтгэлгээгээ хөгжүүлэх, танин мэдэхүйд суралцах чадварын тэгш хүртээх дэд бүтэц бий болгон хэрэгжүүлэх
- Хөдөө орон нутагт чөлөөт цагийн соёлыг хөгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ХИЙХИЙН ТУЛД СУРАЛЦАХ

Тус бүлэгт бид уг төслийн судалгааны гол судлагдахуун буюу соёлын боловсролын нэг гол ай болох “хийхийн тулд суралцах” хэсгийн судалгааны үр дүнг танилцуулах болно. “Хийхийн тулд суралцах” гэдэг бол НҮБ-аас тодорхойлсон соёлын боловсролын үндсэн дөрвөн зарчмын нэг юм. Энэ нь ямар нэгэн нийгэм соёлын хүний ямар нэгэн зүйл хийхийн тулд зориудаар эрэлхийлж эзэмшиж буй мэдлэгийн төрөл зүйл юм. Орчин цагийн мэдлэгийн эрин зуунд хүнээс зогсолтгүй хөгжих, шинийг эрэлхийлэх, бүтээлч санаачилга, ур чадвар бүхий иргэнийг төлөвшүүлэхэд соёлын боловсролын энэ асуудал ихээхэн чухал юм. Хот, хөдөөгийн гэр бүлийн орон зайд энэ чадавх хэрхэн хөгжиж буйг хийж бүтээх соёлд суралцахуй (гэр ахуй, аж амьдрал, соёл, урлаг, эрүүл мэндийн болон бусад боловсрол)-н соёлд хэрхэн суралцаж буйг тодруулахыг зорилоо. Үүнд гэр бүлийн хүрээнд ямар нэг зүйлийг өөрөө хийж, сурах ямар мэдлэг ур чадварт (цэцэг ногоо тарих, цахилгаан бараа засах, модоор урлах г.м.) суралцдаг эсэх, соёл урлаг, спортоор хичээллэдэг эсэх, бусдаас заавар зөвлөгөө авч хамтран бүтээдэг эсэх, зорилгодоо хүрэхийн төлөө хийдэг алхам, хүүхдээ энэхүү хийж бүтээх соёлд сургадаг арга зам зэрэг асуудлын хүрээнд нягталлаа. Өөрөөр хэлбэл, тус бүлэгт бид өдөр тутам гэр бүлийн хийхэд суралцах дадал, ямар мэдлэг, ур чадварт хэрхэн суралцдаг хэв маяг, нийгмийн харилцааны соёлд суралцах арга зам, саад бэрхшээлийг тодорхойлох зорилт тавьсан болно. Дор хэсэгт тэдний ярилцлагын үр дүнг дэлгэрүүлэн өгүүлэх болно.

4.1. Хийж бүтээх соёлд суралцах

Судалгаанаас харахад төв, орон нутгийн гэр бүлүүд нь гэртээ цэцэг тарих, цахилгаан бараа засах, модоор урлах, хатгамал (голдуу хөдөөгийн малчин) гэх мэтийг хийдэг гэсэн байна. Хөдөө орон нутгийн ялангуяа аймгийн төвийн эсвэл сумын төвийн иргэд бага хэмжээний гэр бүлийн тариалан эрхэлдэг тухай хариулсан байна. Энэ нь хотын төвийн оршин суугч болон бүр хөдөөд малчин өрх ийм бичил тариалан эрхлэх боломжгүйг харуулж байна. Малчин өрхүүдийн хувьд мэдээж мал аж ахуйн хамаатай гар үйлдвэрлэл хийж байгаага дурдаж байгаа ч улам бүр хүн малын харьцааг хөндийрүүлэх машин, техникийн нөлөөгөөр энэ байдал суларч байгаад харамсан ярих нь олон.

“Нөхөр хүүхдүүддээ дээл хувцас оёж хатгах зэргээр гэрийн ажлын хажуугаар шинэ соргог зүйлс сурчих юмсан гэж боддог, фэйсбүүк сургалтаас малчин малгай оёж сурсан ба нөхөр, бага хүүдээ хийж өгсөн тухайгаа ярьж байлаа. Хэд хэд туршин эсгүүрийг нь сайжруулж шинээр хийсэн”

(Хэнтий, Цэнхэрмандал сумын төвийн иргэн Цэнгэлтэй хийсэн ярилцлагаас)

Малчдын хувьд жилийн 4 улиралд нүүж, оторлох гэр бараагаа барихад бүрээсээ шинээр оёж засах, тугалын ногт оёж томох, ааруул цагаан идээгээ боловсруулах гэх мэт ахуй амьдралд шаардлагатай ажил хөдөлмөрийг хийдэг. Хэнтийн Цэнхэрмандал сумын малчин Ариунзаяа уламжлалт аргаар маш сайхан дээс томдог ба нутаг усныхан нь түүгээр дээс томуулж авдаг гэж ярьж байлаа. Дорноговь аймгийн өндөр настан Баяраа “Зарим өндөр настнууд эмнэг мал сургах, морь малын уналга эдэлгээ хэрэглээ муудаж, хүн мал хоорондын хүйн холбоо тасарч байна. Малчид техникээр малаа хариулж, малыг буян заяа гэхээсээ илүү зарж үрэх, амьжиргаанд залгуулах хэрэгсэл хэмээн үзэх болсон. Бэлэнчлэх сэтгэлгээтэй болж байна.” гэх мэтээр өгүүлжээ.

“Уламжлалт аргаар шир шүүлж, элдэж боловсруулсан сураараа чөдөр ногт зангиддагаас гадна уурга ташуур нааж урладаг, энэхүү уламжлал ихэд алдагдаж байгаа талаар, нутаг орныхондоо эдгээрийг хийж өгөх, зарим залуу үедээ зааж сургахыг хичээдэг ч зав хомс тул яг тулхтай сайн сурсан залуучууд ховор байна.”

(Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын адуучин Ганбаттай хийсэн ярилцлагаас)

Хөдөөгийн иргэдийн оролцсон соёл, урлагийн арга хэмжээ нь голдуу бүжиг, аялан тоглолтоор ирсэн хамтлаг дуучдын концерт зэргээр хязгаарлагдаж байна. Ялангуяа бидний судалгааны явцад Ковидын дараах хөл хорио тавигдсантай холбоотой хөдөө орон нутагт хийсэн олон тоглолтуудыг үзсэн тохиолдол түгээмэл байна. Энэ нь орлогогүй удаан суусан урлаг соёлынхны аялан тоглолт идэвхэжсэнтэй холбоотой олширсон боловч ердийн үед соёл, урлагийн арга хэмжээ төдийлөн элбэг биш байдаг байна.

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Бүтээлч чадвар ба шинэ санаачилга

Тулгамдсан асуудал: Гэр бүл, хүүхэд, иргэдийн бүтээлч санаачилгыг дэмжих соёлын орон зай боловсролын тогтолцоо, сургалтын орчин, гэр бүлийн хүрээнд хязгаарлагдмал. Өөрөө сэтгэж, шинээр бүтээхээс илүүтээ бэлэн зүйл хэрэглэх, бусдыг даган дуурайх дадал тогтсон.

Шалтгаан: Албан боловсролын сургалтын заах аргазүй, өнгөрсөн нийгмээс улбаатай “бэлэнчлэх сэтгэлгээ”, орчин үеийн хэтийдсэн хэрэглээ, технологийн дэвшил, дэлгэцийн хэт хэрэглээ зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж, хөдөлмөр хөнгөвчлөх, бэлэн бүтээгдэхүүн хэрэглэхийг илүүд үзэж бүтээлчээс сэтгэж, шинийг санаачлахад суралцах соёлын хомс байна.

Үр дагавар: Мэдлэгийн эрин зуунд хүний хөгжлийн гол тулгуурын нэг нь бүтээлч чадвар, шинэ санаачилга юм. Энэ чадварыг хөгжүүлэх, хөхиүлэн дэмжих соёлын дэд

бүтэц, орчин бүрдүүлэхгүй бол өрсөлдөх чадваргүй, идэвхгүй, сул дорой иргэд болж төлөвших болно.

Шийдэл:

- Бүх шатны албан боловсролын сургалтад бүтээлч санаачилгыг дэмжих заах аргагүйг нэвтрүүлэх, анги танхимаас гадуур хичээл явуулах боломжийг бүрдүүлэх, багш сурган хүмүүжүүлэгчдийг мэргэшүүлэн сургах
- Гэр бүлийн орчинд төрөл бүрийн ур чадварт суралцах платформ, контент, сургалт хөгжүүлэх орчныг бүрдүүлэх, дэмжих
- Хувийн хэвшил, ТББ-ууд, ХНХЯ-тай хамтран ажлын орчинд зөвхөн техник, мэргэжлийн сургалт бус багийн ажиллагаа, бүтээлч чадвар, шинэлэг санаачилга, бэрхшээлийг даван туулах чадвар суулгах сургалт зохион байгуулахыг дэмжих

Урлагийн боловсрол

Тулгамдсан асуудал: Урлагийн боловсролоор дамжуулж бүтээлч чадвар, олон нийттэй харилцах чадвар, багийн ажиллагаа, тэсвэр хатуужил зэрэг хувь хүний хөгжлийн олон чадварыг суулгах боломжтой. Гэтэл гэр бүл, хүүхэд залуус, иргэдийн урлагийн боловсрол хангалтгүй, урлагийн боловсрол эзэмших сувгууд хязгаарлагдмал байдгийн улмаас дээрх чадварт суралцах бас нэгэн боломж нь хаагдаж байна.

Шалтгаан: Сургууль, цэцэрлэгийн багш нарын урлаг, уран сайхны авьяас чадвар дутмаг учир хүүхдийн авьяасыг нээн илрүүлэх, хөгжүүлэх үйл ажиллагаа доголдсон. Боловсролын байгууллагын даац хэтэрсэн тул танхимын хичээлийн сургалтаас өөр дугуйлан секц явуулах боломж хомс. Соёл, урлагийн салбарын нийгмийн үнэлэмж муу тул эцэг эхчүүд хүүхдээ урлаг соёлын мэргэжилтэн болгохыг хүсдэггүй, авьяас сонирхлыг нь дэмждэггүй.

Үр дагавар: Урлаг, уран сайхан, бүтээлч сэтгэлгээ хомс, соёлын өвийг өвлөн уламжлах сонирхолгүй хүмүүс олширсон, соёлын өвийг өвлөн уламжлагчдыг дэмжсэн орон нутгийн бодлого, шийдвэр хангалтгүйн улмаас үнэлэмж буурсан.

Шийдэл:

- Сургуулийн өмнөх боловсролын багш нарыг их сургуульд элсүүлэхэд ур чадварын шалгалт авч тэнцүүлэх, авьяас чадварыг үнэлэх, сургуулийн хөгжмийн багш нарыг чадавхжуулах, сургууль цэцэрлэгт урлагийн дугуйлан тогтмол хичээллүүлэх.
- Соёл, урлагийн салбарын мэргэжилтэн, өвлөн уламжлагч нарын нийгмийн үнэлэмжийг дээшлүүлэх, авьяасыг үнэлэх, эдийн засгийн хангамжийг бүрдүүлэх.

ТАВДУГААР БҮЛЭГ: ХАМТДАА АМЬДРАХАД СУРАЛЦАХ

Тус бүлэгт бид уг төслийн судалгааны гол судлагдахуун болох соёлын боловсролын нэг гол ай болох “хамтдаа амьдрахад суралцах” тухай хэсгийн судалгааны үр дүнг танилцуулах болно. “Хамтдаа амьдрахад суралцах” гэдэг бол НҮБ-аас тодорхойлсон соёлын боловсролын үндсэн дөрвөн зарчмын нэг юм. Энэ нь ямар нэгэн нийгмийн бүлгийн гишүүн, улсын иргэн, үндэстний бүрдэл байхад суралцсан хувь хүний тухай юм. Бидний төслийн судалгааны хувьд энэ байдлыг Монгол улсын өөр өөр газарзүйн оронд амьдарч байгаа гэр бүлийн орон зайд хэрхэн өрнөж байгааг *нэгд*, хамтдаа амьдрах соёлд суралцах зорилтын дор нийгмийн харилцааны соёлд суралцах арга зам, саад бэрхшээлийг тодорхойлохыг зорьсон. Үүнд, нийгмийн харилцаанд учирч буй саад бэрхшээл, тэдгээрийн шалтгаан, нийгмийн бухимдал, ялгаварлан гадуурхал, сэтгэлзүйн төлөвшил, айл хөршийн харилцаа, харилцааны соёл, ур чадвар, хүүхдээ харилцааны соёлд сургах арга зам зэрэг асуудлын хүрээнд ажиглан судалсан. *Хоёрт*, байгаль орчинд ээлтэй амьдрах соёлд суралцах зорилт дор байгальд ээлтэй амьдрах арга замыг бүтээх үр дүнгийн төлөө иргэдийн байгаль цаг уурын өөрчлөлт, цөлжилт, бэлчээрийн доройтол, цэвэр усны хомсдол, орчны бохирдол, хог хаягдлын асуудал, хүн байгалийн хэмнэл, цаг ууртаа зохицон амьдрах, байгаль дэлхийгээ хайрлах, хувь хүний оролцоо, ирээдүй хойч, үр хүүхдэдээ байгаль дэлхийгээ унаган төрхөөр нь өвлүүлэх зэрэг асуудлыг анхааран судалсан болно. Дор хэсэгт бид дээрх хоёр бүлэг хэсэг судалгааны асуултыг задлан шинжлэх болно.

5.1.Хамтдаа амьдрах соёлд суралцах

Энэ асуудлын хүрээнд хотжилт, шилжилт хөдөлгөөн, нийгмийн өөрчлөлт, соёлын хэв маягийн ялгаа зэрэг олон хүчин зүйлсийн нөлөөгөөр нийгмийн харилцаа, хөршийн харилцаа, элгэмсэг зочломтгой байдал, харилцан хүндлэлд саад бэрхшээл тулгарч байдаг. Нийгмийн харилцаанд нутаг ус (аймаг сумын нутгийн зөвлөл г.м.), ах дүү, хамаатан садны холбоо хамаарал давамгайлж, үүнээс улбаатай ялгаварлал мөн оршиж байдаг. Үүнээс гадна социализмын үеэс улбаатай “бид”, “тэд”-ийн буюу “хотын, хөдөөгийн”, “хотын төвийн-захын” зааг ялгаа хэвээр үлдсэн байдаг. Хотын харилцаанд түр зуурын, ашиг сонирхолд тулгуурласан, богино хугацааны харилцаа давамгайлдгийг судлаачид тодорхойлсон байдаг. Харин орон нутгийн иргэд эсвэл малчдын хувьд эсрэгээрээ байгаа юм.

Өнөөгийн нийгэмд хамгийн тулгамдсан эсвэл бухимдал үүсгэдэг асуудлын тухайд замын түгжрэл, үнийн өсөлт, төрийн алдаатай бодлого зэргийг судалгаанд оролцогчид

дурдсан байна. “Төрөөс бусдыг л хүндэлдэг” гэж хүртэл хэлсэн. Хэдий тийм ч “боловсролгүй хүнийг харахаар уур хүрдэг”, “соёлгүй хүнийг харахаар бухимддаг” гэх мэтээр хүлээцтэй байх, бусдыг хүндлэх, ялгаварлан гадуурхахгүй байх зэрэг чанар дутмаг байгаа нь ажиглагдаж байна.

“...ажлын шаардлагаас ч амьдралын шаардлагаас ч байсан гаргасан бодлогууд нь ихэнх нь маш төвөгтэй байдаг. Амархан, хурдан шийдээд өгөх юман дээр маш их цаг алддаг. Зарим шийдвэрүүд нь арай хэтэрсэн зохимжгүй, энэрэнгүй бус байдаг. Ялангуяа хувиараа бизнес эрхэлсэн жижиг дунд үйлдвэртэй,компаниудтай хүмүүст үнэхээр хүнд байдаг...”

Улаанбаатар хотын ХУД-т оршин суугч 40 настай эрэгтэйтэй 2022 оны 2 дугаар сарын 29-нд

Монголын нийгэмд хамгийн дутагдаж буй зүйлийг хүн чанар гэж хариулсан байна.

“...Ирээдүй нь тодорхойгүй, хүмүүжилгүй хүүхдүүд их гарч ирж байгаа нь санаа их зовоодог. Боловсролгүй амьдралын түвшин доогуур хүмүүсийн дунд төрөлт их байна. Шалтгаан нь боловсролын систем, бүх түвшний багш сурган хүмүүжүүлэгч нар өөрсдөө боловсролгүй байна. Ялангуяа улсын иэцэрлэг сургуулиуд...”

Улаанбаатар хотын оршин суугч 32 настай эмэгтэйтэй 2022 оны 3 сарын 1нд хийсэн ярилцлагаас.

Та гадуурхалд өртөж байсан уу гэдэгт нэлээдгүй нь өртөж байсан гэж байгаа боловч тэгээд яадаг байсан бэ гэхээр “уйлдаг байсан” эсвэл “орхичихдог” байсан гэх хариулт түгээмэл байна. Тиймээс “гадуурхал” гэдгийг монголын нийгмийн харилцаанд хүмүүс тодорхой хүний эрхтэй холбож ойлгох байдал хараахан бүрэн төлөвшөөгүйг харуулж байх мэт. Энэ асуултад малчин өрхүүд өөр сумын нутагт нутаглаж байхдаа бэлчээрийн хамаатай гадуурхагдаж байсан тухайгаа өгүүлсэн байна.

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Нийгмийн харилцаа ба бусдыг хүлцэх

Тулгамдсан асуудал: Нийгэмд бусдыг хүлээн зөвшөөрөхгүй, ялгаварлан гадуурхах, уур бухимдлаа гаргах, эелдэг нөхөрсөг харилцаа дутмаг байгаа нь өдөр тутмын үйл ажиллагаа, гэр бүлийн орчинд ажиглагдаж байна.

Шалтгаан: Хотжилт, хүн амын нягтшил, шилжилт хөдөлгөөн, ажилгүйдэл, эдийн засгийн хямрал, нийгмийн тогтолцооны хямрал гэх мэт олон хүчин зүйлээс үүдэлтэй амин хувиа хичээх, хүн хүнээ хайрлахгүй, харилцан ойлголцож, хүндлэхгүй байдал үүссэн.

Үр дагавар: Хойч үед буруу үлгэр дуурайл үзүүлж, нийгэмд бусдыг үл хүлцдэг, үл хүндэлдэг, ялгаварлан гадуурхдаг иргэд төлөвших аюултай.

Шийдэл: Соёлын олон талт байдлыг таниулах, харилцан хүндлэх, ойлголцох, хүлцэн тэвчих байдлыг нэвтрүүлэх зорилготой олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах шаардлагатай. Үүнд:

- Соёлын ялгаатай байдал, ялгаатай байдлын эерэг үнэ цэн, соёлын ялгаатай байдлыг хүндлэх, хүлцэх, ялгаварлан гадуурхахгүй байхад чиглэсэн сургалт, хөтөлбөр боловсруулах, багш мэргэжилтнийг сургах, заах аргазүйг сайжруулах
- Хүний эрх, эрхэм чанар, жендерийн тэнцвэртэй байдал, халдашгүй байдал зэрэг нийгмийн үнэт зүйлийн ойлголтыг таниулах, хэвшүүлэх хөтөлбөр, цахим контент бүтээх, нэвтрүүлэх
- Буддын шашны ёс зүйн сургаалыг иргэний шинжтэй, хялбаршуулсан хэлбэрээр олон нийтэд таниулах цахим контентыг дэмжих, уралдаан тэмцээн зохион байгуулах
- Хүн бүрийн соёлын ялгаа, амьдралын хэв маяг, үндэс угсаа, угсаа гарвалийг хүндэтгэх, ойлгох, хот, хөдөө, улсын хувийн сургууль хоорондын багш, оюутан, мэргэжилтэн хоорондын соёлын солилцоог хөхиүлэн дэмжих

5.2. Байгаль орчинд ээлтэй амьдрах соёлд суралцах

Байгаль орчны бохирдол, цөлжилт, шороон шуурга, ган, зуд, бэлчээрийн доройтол, хог хаягдал зэрэг асуудал өнөөгийн нийгэмд тулгамдаж буй хамгийн хурц асуудал мөн болох нь судалгаанаас харагдаж байна. Байгалийн эрхшээл, малын аясаар амьдардаг хөдөөгийн малчдад цаг уурын өөрчлөлт, усны хомсдол, байгалийн давагдашгүй хүчин зүйлс ихээхэн нөлөөлж байна. Мөн судалгааны тус хэсэгт багтаж байгаа нэг гол агуулга бол амьдралын хэмнэлттэй хэв маяг, байгаль дэлхийгээ хамгаалах, хэрэглээгээ хянах, ус, тогоо хэмнэх зэрэг асуудлыг хөндсөн. Байгаль дэлхийг хайрлах ёстойг бүх л оролцогчид өгүүлж байгаа ч өдөр тутмын амьдралд хэрэгжүүлэх нь дутмаг. Сум, аймгийн төвд хогоо бараг ангилдаггүй, бөөнд нь л хогийн саванд хийдэг, малчид бол хогоо ангилдаг, шатааж болохоор хогийг шатааж, шил савыг нь сумын төвийн нэгдсэн хогийн цэгт аваачиж хаядаг.

“наад зах нь хаврын шороон шуурганд гэр нурдаг, мал урууддаг, үхдэг, зун нь хур бороогүй хэт халах, ус ховор, бэлчээр хомсдож байнга оторлодог болсон. Ийм сорилт бэрхиээлээс болоод залуучууд хөдөө мал маллахаа больж байна. Хижээл дунд насныхан л мал дээр байна”

(Дорноговь аймгийн Баянтүмэн сумын малчны ярилцлагаас)

“Цөлжилт, бэлчээрийн доройтол малчдын амьдралд маш хүчтэй нөлөө үзүүлж байна гэсэн нийтлэг дүр зураг ажиглагдаж, зарим аймгуудад энэ асуудлаас болж нутаг сэлгэн нүүдэллэх, оторлох шаардлага урган гарах болсон. Малын тоо толгой, сүргийн бүтцийн зохист хэмжээ алдагдсан ба үе үе нутгаар нь 1000-2000 толгой адуун сүрэг оторлон өнгөрдөг ба үүний улмаас бод малын хөлд өртсөн бэлчээр газар дараах 2-3 жилдээ сэргэдэггүй. Эдгээр их сүргийн хөлд өвөлжөө, хаваржаагаа дайруулсан малчид хэдэн жил дарааллан өөр сум, аймаг дамжин оторлохоос өөр аргагүйд хүрдэг”

(Дорнод аймгийн Баянтүмэн сумын фермер Лхагвасүрэн болон Хэрлэн сумын иргэн Хэнмэдэх нартай хийсэн ярилцлагын хэсгээс)

Үүнтэй зэрэгцэн мэдлэг мэдээлэлтэй, байгаль орчноо хамгаалах гэсэн, хогоо сул хаяхгүй байх, мод тарих гэх мэтээр тэмцэж байгаа сайн жишээ ч мэр сэр ажиглагдана.

“...Орчны бохирдол бол нийслэлийг бүхэлд нь хамарсан. Агаар, хөрсний бохирдол ихсэж, халдварт өвчин, архаг бронхит, суурь өвчлөл ихсэж эрүүл мэндийн асуудал 1-рт яригдах ёстой. Эдгээрийг бууруулахад хувь хүн бүр соёлтой, боловсон ухамсартай байх хэрэгтэй байна. Гэр хорооллыг зохион байгуулалттайгаар эко жорлонтой болгох төсөл санаачлагуудыг төрөөс дэмжин, хамтран үр бүтээлтэй ажиллах хэрэгтэй”

(Улаанбаатар хотын ХУД-т оршин суугч 40 настай эрэгтэйтэй 2022 оны 2 дугаар сарын 29-нд хийсэн ярилцлагаас)

“Байгальтай ойрхон байхаар цаг уурын өөрчлөлт, цөлжилт нүдэн дээр яаж эрчимтэй явагдаж байгааг харагдаж байна. Саяхан ШУА-н бэлчээрийн доройтлыг тэглэх төсөлд зориулж хэдэн нийтлэл бичих гээд судалж байхдаа Монгол улс минь ямар хэцүү нөхцөлд байгааг улам мэдсэн. Монгол улс бол тал хээрийн бүс нутаг учир мод тарих гэхээс илүүгээр хөрсийг сайтар хамгаалах хэрэгтэй. Хөрс бол хэдхэн см зузаантай яг л хүүхдийн зулай шиг нимгэн. Тийм учраас надад хамаагүй гэж хэн ч бодох ёсгүй хүн бүр дор дорноо хичээх хэрэгтэй. Ядаж л зун ширэг зүлгэн дээр машины дугуйн мөр гаргахгүй байх. Хөдөө зугаалгаар явахдаа хогоо аваад явах нь л эх оронч үзлийн нэн тэргүүний шаардлага болно. Байгаа байгаа орчноо л цэвэрхэн байлгахад болно”.

(Улаанбаатар хотын БЗД II хорооны иргэн Энх-Оюуны ярилцлагаас)

Гэвч байгаль хамгаалах үйлс гэхээр өдөр тутмын амьдралдаа дадал болгосон иргэд ховор, харин гадаа орчны их цэвэрлэгээ хийх, гал түймэр унтраах, оготно устгах, хогоо ил задгай хаяхгүй байх, мод тарих аянд нэгдэх зэргээр оролцдог зэргээр хязгаарлагддаг нь нийтлэг ажиглагдаж байлаа.

Зураглал 6. ӨРХ ГЭРИЙН ХООЛ ХҮНС

	<p>УБ. БЗД. 2-р хороо. Маркетингийн менежерийн гэр бүл</p> <p>Дорноговь, Сайншанд Өрх толгойлсон эмэгтэй</p>	
	<p>УБ. СХД. 19-р хороо. Дунд сургуулийн багшийн гэр бүл</p> <p>Дорноговь, Сайншанд Төрийн албан хаагчийн гэр бүл</p>	
	<p>Дорноговь Эрдэнэ Дөрвөлж баг. Малчин өрх.</p> <p>УБ. БЗД. 20-р хороо. Хувийн хэвшилд ажиллагч.</p>	



Баянхонгор.
Жинст.
Уулан малчин
өрх.

Баянхонгор
аймаг.
Өлзийт сум.
Суурин.
малчин өрх.




Зураглал 7. ӨРХ ГЭРИЙН ЗОЧНЫ ШИРЭЭ



ХУД,
Нүхт
хотхон.
Хувиараа
бизнес
эрхлэгч

ХУД, 17-р
хороо
"River
Garden 2



СХД, 41-р
хороо.
Өрх
толгойлсо
н
эмэгтэй.

Ховд.
Дарви. 4-р
баг.
Хувиараа
бизнес
эрхлэгч.





Баянхонго
р аймаг.
Өлзийт
сум.
Суурин.

УБ. БЗД.
20-р
хороо.
Хувийн
хэвшилд
ажиллагч



Баянхонго
р. Жинст.
Уулан баг.
Малчин
өрх

Ховд.
Дарви.
Хөшөөтийн
уурхай.
Малчин
өрх



УБ. БЗД.
18-р
хороо.
Маникюрчин

Дорноговь
аймаг.
Малчин
өрх



ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Байгаль орчны өөрчлөлтийн ба олон нийтийн мэдлэг

Тулгамдсан асуудал: Байгаль орчны бохирдол, дэлхийн дулаарал, хэмнэлттэй амьдралын хэв маяг, байгалийн хийн хэрэглээ, карбон ул мөр зэрэг дэлхий нийтэд тулгамдаад байгаа асуудлын талаарх ойлголт, мэдлэг ард иргэдийн дунд дутмаг, амьдралын хэвшил болж нэвтрээгүй байна. Байгаль орчин хамгаалах үйлсэд хүн бүрийн оролцоо, өдөр тутмын амьдралын хэв маягийн дадал зуршлуудын ач холбогдлыг дутуу үнэлэх явдал.

Шалтгаан: Иргэдийн амьжиргааны түвшин, боловсролын түвшин, социализмын үеийн хэмнэлтгүй хэрэглээ, дадал зуршил, бэлэнчлэх сэтгэлгээ, байгальд ээлтэй дэд бүтцийн хөгжөөгүй зэрэг олон шалтгаанаас үүдэлтэй.

Үр дагавар: Байгаль орчинд ээлгүй, хэт их хэрэглээтэй, хэмнэлтгүй амьдралын хэв маяг, дадал зуршилтай нийгмийн гишүүд, иргэд төлөвшсөнөөр усны хомсдол, орчны бохирдол, байгалийн эх үүсвэрийн хомсдол, иргэдийн эрүүл мэндэд муугаар нөлөөлөх уршигтай. Цөлжилт, цаг уурын өөрчлөлт, усны хомсдол, бэлчээрийн доройтол зэрэг асуудлууд улам бүр даамжрах. Байгаль хүний хүйн холбоог эрхэмлэдэг монгол сэтгэлгээний хэв маяг алдагдах.

Шийдэл: Байгаль орчны тухай мэдлэг мэдээлэл бүхий байгальд ээлтэй, хэмнэлтэд хэрэглээ бүхий иргэн төлөвшүүлэх соёлын суурь бүрдүүлэх бодлого, арга хэмжээ авах.

Үүнд:

- Байгаль орчны яам, Экологийн цагдаагийн алба зэрэг холбогдох газруудтай хамтарсан Экологийн боловсрол, Эко соёлыг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх. Ялангуяа хот суурин газрын иргэдэд өдөр тутамд ус болон цахилгаанаа хэмнэх, хогоо хаягдлаа багасгах, ангилах зэрэг дадал зуршлуудыг олон нийтэд суулгах хамтран олон нийтэд нөлөөлөх үйл ажиллагаа, компанит ажил зохион байгуулах
- Хогоо ангилан ялгах, дахин хэрэглэх, дахиварт өгөх, органик хогийг бордоо болгон ашиглах, хоолны хаягдал бага гаргах, тог цахилгаан хэмнэх, ус хэмнэх, гялгар уут, хуванцрын хэрэглээг хянах зэрэг хэвшил дадал, соёл хэвшүүлэх, таниулан сурталчлах арга хэмжээ авах
- Уламжлалт байгаль хамгаалах зан заншил ёс уламжлалыг сэргээх.
- Нүүрсний хэрэглээ, карбон ул мөр, байгалийн хийн хэрэглээний тухай мэдлэг, мэдээлэл олгох, олон нийтэд нөлөөлөх үйл ажиллагааг инфлюсер, цахим орчин, нийгмийн сүлжээгээр түгээх

- Албан болон албан бус сургалтад энэ талын мэдлэг олгох хөтөлбөр хэрэгжүүлэхийг дэмжих

Цаг уурын өөрчлөлт ба уламжлалт соёлын хэв маяг

Түлгэмдсан асуудал: Цөлжилт, байгалийн сорилт бэрхшээл нь малчин ахуй, соёлын залгамж үе бий болгох, залуу үеийнхэн малчин болоход сөргөөр нөлөөлж эхэлсэн. Энэ нь гэр бүлийн байдал, жендерийн тэнцвэргүй байдлыг бий болгох нөхцөл болдог.

Шалтгаан: Малчин байх хөдөлмөр, үйл ажиллагаа нь сорилт бэрхшээл ихтэй тул залуус орчин үеийн амьдралын хэв маягт малчин болохоос халгах болсон. Малчдын нийгмийн баталгаа хангалтгүй, амьжиргааны эх үүсвэр нь байгаль, цаг уураас шууд хамааралтай тул эрсдэл ихтэй. Нэг зуны ган, нэг өвлийн зуднаар амьжиргааны эх үүсвэргүй болох магадлалтай. Гэр бүлийн асуудалд сөргөөр нөлөөлдөг. Тухайлбал, хөдөө гарсан малчин залуучуудад эхнэр олддоггүй, малчдын охид их, дээд сургуульд сурахаар яваад эргэж ирдэггүй. Иймд залуучууд найз охин, эхнэрээ даган төвд суурьшиж байна.

Үр дагавар: Монголын уламжлалт ахуй соёлын эх үүсвэр болсон нүүдлийн мал аж ахуй устан үгүй болох, мал эзгүйдэх, өв соёл мартагдахад хүрнэ.

Шийдэл: Малчдын нийгмийн баталгааг хангах, залуу малчдыг дэмжих, гэр бүл төлөвлөлтийг зохицуулах замаар малчин ахуй, өв соёлыг хадгалж, хамгаалах, өвлүүлэн уламжлуулах боломж бүрдэнэ. Мөн говь нутгийн байгаль, цаг уур, бэлчээр, усны менежментийг сайжруулах эрс шинэчлэл хэрэгтэй байна. Сүргийн бүтэц, тоо хэмжээг зохист хэмжээнд барих, бэлчээр сэлгэлт зохицуулалтын уламжлалт өв ухааныг сэргээн, залуу малчдад уламжлуулах.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

“Амьдралын хэв маяг ба соёлын боловсролын ялгаа” сэдэвт энэхүү чанарын судалгааны хүрээнд а) Улаанбаатар хот болон Баруун, Зүүн, Төвийн бүсийн төлөөллийг хамарсан нийт 34 өрхийн 60-аад хүнээс ганцаарчилсан ярилцлага хийж, б) соёл, боловсролын салбарын бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшинд ажиллаж байсан хүмүүс болон эксперт мэргэжилтнүүдийн дунд фокус бүлгийн уулзалт, в) соёл, урлагийн байгууллага, боловсролын байгууллага, хилийн чанадад амьдарч байгаа монгол иргэдэд монгол хэл, соёлын боловсрол олгож байгаа багш нарын төлөөллийг хамруулсан эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг зохион байгуулж дүн шинжилгээ хийлээ. Судалгааны үр дүнг бүхэлд нь амьдралын хэв маяг, соёл, боловсрол гэсэн гурван томоохон сэдэв, концепцын хүрээнд дүгнэн тайлбарлах боломжтой. Эдгээр нь хоорондоо холбоотой ч тус тусын онцлог, судлах онол, аргазүйн зарчимтай билээ. Уг судалгааны хүрээнд “Бүх нийтийн соёлын боловсрол”-ын арга хэмжээнд холбогдох үзэл баримтлалыг боловсруулах зорилготой уялдуулан амьдралын хэв маягийн ялгаатай байдлын зураглал, тэдгээр нь соёлын боловсролын хүртээмжид хэрхэн нөлөөлж буй талаас нь холбон дүн шинжилгээ хийсэн болно. Үүнд, *нэгд*, Монгол Улсын өрх гэр, хувь хүний өдөр тутмын ахуйн хэв маягийн олон янз байдлын ерөнхий зураглал, онцлог дүр төрхийн нарийвчилсан дүрслэл тодорхой болгоно; *хоёрт*, хотын болон орон нутгийн төлөөллөөр соёлын боловсролын ялгарах хүрээ, суурь шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлсийг тодруулах зорилго тавьсан билээ.

Амьдралын хэв маягийн зураглал

Өнөөгийн монголчуудын амьдралын хэв маяг нь “хотын төвийн-хотын захын”, “сумын төвийн”, “хөдөөгийн” гэх мэт байршлын ялгаанаас гадна бизнесмен, малчин, нинжа, тариачин, уурхайчин гэх мэт байнгын болон түр зуурын ажил мэргэжлээр ялгарах олон талт хэв шинжтэй ажээ. Хэдий тийм ч энэ нь “баян-ядуу”, “сэхээтэн-ажилчин”, “хот-хөдөө” гэх мэтээр хувьслын онолын суурьтай эсвэл социализмаас улбаатай ангилал гэхээсээ хүмүүсийн өдөр тутмын амьдрал, дадал хэвшил, сонирхол таашаал, мэдлэг боловсрол зэрэг олон хүчин зүйлийн нөлөөтэй ойлголтууд юм. Энэ хүмүүсийн амьдралын *хабитус* буюу хэв маягтай тасралтгүй хувиран бүрэлдэж байдаг, уян хатан, олон талт байдлын тухай юм. Өөрөөр хэлбэл, хүмүүс экологийн, эдийн засгийн, шашны, улс төрийн гэх мэт маш олон нийгэм, соёлын хүчин зүйлээс хамаарч амьдралын маш олон янзын хэв маягт амьдардаг гэсэн үг.

Өдөр тутмын амьдралын хэв маягийн хувьд сэтгэлгээний онцлог болон дадал хэвшил (*хабитус*)-д нь үндэслэн дараах байдлаар ерөнхийлөн авч үзэх боломжтой юм. Үүнд:

1. *Нүүдлийн соёлын хэв маягт* – үүнд отроор болон өвөл, зундаа нүүдэллэн мал аж ахуй эрхэлдэг малчин өрхүүд.
2. *Хагас нүүдлийн соёлын хэв маягт* – төв, суурин газар суурин сууж, мал аж ахуй болон бусад аж ахуй эрхэлдэг.
3. *Хагас суурин соёлын хэв маягт* – орон нутаг болон нийслэлд амьдарч ажилладаг, хөдөөгөөс хотод шилжин суурьшсан, ойрын ураг төрөл малчин, ХАА эрхэлдэг зэрэг шалтгаанаар нүүдлийн соёлын хэв маягийг хадгалан амьдардаг, мал ахуйд ойр, улирлын чанартайгаар ирэн очин амьдрах тул амьдралд нь мал аж ахуйн нөлөө их өрхүүд.
4. *Суурин соёлын хэв маягт* – нийслэл хотод төрж өссөн 2 дахь үе, зарим тохиолдолд 3 буюу буюу түүнээс дээших үе, өдөр тутмын амьдралын хэв маягт нь нүүдэлчин иргэншилтэй холбоотой зүйл бараг үгүй болсон өрхүүд

Судалгаанд оролцогсдын дийлэнх хувийг хагас суурин иргэншилт өрхүүд эзэлж байлаа. Үүний гол шалтгааныг сүүлийн 30 жилд эрчимжсэн хот руу /нийслэл Улаанбаатар/ чиглэсэн шилжилт хөдөлгөөн гэж үзэж болохоор байна. Үндэсний Статистикийн Хорооны мэдээлснээр, “2010-2016 онуудад 126,143 хүн Улаанбаатарт албан ёсоор шилжин суурьшсанаар, 2017 онд нийслэлийн хүн ам 1,463,000 гэж тоологдсон” гэжээ. Сүүлийн 5 жилийн дотор буюу 2018-2021 оны хоорондох шилжилт хөдөлгөөнийг харахад нийслэлд шилжин суурьшигчдын тоо 166,381 хүрч 2021 оны байдлаар нийслэлийн хүн амын тоо 1,539,252 гэж тоологдсон нь Монгол Улсын нийт 3,4 хүн амын 45%-ийг эзэлж байна (www.1212.mn).

Гэхдээ эдгээр олон янзын хэв маяг нь тогтсон бүтэцтэй, хувирдаггүй гэсэн үг биш, тасралтгүй хувьсан өөрчлөгдөж, дээш доошоо гүйх уян хатан шинжтэй байдгийг судалгаанд оролцогсдын өдөр тутмын амьдралын хэв маягаас харж болохоор байна. Тухайлбал, малчин байсан хүн хотод орж ажил хийж, хотын өрх болох эсвэл хотод байсан хүн малчин болох, лам хүн замын ажилчин болох, уран бүтээлч уурхайн ажилтан болох гэх мэт олон тохиолдлыг харж болно. Малчин өрх дотроо олон талт үйл ажиллагаатай, амьдралын өөр хэв маягт шилжих хөдөлгөөн идэвхтэй байгааг ажиглаж болно. Энэхүү ялгаа зөрөөтэй олон хэв маягт хамгийн гол нөлөөлж байгаа зүйл бол өмнө дурдсанчлан экологийн, эдийн засгийн, аж ахуйн, насны хэв маяг хамгийн их нөлөөлж байгаа юм.

Түүнчлэн энэхүү нөлөөллийн доорх олон зүйл хэв маяг нь нийгэм соёлын баялгийг ялгаатай байдлаар хүртэж, мөн өөр өөрөөр бүтээж байна. Тухайлбал, ардын “уламжлалт” соёлын тухайд хөдөө малчин өрхийн хувьд бүрэн дүүрэн дотор нь байдаг бол хот юм уу төв суурин газрын тухайд “орчин үеийн” гэгдэх өнөөгийн хотын орон зайн соёлын элементүүдийг түлхүү хүртэж байна. Эргээд “уламжлалт” гэгдэх соёлын элементүүдийг хүртэх байдал нь маш бага эсвэл зарим судлаачдын хэлдэгчлэн “үндэсний соёл нь үзмэр” болох хэмжээнд байгаа юм.

Монголчуудын амьдралын энэхүү олон талт хэв маяг нь зөвхөн Монголын нийгэмд байгаа биш, ерөнхийдөө орчин үеийн нийгэмд түгээмэл байдаг хэв шинжийг мөн агуулж байна. Цаашлаад орчин үеийн нийгмийн, байгаль орчны олон асуудал (дулаарал, цөлжилт, ядуурал, баялгийн тэгш бус хуваарилалт, боловсролын тэгш бус байдал гэх мэт) ч мөн адил Монголчууд дэлхийн иргэн, дэлхийтэй “зовлон нэгтэй” гэдгийг харуулж байна.

Иймээс “Бүх нийтийн соёлын боловсролын” арга хэмжээг иргэдийн нас, сэтгэхүйн онцлог, соёлын ялгаатай хэв маяг, өдөр тутмын амьдралын дадал хэвшил, сонирхол таашаалд нийцүүлэн боловсруулах шаардлагатай. Ингэхдээ соёлын ялгаатай байдлыг хүндэтгэх, тэгш бус хүртээмж, хуваарилалтыг саармагжуулахад чиглэх ёстой.

Соёл ба боловсрол

Нэн тэргүүнд “соёл” хэмээх ухагдахууныг эргэн нягталж, хүрээг нь тэлж, дахин тодорхойлж, ойлголтоо нэгтгэн олон нийтэд хүргэх шаардлага байна. Ингэхдээ “соёл = урлаг”, “соёл = боловсрол”, “соёл=иргэншил гэсэн явцуу ойлголтоос холдуулж, соёлыг өдөр тутмын амьдралын хэв маяг, байнгын өөрчлөгдөх үйл явц талаас нь ойлгож тайлбарлавал зохилтой. Монгол Улсын төрөөс соёлын талаар явуулж ирсэн бодлого нь социалист соёлын байгуулалтаас улбаатай “мэргэжлийн”, “институцийн” соёл, урлагийн үйл ажиллагааг голлосон шинжийг хадгалсан, 90-ээд оноос хойших үеийн үндэсний соёлын сэргэлт, “үндэсний үзэл”-ийн нөлөөгөөр уламжлалт соёлыг “өв”, “үнэт зүйл”, “бэлгэдэл”-ийн хэлбэрт барьсан шинжтэй явж ирсэн гэж болно. Үүний дүнд соёл хэмээх ойлголт нь олон нийтийн, өдөр тутмын амьдралаас холдож, жирийн иргэдэд хүртээл багатай мэт ойлгогдохоор байна. Иймээс “Бүх нийтийн соёлын боловсрол”-ын үндэс суурь нь соёлыг хүн бүрд хүргэж, өдөр тутмын амьдралд нэвтрүүлж, “өөрийгөө болон байгаль, нийгмийг танин мэдэхүй, хийж бүтээхэд насан туршдаа өдөр тутам суралцах идэвхтэй иргэн” төлөвшүүлэхэд орших болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Нэг. Баримт бичгүүд:

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992
2. Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал-2010.
3. БСШУЯ, БХ, ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс. *Монгол Улсын боловсролын суурь мэдээллийн тайлан*, Улаанбаатар хот, 2019 он.
4. ҮСХ, УИХ. 2019. Монгол улс-НҮТС 2018
5. БШУСС Сайдын тушаал. 2019 оны 8 дугаар сарын 2 өдөр. Хөтөлбөр батлах тухай.
6. [АЛСЫН ХАРАА 2050 МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО.pdf \(nda.gov.mn\)](#)
7. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль [...](#)
[www.Legalinfo.mn - Хуулийн нэгдсэн портал сайт :...](#)
8. Соёлын тухай хууль [СОЁЛЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ \(legalinfo.mn\)](#)
9. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр [Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр \(meds.gov.mn\)](#)
10. Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр /төсөл/

Хоёр. Судалгааны бүтээлүүд:

11. Монголын маркетингийн судалгааны ассоциаци ТББ. Монгол үндэстний ижилслийг илтгэх бэлгэдэл, соёлын судалгаа, Улаанбаатар хот. 2019 он.
12. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарын чанарын судалгаа, Эм Эм Си Жи ХХК, 2021, Улаанбаатар хот.
13. Ш. Ариунболд, Ц.Янжиндулам нар. *Монгол улсын аз жаргалын индексийг олон улсын түвшинтэй харьцуулсан судалгаа, 2016*. Улаанбаатар хот.
14. Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар. *Хүүхдийн хөгжил, төлөвшил, хүмүүжилд сөрөг нөлөө үзүүлж болох хүчин зүйлийг тодорхойлох судалгаа*. 2019. Улаанбаатар хот.
15. Соёл урлагийн их сургууль. *Монголчуудын үнэт зүйлийн судалгаа*. 2019. Улаанбаатар хот.
16. Санхүү эдийн засгийн их сургууль. *Монголчуудын үндэстний үнэт зүйлийн судалгааны тайлан*. 2015. Улаанбаатар хот.
17. У. Туяа нар. *Ерөнхий боловсролын болон их, дээд сургууль, мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагчдад зориулсан эрх зүйн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгааны тайлан*. 2021. Улаанбаатар хот.
18. О.Пүрэв, Г.Түвшинжаргал. *Түүхийн сургалтын хөтөлбөрт Монгол үндэстний нэгдмэл үнэт зүйлийг тусгах агуулга, арга зүйн судалгаа*, Улаанбаатар хот.

19. Mongolian Marketing consulting group. *Монгол хүний эрхэм чанар, зан суртахууны судалгаа*. 2019. Улаанбаатар хот.
20. Боловсролын хүрээлэн. *Боловсролын чанар, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн бодлогын судалгаа*. 2020. Улаанбаатар хот.

Гурав. Онол, арга зүйн бүтээлүүд:

21. А.А. Возьмитель Г.И. Осадчая. Образ жизни: Теоретико-Методологические основы анализа.
22. Европейская экономическая комиссия. 2006 года. Индикаторы для образования в интересах устойчивого развития.
23. Basis for Cultural Education: Guide for the future of school-based and extracurricular cultural education.
24. Contradictions in Schooling Children among Mongolian Pastoralists Author(s): Ariell Ahearn and D. Bumochir Source: Human Organization, Vol. 75, No. 1 (Spring 2016), pp. 87-96
25. Dawn Mannay. Visual, narrative and creative research methods: *application, reflection and ethics*. Routledge.
26. United Nations Educational, Scientific and Cultural Organization. 2014. *UNESCO Cultural for development indicators, Methodology Manual*.
27. Marzluf, Phillip P. 2015 The Pastoral Home School : Rural, Vernacular, and Grassroots Literacies in *Early Soviet Mongolia*. Central Asian Survey 34(2):204-218
28. United Nations Educational, Scientific and Cultural Organization, 2015. *Соёлын бодлогыг дахин тодорхойлох нь*. 2005 оны Конвенцын дэлхийн тайлан.

“СОЁЛЫН БОЛОВСРОЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ: ТУЛГАМДСАН АСУУДАЛ”

Семинарын удирдамж

Хурлын зорилго. Монгол Улсын төрөөс “Хүмүүнлэг, оюунлаг, ёс суртахуунтай, үндэсний соёлын мэдлэг, чадвар, дадалтай монгол хүнийг бэлтгэх” зорилт тавьж, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн “Бүх нийтийн соёлын боловсрол”-ын бодлого боловсруулахад ихээхэн анхаарч байна. Дээрх асуудалд эрдэмтэн, судлаачдын анхаарлыг хандуулах, бодлогын баримт бичиг боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцоог нь хангах зорилгоор энэхүү семинарыг зохион байгуулж байна.

Семинарын хүрээнд Бүх нийтийн соёлын боловсролын талаар баримталж буй төрийн бодлого, түүний хэрэгжилтийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх; Бүх нийтийн соёлын боловсролын тулгамдсан асуудал, түүнийг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх зэрэг асуудлыг хэлэлцэж, энэ чиглэлээр сургалт, судалгаа явуулдаг байгууллага, судлаачид харилцан мэдээлэл солилцох, хамтран ажиллах боломж бүрдүүлэхийг зорьж байна.

Боловсрол, шинжлэх ухааны яам, Соёлын яам, ШУА-ийн Философийн хүрээлэн, МУИС, ШУТИС, СУИС, Олон улсын Улаанбаатарын их сургууль болон бусад их, дээд сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэн, төвүүдийн төлөөллийг урьж илтгэл, хэлэлцүүлэг зохион байгуулж, зөвлөмж боловсруулна.

1.Илтгэлийн хамрах хүрээ:

1. Бүх нийтийн соёлын боловсролын талаарх төрийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх механизмыг боловсронгуй болгох асуудал
2. Бүх нийтийн соёлын боловсролын хэрэгцээ, шаардлага
3. Соёлын боловсролын хамрах хүрээ, хэрэгжүүлэх үйл ажиллагааны арга, хэлбэр
4. Хүн амын соёлын боловсролын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал
5. Бүх нийтийн соёлын боловсролд гэр бүл, нийгмийн институциудын гүйцэтгэх үүрэг
6. Ёс зүй, ёс суртахууны боловсрол
7. Соёлын өвийн боловсрол
8. Урлагийн боловсрол
9. Музейн боловсрол

10. Монгол хүний хөгжил, нийгэмшлийн асуудал

2.Хуралд хэлэлцүүлэх илтгэлд тавигдах шаардлага:

1. Илтгэлээ 5-10 нүүрт багтааж word хэлбэрээр, форматын дагуу /Times New Roman, 12 pt фонтоор, мөр хоорондын зай 1,5, хүснэгтийн үсгийн хэмжээ 10 pt байна/ бэлдэнэ.
2. ЭШХ-д илтгэлийг powerpoint болон бусад үзүүлэн хэлбэрээр бэлтгэж, 15 минутад багтаан хэлэлцүүлнэ.
3. Илтгэлийг цахим болон хэвлэмэл байдлаар 2022 оны 3-р сарын 20-ны дотор ирүүлнэ.
4. Эрдэм шинжилгээний хурал 2022 оны 3-р сарын 25-ны Баасан гаригийн 10.00 цагт Монголын Үндэсний музейн хурлын танхимд болно.

Холбоо барих хаяг: ШУА-ийн Философийн хүрээлэн

Утас: 99096551, 99131936, 99096083

Цахим хаяг: b.puujee@gmail

dolgorsuren.tdus@gmail.com

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ



**“СОЁЛЫН БОЛОВСРОЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ: ТУЛГАМДСАН
АСУУДАЛ”
Семинарын хөтөлбөр**

*Хэзээ: 2022 оны 3-р сарын 25-ны Баасан гаригт 10.00 цагт
Хаана: Монголын Үндэсний музейн хурлын танхимд болно.*

Семинарыг ШУА-ийн ФХ-ийн захирал Б.Пүрэвсүрэн (Ph.D. Проф.) удирдаж явуулна.

10:00 – 10:15

“Гэр бүлийн боловсролын өнөөгийн байдал, цаашдын төлөв” ОУУБИС-н Гэр бүл, сэтгэл судлалын тэнхимийн эрхлэгч доктор, дэд профессор Б. Оюун-Эрдэнэ

10:15 - 10:30

“Ёс суртахууны боловсрол” ШУА-н Философийн хүрээлэнгийн Ёс зүй, сэтгэл судлалын салбарын эрхлэгч доктор М.Анара

10:30 - 10:45

“Хөгжмийн урлагийн боловсрол: тулгамдсан асуудал, шийдлийн гарц”
Г.Ганцэцэг. СУИС-ийн ХУС-ийн захирал

10:45 - 11:15 ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

11:15 - 11:35 ЦАЙ, КОФЕ

11:35 - 11:50

“Музейн боловсролын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал” Д.Мөнхтоогоо (Ph.D) МҮМ-н Музей судлалын мэргэжил арга зүйн төвийн дарга

11:50 - 12:05

“Театрын боловсролыг хөгжүүлэх асуудалд”. СУИС-ийн Театрын урлагийн сургуулийн НЖУТ-ийн эрхлэгч М.Ариунжолоо

12:05 - 12:20

“Боловсролын талаарх судалгааны үр дүн” Б.Гэрэлмаа Боловсрол судлалын хүрээлэнгийн ЭША.

12:20-12:50 ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

ЁС СУРТАХУУНЫ БОЛОВСРОЛ

М.Анара (Ph.D)

anara_m@mas.ac.mn

ШУА, Философийн хүрээлэн,

Ёс зүй, сэтгэл судлалын салбарын эрхлэгч

Аливаа улс орны хөгжлийг хүний хөгжлөөр нь хэмжин дүгнэх болсноор дэлхий нийтээр хүний хөгжилд анхаарлаа хандуулах болжээ. “Хүний хөгжил бол бие бялдар, оюун ухаан, ёс суртахуун, сэтгэл зүйн чадвар чадавхыг цогцоор нь сайжруулах үйл явц билээ.”⁶ Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын Хараа- 2050”-д хүний хөгжлийн бодлогыг Монгол улсын хөгжлийн бодлогын үндэс болгон тодорхойлсон. Улмаар нэн тэргүүнд бодлогын түвшинд боловсролын асуудалд анхаарч, сайжруулахаар зорилго, зорилтуудыг дэвшүүлжээ. Хүний хөгжлийн агуулгад ёс суртахууны төлөвшил хөгжлийн асуудал чухал бүрдэл хэсэг нь мөн. Иймд бид өнөөдөр ёс суртахууны боловсролын тогтолцоог бодлогын түвшинд авч үзэх, улмаар түүнийг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх тал дээр анхаарал хандуулах шаардлагатай болоод байна.

Ёс суртахууны боловсрол нь аль ч улс орны хувьд чухал асуудлуудын нэг мөн учраас Юнеско, Европын холбоо зэрэг байгууллагууд боловсролын асуудлын хүрээнд түүнийг орхигдуулалгүй нэн чухлаар авч үзэж байна. Иймд ёс суртахууны боловсролыг албан ёсны сургалтын хөтөлбөрт тусгах хэрэгцээ байна гэдэгт дэлхий нийт аль хэдийнээ санал нэгдэх болжээ. Энэхүү чиг хандлагыг улс бүр өөрийн боловсролын бодлогод тусгаж, сургалтын хөтөлбөртөө, “Иргэний боловсрол”, “Иргэний болон нийгмийн үнэт зүйлс, ёс зүйн үнэт зүйлс”⁷ зэрэг хичээлүүдийг оруулж байна. Монгол улсын хувьд, 2022 оныг “Боловсролын ёс зүйн жил” болгосон, 2019 оноос эхлэн “Иргэний ёс зүйн боловсрол” хичээлийг ЕБС-ийн 1-12 дугаар ангид заавал үздэг болсон зэргээр боловсролын өнөөгийн чиг хандлагаар явж буй нь ажиглагдаж байгаа хэдий ч, оновчтой тогтолцоо бүрдсэн эсэх, чанар, хэрэгжилтийн түвшин, үр дүн зэрэг асуудлууд дээр дутагдалтай талууд байгааг анхаарч ажиллах хэрэгтэй байгаа билээ. Тухайлбал, ёс зүйн мэргэжлийн эрдэмтэн судлаачид мэргэжлийн хүрээнд эрдэм шинжилгээний хурал⁸, судалгааны бүтээлүүд гаргадаг хэдий ч энэ нь бодлого боловсруулагчдаас дорвитой дэмжлэг, хамтын ажиллагааг олж чадахгүй байна. Энэхүү илтгэлийн судалгаанд зориулж “Иргэний ёс зүйн боловсрол” хичээлийн сурах бичгийг үнэлэх мэргэжлийн экспертний багаас чанарын арга зүйгээр судалгаа авлаа. Судалгаанаас, ёс суртахууны боловсролыг боловсролын бодлого, тогтолцоонд зөв оновчтой, үр дүн гарахуйцаар хэрэгжүүлэхэд дараах зүйлсэд нэн тэргүүнд анхаарч ажиллах хэрэгтэй байна гэсэн дүгнэлт гарлаа. Үүнд,

1. Ёс суртахууны боловсролыг олгох хөтөлбөрийг шинэчлэх. Учир нь, тухайлбал, “Иргэний ёс зүйн боловсрол “ хичээлийн сурах бичгийн агуулгыг экспертүүд “...сургалтын хөтөлбөрийг ёс зүйн мэргэжлийн багш, судлаач боловсруулаагүйгээс болж, хөтөлбөрийн агуулга дахь ёс зүйн шинжлэх ухааны мэдлэгийн агуулга бараг ороогүй бөгөөд буддын шашны сэтгэл судлал болон монгол ёс заншлын талаар голдуу

⁶ Дарьхүү Р, Золзаяа М, Оюунгэрэл Д. Ёс суртахууны боловсрол. УБ., 2020

⁷ “ Education for Citizenship, Civic and Social Values, Ethical Values” Research in Moral Education, Felix Garcia-Moriyon et al, Education Science, 2020.

⁸ “Монгол дахь ёс зүйн сургалт, судалгааны өнөөгийн байдал, тулгамдсан асуудал” 2014 он, “Монгол дахь ёс суртахууны боловсролын тулгамдсан асуудал” 2015 он, “Монгол дахь ёс суртахууны боловсролын уламжлал, шинэчлэл” 2016, “Хэрэглээний ёс зүйн асуудлууд” 2017 он, “Мэргэжлийн ёс зүйн асуудалд” 2018 он, “Тогтвортой хөгжил: ногоон ёс зүй” 2019 онд тус тус сэдвээр МУИС-ийн ШУС-ийн ХУС-ийн Философи, шашин судлалын тэнхим анх санаалчлан бусад байгууллагуудын дэмжлэгээр зохион байгуулсан байна.

- бичсэнийг өөрчилж, сургалтын хөтөлбөрийг бүхэлд нь шинээр ёс зүйн шинжлэх ухааны мэдлэгийн агуулгыг нэмж боловсруулах шаардлагатай.”⁹ хэмээн дүгнэж байна.
2. “Иргэний ёс зүйн боловсролын гол зорилго бол ёс суртахууны хувьд боловсорсон иргэнийг төлөвшүүлэх явдал билээ. Ёс зүйн боловсрол бол би монгол хүн гэсэн хязгаарлагдмал хүрээнд бус, ямар ч үндэстэн, улс оронд түгээмэл үйлчлэх боловсрол юм. “Уламжлалт соёл” нь зөвхөн өөрийн соёлыг онцгойлон магтах бус, нийт хүн төрөлхтний хөгжилд хувь нэмэр оруулах ёс зүйн боловсролтой хамт судлах, дэлхийн монгол хүн төлөвшүүлэх асуудал.”¹⁰
 3. Ёс суртахууны боловсролыг олгох хүний нөөцийн асуудалд анхаарал хандуулах цаг болсон байна. Хүний нөөцийг бүрдүүлэх эсвэл мэргэжлийн хүмүүстэй хамтран ажиллах, тэднээс мэргэжлийн зөвлөгөө, зөвлөмж, санал авах тал дээр онцгой анхаарч ажиллах ёстой.
 4. Цаашид ёс суртахууны боловсролыг олгох тогтолцоог бүрэн шинэчлэх. Ингэхдээ дээрх санал, зөвлөмжүүдээс эхлэн тусган шинэчлэлийг үр дүнтэйгээр хийх нь зүйтэй байна.

Дээрх санал, зөвлөмжүүдийг нэгтгэн дүгнэвэл, ёс зүйн мэргэжлийн багш-судлаачид¹¹, “...Монгол хүний хөгжлийг дээшлүүлэх суурь болсон ёс суртахууны төлөвшил, хөгжлийн асуудлаар өөрийн орны өмнөх туршлага ба гадаад улс орны ёс суртахууны боловсролын тогтолцоо, түүний агуулгыг харьцуулан судалж, өнөөгийн монгол хүний хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн ёс суртахууны боловсролын тогтолцоо, шинэ агуулга, арга зүйг боловсруулан хэрэгжүүлэх нь тулгамдсан асуудал болж байна Үүнд төрийн бодлого дэмжлэг зайлшгүй чухал.”¹² хэмээн 2020 онд ёс зүйн мэргэжлийн судлаач багш нарын тэмдэглэн хэлж байсан санаа дахин давтагдаж байна.

Ёс суртахууны боловсрол гэдэг бол боловсролын шинжлэх ухаанд хэрэглэгддэг ойлголт. Гэвч, ёс зүй бол философийн салбар ухааны хувьд, ёс суртахууны боловсрол нь эдгээр ухаануудын харилцан хамааралд буюу салбар дундын асуудал мөн юм. Улмаар, ёс суртахууны боловсролын мөн чанарыг ойлгосны үндсэн дээр энэ хүрээнд практикт буюу боловсролыг олгох үйл явцад энэ нь ямар үр нөлөө үзүүлэх вэ гэдгийг тооцож үзэх боломжтой болно. Иймд энэхүү илтгэлд дараах асуудлыг авч үзэж байна. Үүнд,

1. Ёс суртахууны боловсрол гэж чухам юу вэ?
2. Ёс суртахууны боловсролд сэтгэл судлалын гүйцэтгэх үүрэг

НЭГ:Ёс суртахууны боловсрол гэж чухам юу вэ?

Хүн ёс суртахуунгүйгээр эсвэл ёс зүйгээс ангид амьдардаггүй бөгөөд хүүхэд наснаас эхлэн тогтсон уламжлалт ёс суртахууны хэм хэмжээгээр өсөж төлөвшдөг. Ардчилсан нийгэмд ч мөн л иргэн бүр тогтсон ёс суртахуун, иргэний үнэт зүйлстэй бөгөөд тэд сайн үйлийг олноор тунхаглан хийснээр цэцэглэн хөгжих боломжтой болно гэж үздэг. Өнөөгийн шинжлэх ухаан, технологийн хурдацтай хөгжил нь нийгмийн төвөгтэй, бэрхшээлтэй асуудлуудыг бий болгохын хэрээр, тэдгээр нь ёс суртахуун, үнэт зүйлс, ёс зүйн нийгэмд үзүүлэх ач тусыг улам өсгөсөөр байна. Ж.Дью “Жинхэнэ боловсрол бол ардчиллаар өгөгдсөн бөгөөд ардчилсан нийгмийг ойлгоно гэдэг бол ардчилсан засгийн газрын тухай бус, харин хүмүүс хоорондын харилцаан дээр үндэслэсэн холбоог ойлгох тухай юм. Ардчилал бол, амьдралд аливааг харилцан хуваалцах байдал бөгөөд хүний мөн чанар нь жинхэнэ ардчилсан бүлэг, нийгэмд бүрэн хөгжих боломжтой.”¹³ хэмээн хэлжээ. Ёс зүйг түгээмэл үндсэн гурван утгаар ойлгож болно. Үүнд, нэгдүгээрт, ердийн амьдралын түвшинд, ёс суртахууны үйл гэдэг утгаар нь ёс зүйг ойлгодог. Хоёрдугаарт, ёс зүй нь философийн нэг салбар ухаан бөгөөд хүний үнэт зүйл, хэм хэмжээний эх

⁹ “Иргэний ёс зүйн боловсрол” сурах бичигт хийсэн дүгнэлт, санал, зөвлөмж, Нийгмийн ухааны баг, Дарьхүү.Р, Батзаяа Б, Баасанцэрэн Э, 2021 он.

¹⁰ Мөн тэнд

¹¹ Дарьхүү Р, Золзаяа М, Оюунгэрэл Д, Ёс суртахууны боловсрол. УБ.2020.

¹² Мөн тэнд

¹³ Research in Moral Education, Felix Garcia-Morison et al, Education Science, 2020.

сурвалжийг судалдаг ухаан юм. Гуравдугаарт, мэргэжлийн ёс зүй буюу энэ нь ямар нэг онол гэхээс илүү тодорхой мэргэжлийн хүрээнд баримтлах ёс суртахууны тусгай кодуудыг баримтлах тухай юм.

Ёс суртахууны боловсролын төвд нь мэдлэгт суралцаж буй, мэдлэгийг эзэмшиж буй хүн байдаг тул түүний онол нь ёс суртахууны философи, ёс суртахууны сэтгэл судлал, ёс суртахууны боловсролын практик хүрээнд яригддаг (Han, 2014)¹⁴.

Ёс суртахууны боловсролын үндсэн зорилго бол хүн өөрийн буюу хувь хүний хариуцлага болон үйлдэлдээ эзэн болох, бусадтай хуваалцах мэдрэмжээ хөгжүүлэхэд тус болох юм (Campbell, 2008)¹⁵. Мөн ёс суртахууны боловсрол нь суралцагчдын ёс суртахууныг дээшлүүлэн хөгжүүлэх, зан суртахууныг төлөвшүүлэх үүрэгтэй.

Сүүлийн үеийн чиг хандлагаар, ёс суртахууны үзэл бодол, үйл нь Ж.Дьюгийн үзэл баримтлалын хүрээнд, ёс суртахууны үзэл бодол эсвэл ёс суртахууны учир шалтгаан нь нийгмийн капитал мөн гэж үзэж байна.¹⁶ Улмаар, ёс суртахууны боловсролын философи түлхүүр асуудал нь ёс суртахууныг хэрхэн тусгаж авах эсвэл түүнийг ойлгох гэсэн эпистемологи байр суурь болон ёс суртахууны үйл, нөлөөний тухай болоод байна.

Ёс суртахуун гэдэг бол нэг хүний тухай асуудал биш, хүн болгоны асуудал мөн. Ёс суртахууны үүрэг гэдэг бол нэг соёл, нэг нийгэмд зориулагдсан байдаггүй, харин түгээмэл шинж чанартай байдаг. Хэрвээ бид энэ утгаар нь ёс суртахууныг авч үзвэл, ёс суртахууны хөгжил гэдэг нь хүний нийгмийн болон сэтгэл зүйн хөгжлийг дамжин явах процессыг хэлнэ. Энэ бол өөрийн болон бусдын зан төлөвийг үнэлэхийн зэрэгцээ зөв болон бурууг ялгах “авьяас”¹⁷-ын тухай юм (Turjel, 1998)¹⁸. Хөгжлийн энэ процесс нь хүний хүүхэд наснаас эхэлдэг. Хүүхэд ёс суртахууны нээлттэй асуудлуудтай цаг ямагт тулгардаг. Тухайлбал, найзынхаа хийсэн буруу зүйлийг багшид хэлэх нь зөв үү, буруу юу?, Ээжийнхээ, аавынхаа эсвэл багшийнхаа буруу, муу үйлдлийг бусдад хэлэх үү, үгүй юу? Насанд хүрэгчид яагаад худал хэлж, хуурч болоод байдаг? Ёс суртахууны боловсрол нь хүн өөрийн үйл, үйлдлийг эргэн санаж тунгаан бодох нь түүнийг өөрийгөө-үнэлэх, өөрийгөө-шүүн тунгаахад хүргэдэг ач холбогдолтой. Хүүхэд, залуусын ёс суртахууны үнэт зүйлс, нийгмийн чадваруудыг ёс суртахууны боловсролоор олж авах боломжтой заавар, загвар, туршлага болон тасралтгүй дадал зуршлаар хөгжүүлэх боломжтой (Berret and Berman 1997)¹⁹.

“Ёс суртахууны боловсрол нь суралцагсдад ёс зүйн мэдлэг олгоод зогсохгүй тэрхүү мэдлэгийг суралцагч бие даан эзэмших, түүнийгээ амьдрал практикт хэрэгжүүлэх чадвар, дадал зуршил бий болгох, эрүүл сэтгэлгээтэй хүн болгон төлөвшүүлэх үйл ажиллагаа юм.”²⁰

Өнөө үеийн ёс суртахууны боловсрол нь иргэдэд ёс суртахуунтай шийдвэр гаргах чадвар, ёс суртахуунтай үйлдэл хийх хүсэл эрмэлзлийг бий болгох, ёс суртахуунтай үйлдэл хийх чадварыг эзэмшүүлэхэд илүү анхаарч байгаа чиг хандлагатай байна. Үүнд, ёс суртахууны боловсрол нь дараах үндсэн хэсгүүдээс бүрдэж байна.

- Ёс зүйн мэдлэг олгох
- Практикт хэрэгжүүлэх чадварыг эзэмшүүлэх
- Дадал зуршил суулгах
- Төлөвшүүлэх

¹⁴ *Emphasizing Morals, Values, Ethics, And Character Education In Science Education And Science Teaching, Mohammad Chowdhury, The Malaysia Online Journal of Education Science, 2016.*

¹⁵ *Мөн тэнд*

¹⁶ *Research in Moral Education, Felix Garcia-Morison et al, Education Science, 2020.*

¹⁷ “Talent”

¹⁸ *A Study of Moral Education and Relationship with Character Education, Dr. Nur Silay, Mediterranean Journal of Sciences, Rome, Italy, 2014.*

¹⁹ *Emphasizing Morals, Values, Ethics, And Character Education In Science Education And Science Teaching, Mohammad Chowdhury, The Malaysia Online Journal of Education Science, 2016.*

²⁰ *Дарьхүү Р, Золзаяа М, Оюунгэрэл Д, Ёс суртахууны боловсрол. УБ.2020.*

Ёс суртахууны боловсролд сургуулийн гүйцэтгэх үүргийг Дьюкем, Пиаже, Мариа де Марезүг нараас эхлэн 1960 аад оноос эхлэн чухлаар тодорхойлох болсон. Тухайн үеийн барууны нийгэмд нийгэм соёлын хямрал явагдахын хэрээр боловсролын системд ч хямрал нүүрлэж байсныг бид дэлхийн түүхээс мэднэ. Тэгвэл, XXI зууны эхний арван жилд хүн төрөлхтөнд оршихуй болон глобалчлалын хүрээнд нүүрлэсэн сорилтод ардчилсан нийгмийн нэгдмэл байдлыг хангахад боловсролын гүйцэтгэх үүрэг гол байгаа учраас ёс суртахууны боловсролын хэрэгцээ улам нэмэгдэх болсон гэж эрдэмтэд дүгнэж байна. Иймд, ёс суртахууны боловсролд анхаарал хандуулахын зэрэгцээ, ёс суртахууны чадвар (танин мэдэхүйн болон сэтгэл зүйн хүрээнд), хүний эрх, ардчиллын үнэт зүйлс нь сурган хүмүүжүүлэгч багш болон сургуулийн орчинд хөгжих нь чухал болоод байна. Сургууль гэдэг бол нийгэм-суралцахуйн институц юм. Сургууль нь зөвхөн мэдлэгт суралцдаг газар бус, харин хувийн орон зайн талбарын нэг хэсэг (part of the private space field) буюу үе тэнгийнхэнтэйгээ хамт амьдрах газар, гэр бүлийн амьдрал шиг амьдрал байх газар болоод байна.²¹ Мөн ёс зүйн зохих боловсролд хүрэхийн тулд суралцагчдын ёс суртахууны өсөлтөд анхаарах шаардлагатай. Ёс суртахууны хөгжил нь хүүхэд наснаас эхлэн их сургуулийн эхний курс хүртэл явагддаг.²² Өөрөөр хэлбэл, их сургуулийн насны залуу хүний ёс суртахууныг дээшлүүлэх, төлөвшүүлэх үйл ажиллагаа бол хамгийн чухал зүйл юм. Өнөөгийн нийгмийн хүүхэд, залуус асар их мэдээллийн урсгал, өмнөх үеэс эрс өөр үнэт зүйлсийн нөлөөн дор өсөж, хөгжин төлөвшиж байна. Ёс суртахууны боловсролын үр дүнд, тэдгээр залуус өөрийн амин чанараа²³ олж авдаг. Хүний амин чанарт нөлөөлөх чухал хүчин зүйлс нь :

- мэргэжил сонголт
- амьдралын хэв маягаа тодорхойлох
- эсрэг хүйсийн хүнтэй хайр сэтгэлийн холбоо үүсгэх
- улс төр, философи, шашны талаарх үзэл бодлоо төлөвшүүлэх
- бүлэгт байх болон бүлэгт харьяалагдах
- өөрийн үнэт зүйлстэй болох

ХОЁР. Ёс суртахууны боловсролд сэтгэл судлалын гүйцэтгэх үүрэг

Америкийн сэтгэл судлаач Л.Коулбергийн ёс суртахууны хөгжлийн онол нь ёс суртахууны боловсрол нь сэтгэл судлалын ухаантай хэрхэн харилцан хамааралтай болохыг сонгодог байдлаар томъёолсон юм. Пиажегийн ёс суртахууны хөгжлийн онолд тулгуурлан боловсруулагдсан түүний онол олон жил ёс суртахууны хөгжлийн онолын судалгааны суурь болон иржээ. Коулбергийн ёс суртахууны хөгжлийн онолоор, ёс суртахууны боловсролд хүрэх гурван үе шат байдаг. Үүнд, 1.уламжлалаас өмнөх, 2. уламжлалт, 3. уламжлалын дараах гэсэн ёс суртахууны гурван үе шат байна.

1-р үе шат: Хувь хүн болон бусдын харилцан хамаарлыг хамарна.

2-р үе шат: Ёс суртахууны нээлттэй асуудлуудыг шийдвэрлэнэ.

3-р үе шат: Ахлах сургууль болон их сургуулийн насны хүмүүсийг хамарна.

Ёс суртахууны нээлттэй асуудлуудыг хэрхэн шийдвэрлэж байгаа нь тухайн хүүхэд ёс суртахууны хөгжлийн аль үе шатанд байгааг тодорхойлно. Энд ёс суртахууны асуудал бүхий бодол санаа нь хүний шийдвэр гаргалтад нөлөөлдөг гэдэг санаа байна. Эцсийн үе шатанд, хүн уламжлагдан ирсэн ёс суртахууны санаан дээр тулгуурлан шийдвэр гаргадаг. Энэ үе шат нь дотроо хоёр үе шаттай. 1. Нийгмийн буюу бусадтай хамт байх 2. Хувь хүний эрх болон түгээмэл эрх. Эхний үе шатанд, хүн хүний эрх болон нийгмийн эрх ашгийн аль аль талыг хүлээн зөвшөөрч, тэдгээрийг тэнцвэртэй хадгалахыг оролддог. Харин, хоёрдох үе шатанд, тухайн нийгмийн зарчим нь ёс зүйт бус байвал, түгээмэл шударга ёсны зарчмыг баримтлахыг оролддог. Ёс суртахууны өсөлт, хөгжил нь түүний үе шатуудыг амжилттай даван туулснаар тодорхойлогдохгүй. Харин энэ нь ёс

²¹ *Research in Moral Education, Felix Garcia-Morison et al, Education Science, 2020.*

²² *Мөн тэнд*

²³ *identity*

суртахууны чадваруудын цогцыг бүрэн эзэмших, төлөвших үйл явцаар тодорхойлогдоно. Иймд, ёс суртахууны боловсрол нь хүний хүүхэд наснаас эхлэх ёстой байгаа юм.

Darcia Narvaez нь ёс суртахууны хөгжлийн концепцид Коулбергийн үе шатны онолоос нэг шат урагшилж, нео-коулберг онолыг санал болгожээ. Сайн үйл, зан чанар болон ёс суртахууны боловсрол гурвын хоорондын уялдаа холбоон дээр санал дэвшүүлсэн байна. Энэхүү саналыг сүүлийн үед сэтгэл судлалын салбарт ч дэмжиж байна.

Сэтгэл судлалд бие хүний сэтгэл зүйн таван хэв шинж²⁴ нь хүний зан төлөвийг урьдчилан таамаглах боломжтой гэж үздэг бол, үүнийг ёс суртахууны зан төлөвийг дээшлүүлэх боловсролын санааг боловсруулахад харгалзан авч үзэх боломжтой гэж үзэж байна. Хүний амьдралын орчлын турш бие хүний сэтгэл зүйн хэв шинжийн уян хатан байдал үүнд чухал нөлөөтэй. Гэхдээ энэ нь насны үечлэлээс шалтгаалан буурдаг. Өөрөөр хэлбэл, сэтгэл зүйн хэв шинжийн уян хатан байдал нь хүүхэд насанд илүү байдаг бол нас ахих тусам багасдаг байна.

Ёс суртахууны хөгжил гэдэг бол “ ёс суртахууны боловсрол эзэмшсэн хүн “ буюу ёс суртахууны хувьд төлөвшсөн хүн бий болохыг хэлнэ. Ёс суртахууны хөгжлийн талаарх үзэл санаанд чухал хувь нэмэр оруулсан эрдэмтдийн нэг М.Хоффман эмпати буюу бусдыг ойлгох, мэдрэх, бусдын оронд өөрийгөө орлуулан тавьж үзэх мэдрэмжийг хөгжүүлэх талыг илүү онцлон үзсэн байна.

Ёс суртахууны боловсролыг зан суртахууны боловсролтой уялдуулан судлах, тэр дундаа нийгэм дэх институцийн хувьд сургуулийн гүйцэтгэх үүрэг, багшийн заах арга зүй, ёс суртахууны нийгмийг бий болгох зэрэг асуудлуудын хүрээнд гадаадын эрдэмтэд сүүлийн үед түлхүү судалж байгаа нь ажиглагдаж байна.

Манайд улсад ч, ёс суртахууны боловсролын хөгжлийг боловсрол судлал, философи- ёс зүй судлал, сэтгэл судлалын хүрээнд цаашид судлах шаардлага, хэрэгцээ гарч ирж байна.

Ном зүй

1. Дарьхүү Р, Золзаяа М, Оюунгэрэл Д. Ёс суртахууны боловсрол. УБ., 2020.
2. Монгол дахь ёс суртахууны боловсрол: Уламжлал, шинэчлэл, Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл, УБ, 2016.
3. Хэрэглээний ёс зүйн асуудлууд, Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл, УБ, 2017.
4. “Алсын Хараа -2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, УБ, 2019.
5. “Education for Citizenship, Civic and Social Values, Ethical Values” Research in Moral Education, Felix Garcia-Moriyon et al, Education Science, 2020.
6. Emphasizing Morals, Values, Ethics, And Character Education In Science Education And Science Teaching, Mohammad Chowdhury, The Malaysia Online Journal of Education Science, 2016.
7. A Study of Moral Education and Relationship with Character Education, Dr. Nur Silay, Mediterranean Journal of Sciences, Rome, Italy, 2014.

²⁴ Personality traits: BIG FIVE MODEL, OCEAN зэргээр нэрлэдэг.

“ТЕАТРЫН БОЛОВСРОЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ АСУУДАЛД”

Мягмардоржийн Ариунжолоо.
СУИС-ийн ТУС-ийн НЖУТ-ийн эрхлэгч
altaanaa.x@gmail.com

Хураангуй:

Ерөнхий боловсролын сургуулийн сурагч, өсвөр үеийнхний дунд РС тоглоомд донтох, үе тэнгийнхнээ дарамтлах, гэр бүл, насанд хүрэгчид, багш сурган хүмүүжүүлэгчидтэй харилцааны зөрчилд орох, сурах дургүйн улмаас сургуулиас завсардах явдал буурахгүй байна. Энэхүү асуудлыг шийдэхэд урлагийн боловсрол тэр дундаа театрын боловсрол чухал үүрэг гүйцэтгэдэг. Монгол улсад театрын боловсролыг олгоход тулгамдсан олон асуудлууд үүссэн талаар судлаачид онцолжээ. Тухайлбал театрын мэргэжлийн боловсон хүчин хангалттай бус байх бөгөөд төрөөс бодлогын төвшинд дэмжихгүй байна. Түүнчлэн театр, дуурь, балетыг ойлгох чадвартай боловсролтой үзэгчид хангалттай бус. Мөн сонгодог урлагийн заах арга зүйг ерөнхий боловсролын сургуулиудын хичээлийн агуулгад оруулах, заах арга зүйг боловсронгуй болгох асуудал тулгарсан. Энэхүү илтгэлээр театрын боловсрол олгоход тулгамдаж буй асуудлууд үүссэн шалтгаант нөхцөлийг тодруулж, шийдвэрлэх гарцыг эрэлхийлэхийг эрмэлзсэн болно.

Түлхүүр үг: Театрын боловсрол, жүжгийн дугуйлан, бие, хэл, сэтгэхүй, найруулга.

Оршил:

Театрын оршин тогтнох үндэс бол мэргэжлийн бэлтгэгдсэн уран бүтээлчид болох жүжигчин, найруулагч, жүжгийн зохиолч, тайзны зураачид байдаг. Нөгөө талаар урлагийг ойлгодог, сонирхдог эрэлтэд үзэгчидтэй байх зүй ёсны шаардлага урган гарч байгаа юм. Үзэгчидгүй бол ямар ч урлагийн бүтээл оршин тогтнох үндэс үгүй бөгөөд билээ. Харин Дуурийн театр, УДЭТ-ын хувьд эрэлттэй үзэгчдээр дутмаг байдаг. Өнөөдөр жүжгийг зорьж очин үзэж, шинэ тоглолтыг алдалгүй үздэг үзэгчид цөөхөн болжээ. Ихэнх үзэгчид кино эсвэл, хошин шог руу цувах болсон байна. Бид театр, дуурь, балетыг ойлгодог, шимтэн сонирхдог үзэгчдийг хэрхэн бий болгох вэ? гэдэг асуудал өнөөгийн тайзны урлагийн байгууллагуудын тулгамдсан асуудлуудын нэг байсаар байна.

Иймээс бид урлагийн боловсрол тэр дундаа театрын боловсролоор урлагийг ойлгодог, жинхэнэ утгаар нь мэдэрч таашаал авч чаддаг үзэгч болон хувь хүнийг бэлдэх тал дээр боловсролын анхан шатнаас нь анхаарах ёстой юм. Ингэхдээ бага наснаас нь театрын боловсролоор дамжуулан урлаг, уран зохиол, гоо зүйн боловсрол олгосноор хүүхдийн анхаарал, ой тогтоолтыг хөгжүүлэн цэгцтэй сэтгэн бодох, бусадтай чөлөөтэй харьцах, өөрийгөө зөв илэрхийлэх, эх хэлээрээ утга төгөлдөр ярих зэрэг чадвар бүхий оюуны өндөр чадавхтай бие хүн болгон төлөвшүүлэх гэсэн асуудал бидний өмнө тулгараад байна.

Үндсэн хэсэг:

“Нийгмийн гишүүдийг нийгэм болгон бүрдүүлдэг түлхүүрийн нэг бол соёл мөн.”²⁵ Нийгэм, соёл хоёр тусдаа ойлголтууд боловч өөр, өөрийн үндсэн үүргүүдтэй хэр нь хамтын харилцаанд “нэг зоосны хоёр тал” болох зарчмаар уялдадаг. Уялдааны зохирлыг хангах шаардлагатай, учир нь аль нэг нь нөгөөгөөсөө түрүүлэх, хоцрох, холдох тохиолдолд хоорондын зохирол алдагдаж зөрчлийг үүсгэнэ. Зөрчил нийгмийн оюун санаа, сэтгэлгээ, ухамсар доройтох, хямрах, хэлбэрүүдээр илэрнэ. Оюун ухаан, сэтгэлгээ, сэтгэцийн хямралыг соёл, урлаг, уран сайхны бүтээл, соён гэгээрүүлэх олон талт үйл

²⁵ Ионин Г. “Социология культуры” М., 1994

ажиллагаагаар эерэг болгож болно гэж үзсэн эрдэмтэн судлаачдын үзэл баримтлал байдаг.

Иргэдийн нийтийн соёлыг дээшлүүлэхэд, соён гэгээрүүлэхэд соёл, урлагийн байгууллагууд чухал үүрэг, ач холбогдолтой. Тэр дундаа театрын боловсролоор дамжуулан соёл, урлагийг түгээх, хувь хүнийг хөгжүүлэх нь өнөөгийн нийгэмд чухал асуудал болоод байна. 20 гаруй жилийн өмнөх нийтийн соёлын гол цөм нь олон нийтийн ТВ, радио, номын сан, театр байсан бол өнөө үед компьютер, түүнээс хараат технологийн дэвшлийн үр дүнгээс салгаж ойлгож болохооргүй түвшинд өөрчлөгдөж байна. Энэ бол нийтийн соёлд гүйцэтгэж байсан эдгээр зүйлс нь мэдээллийн технологи, үсрэнгүй хурдтай техникийн хөгжлөөр солигдож байгаатай холбоотой. Техник технологийн хэт хурдацтай хөгжил нь хувиа хичээх, амиа бодох, гаж соёл, амьд харьцаа үгүй болох, ярианы ур чадвар муу, санаагаа нээн, ойлгуулах тал дээр дутмаг, биеийн хөгжил мэдрэмж муутай залуу үе ар араасаа гарч ирэх нөхцөл бүрдэж байна. Тийм ч учраас төрөөс иргэдийн урлагийн боловсролыг дээшлүүлэх тал дээр анхаарч тусгай тогтоол гаргасан. Монгол Улсын Их Хурлын 2012 оны 52 дугаар тогтоолын “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого” заалтын 4.2.1-ийн “Монгол хүнийг бага наснаас нь хүмүүнлэг, оюунлаг, соёл, уламжлалаа нандигнан дээдэлдэг иргэн болгож төлөвшүүлэх үйл ажиллагааг бүх шатны боловсролын бүрэлдэхүүн хэсэг болгох”²⁶ гэж зааснаар Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2011 оны 06 дугаар сарын 20 өдрийн 228-р тушаалаар хүүхдэд зориулсан уран сайхан, гоо зүйн мэдлэг олгоход баримтлах уран бүтээлийн жагсаалтаар заавал үзэх жүжиг, циркийн хөтөлбөр, гадаадын болон монголын уран зохиол, ардын урлаг, дуурь балет, кино, сонгодог хөгжим зэргийн жагсаалтыг гаргасан боловч тэдгээрийг хүүхдүүдэд хэрхэн хүртээх, таниулах тал дээр ямар ч гарц, хэрэгжилт байхгүй байгаа учир ажил болж хэрэгжээгүй гэхэд болно.

Театрт жүжиг, уран бүтээл нь олон хүний нөр их хөдөлмөрөөр бүтээгддэг боловч түүнийг үзэх үзэгчид /зритель/-ийг олж театрт ирүүлэх гэдэг бол театр, чуулга, соёлын төвүүдийн хувьд хүндрэлтэй асуудал хэвээр байна.

“Театр” хэмээх ойлголтын цар хүрээг оновчтой тодорхойлсны үндсэн дээр уг ойлголт, ухагдахууныг бүрдүүлж буй элементүүдийг иж бүрдэлд нь авч үзэх нь “Театрын урлаг”, “Театр” хэмээх соёлын үзэгдлийн обьектив хууль, зүй тогтол, түүхэн үйл явц, театрын менежмент, маркетинг, урын сангийн бодлого, үзэгчдийн эрэлт хэрэгцээг судалж, театрын өнөөгийн байдал, тулгамдсан асуудлуудад үнэлэлт дүгнэлт өгөх шаардлага бий болж байна.

Иймээс “театр” хэмээх ойлголтын нэг талд театрын урлаг, нөгөө талд нь түүнийг хүлээн авч хүртэн ойлгодог обьект болсон үзэгч түмэн байдаг.²⁷

Тэгвэл театр үзэгчээ хэрхэн бэлдэх вэ гэдэг асуудал дан ганц театрын урлагийн байгууллагуудын толгойны өвчин байх нь өрөөсгөл юм. Харин боловсролын бүх шатанд театрын боловсрол олгох тогтолцоог бий болгох, театрын боловсролын ач холбогдлыг багш сурган хүмүүжүүлэгч нарт ойлгуулан таниулах, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрт театрын боловсролын сургалтын аргагүйг нэвтрүүлэх зэрэг цогц ажлыг бодлоготойгоор хэрэгжүүлснээр бид урлаг, гоозүйн боловсрол бүхий ирээдүйн иргэнийг бэлдэх боломжтой болох юм.

ЕБС-ийн сурагчдад театрын урлагийн боловсрол олгох асуудлаар “Глоб Интернетшнл” ТББ, Нээлттэй нийгэм хүрээлэнгээс Соросын сангийн тусламжтайгаар 2004 онд “Урлагийн боловсрол” сэдвээр ЕБС /18 сургуулийн сурагчид/, СУИС, МУИС, МУБИС, Соёлын коллеж, Багшийн коллеж, Дорнод аймгийн багшийн коллеж,

²⁶ Боловсролын салбарын хууль тогтоомж УБ. 2012

²⁷ Авров Д. Н. Спектакль и зритель. М.: Просвещение, М., 1985

мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн оюутнууд болон багш сурагчид гэх мэт нийт 1512 хүнийг судалгаанд хамруулсан бөгөөд үүний 55 хувь нь сурагчид, 18 хувь нь багш нар, 27 хувь нь оюутнууд байсан. Энэхүү судалгаанд оролцсон хүмүүсийн 78 хувь нь театрын тухай ойлголт болоод ер нь урлагийн талаар ойлголт, урлагаас таашаал авах мэдрэмж байхгүй гэсэн дүгнэлт гарсан байна. Үүнээс харахад ЕБС-ийн сурагчдаас гадна өөр бусад хүмүүст урлагийн боловсрол нэн чухал хэрэгтэй байгааг баталж байна.

Мөн 2017 онд ТУС-ийн багш Г.Тунгалаг магистрын эрдэм шинжилгээний ажлын хүрээнд “Театрын урлагийн боловсрол олгох асуудал” сэдвээр судалгаа авсан. Судалгааны гол зорилго нь театрын урлагийн боловсролыг олгох арга зам, одоогийн нөхцөл байдлыг тогтооход чиглэгдсэн болно. Судалгааг 2 сар 10 хоног явуулсан бөгөөд судалгаанд ЕБС-ийн сурагчид болон багш нар нийт 965 хүн хамрагдсан. Судалгааны бүс нь Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн 3 сургууль, Хөвсгөл аймгийн 5 сургуулийн багш, сурагчид хамрагджээ. Үүнээс ЕБС-ийн сурагчид 84,8 хувь, ЕБС-ийн багш 15.2 хувийг эзэлжээ.

Судалгааны үр дүн:

- Урлаг соёлын мэдээллийг ямар эх сурвалжаас олж авдаг вэ? гэсэн асуултад 37 хувь нь интернэтээс, 16 хувь нь ном, сэтгүүлээс, 8 хувь нь багш нараас, 8 хувь нь эцэг эхээс, 17 хувь нь найз нөхдөөс, 14 хувь нь хэвлэл мэдээллийн хэрэгслээс авдаг.
- Танай сургуульд урлагийн ямар дугуйлан хичээллэдэг вэ? гэсэн асуултад 8 хувь нь уран зохиол, 14 хувь нь дүрслэх урлаг, 26 хувь нь дуу хөгжим, 22 хувь нь бүжиг, 22 хувь нь бусад төрлийн дугуйлангууд хичээллэдэг.
- Доорх урлагийн байгууллагуудаас алинд нь үзвэр үзсэн бэ? гэсэн асуултад 16 хувь нь УДЭТ-т, 30 хувь нь СТӨ-д, 11 хувь нь Хүүхэддэйн театрт, 0 хувь нь дуурийн театрт, 52 хувь нь кино театрт, 10 хувь нь бусад төрлийн үзвэрийн газруудад үзвэр үздэг.
- Хичээлд багш нар театрын урлагийн талаар мэдлэг олгодог уу? гэсэн асуултад 52 хувь нь “Байнга”, 7 хувь нь “Заримдаа”, 41 хувь нь “Огт олгодоггүй” гэсэн байна.
- Театрт жүжиг үзэх сонирхолтой юу? гэсэн асуултад 50 хувь нь “Сонирхолтой”, 50 хувь нь “Сонирхолгүй” гэсэн хариулыг өгсөн байна.

Үүнээс үзэхэд театрын урлагийн талаарх ойлголтыг бид ерөнхий боловсролын сургуульд туйлын бага олгож байгаа нь харагдаж байна.

Монгол улсын Төрөөс баримтлах Соёлын бодлогод “Сонгодог урлагийн заах арга зүйг Ерөнхий боловсролын сургуулиудын хичээлийн агуулгад оруулах, заах арга зүйг боловсронгуй болгох асуудал тулгарч байна²⁸. Иймд театрын боловсролыг нээлттэй, хүртээмжтэй олгох, театрын боловсролын заах арга зүйг боловсронгуй болгох шаардлагатай байна²⁹ гэсэн байна.

Энэ чиглэлээр урьд өмнө зохион байгуулж байсан ажлаас дурдвал монгол германы судлаачид хамтран 2008 онд судалгаа хийж “Хүүхэд театрын боловсрол хэлэлцүүлэг” сэдэвт төслийг боловсруулж хэрэгжүүлсэн байна. Тус төслийн хүрээнд хүүхдэд театрын боловсролыг хэрхэн хүртээмжтэй олгох, заах арга зүйг насны онцлогт тохируулан хүүхдэд театрын боловсролыг олгох талаар хэлэлцүүлжээ.

²⁸ Г.Тунгалаг “Монголын суурь боловсрол дахь театрын боловсролын асуудал”, ТУС-ийн багш нарын эрдэм шинжилгээний бага хуралд тавигдсан илтгэл., 2016 он.

²⁹ Монгол Улсын Их хурлын 2012 оны 5 дугаар сарын 22ны өдрийн 52 тоот “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого батлах тухай” тогтоол.

А.П.Ершова “Театрын боловсролын суурь нь ЕБС-ийн сурагчдад театр, жүжгээр дамжуулан урлагийн боловсрол олгох явдал юм”³⁰ гэжээ. Өөрөөр хэлбэл, урлаг нь өөртөө урлагийн боловсрол, театр, театрын боловсролыг агуулсан өргөн хүрээтэй ойлголт байна.

Театрын боловсролыг “жүжигчилсэн тоглолтын боловсрол” гэж нэрлэж байх бөгөөд educational drama эсвэл drama in education гэж хольж хэрэглэх тохиолдох байна. Энд нэг анхаарах зүйл нь жүжигчилсэн тоглолт гэдгийг театр (theatre) гэдгээс зааглаж байх бөгөөд “театр нь үзэгчтэй харилцахыг чухалчилж, үзэгчгүйгээр оршин байдаггүй бол жүжигчилсэн тоглолт нь хүүхдийг өөрийг нь бодитоор нь дадлага хийлгэхийг чухалчилж, заавал үзэгч байх шаардлагагүй”³¹ зэрэг ялгааг дурдаж болно.

Энэ асуудлыг шийдэх хэд хэдэн арга туршлага олон улсад байдгаас хамгийн хялбар арга нь ЕБС-ийн дэргэд драмын дугуйлан хичээллүүлэх явдал юм.

“Драмын дугуйлан”-гийн хөтөлбөр нь драмын урлагаар дамжуулж хүүхдийг бие даасан үйл ажиллагаанд сургаж, тэдний авьяасыг хөгжүүлэх, багаар ажиллах чадвартай болгох, драмын урлагийн бүтээлүүдтэй танилцуулж, улмаар ирээдүйн мэргэжлээ зөв сонгоход чиглүүлэх онцгой үүрэгтэй юм. Театрын боловсролоор дамжуулан хүүхдийг хөгжүүлнэ гэдэг нь драмын урлагийн суурь болох бие, хэл, сэтгэхүйн үйлдлийн урлагт суралцах явдал юм.³² Тиймээс жүжгийн дугуйлангийн сургалт нь 3 үндсэн ухагдахуунаас бүрдэнэ. Үүнд:

- **Сэтгэхүйн хөгжил**/Сэтгэхүйн хөгжлийн сургалтаар дамжуулан хүүхэд залуучуудын сэтгэлгээг задлан хөгжүүлж, театрын урлагийг ойлгон үнэлэх үнэлэмжийг дээшлүүлэх, авьяасыг хөгжүүлэх, анхаарлаа төвлөрүүлж сурах, сэтгэн бодох, учир шалтгаант үйлдэл, ургуулан бодох зэрэг чадваруудыг олгож, урлаг, уран зохиол, гоо зүйн зохих мэдлэгтэй, өөрийгөө илэрхийлэх чадвартай оюуны зохих чадавхтай бие хүн болгон төлөвшүүлэхэд оршино./
- **Биеийн хөгжил** /Биеийн хөгжлийн сургалтаар дамжуулан хүүхэд залуучуудын бие бялдрын уян хатан шинж чанарыг хөгжүүлж, бие сэтгэхүйн бариаг чөлөөлөх, өөрийн бодол санааг хөдөлгөөнөөр илэрхийлэх, хэм хэмнэлийн мэдрэмжийг хөгжүүлэх, нэгэн зэрэг сэтгэн бодох чадварыг сайжруулж бие хүн болгон төлөвшүүлэхэд оршино. Тус сургалт нь хүүхэд нэг бүртэй тулж ажиллах боломжийг олгодог. /
- **Хэл ярианы хөгжлийн хичээл** /ЕБС-ийн Монгол хэл, уран зохиолын хичээлээр үзэж буй мэдлэгийг ярих урлагтай холбон судалснаар сурагчдын сэтгэн бодох чадвар, түүнийгээ уран илэрхийлэх, зөв, утга төгөлдөр ярьж сургах, уран уншлагаар дамжуулан суралцагчдын амьдралыг танин мэдэх ухааныг төлөвшүүлж, оюун мэдлэгийн хүрээг өргөтгөхөд оршино./ зэрэг хичээлүүд багтана.

Мөн драмын дугуйланг хичээллүүлэх чадамжтай багш бэлдэх асуудал үүнээс урган гарч ирж байна. Үүнийг хоёр замаар шийдвэрлэж болох юм. Нэгдүгээрт, ЕБС-ын багш нарыг чадавхжуулан бэлдэх, Хоёрдугаарт, мэргэжлийн сургууль дээр багш бэлдэх.

Цаашилбал бид театрын боловсрол олгоход хэрэглэдэг сургалтын арга, аргачлалыг сургалтад нэвтрүүлснээр суралцагсдыг бүтээлч 21-р зууны иргэн болгон бэлдэх зорилгоо биелүүлэх ач холбогдолтой болох юм. Үүнд сургалтын шинэ арга барилаар дамжуулан бүтээлч сурагчийг хөгжүүлэх чадамж бүхий багшийг бэлдэх нь боловсролын салбарын бас нэг тулгамдсан асуудал гэж бид харж байгаа юм. Учир нь “Багш нь боловсролын

³⁰ Ершова А.П Уроки театра на уроках в школе. М. 1992

³¹ Кагава Ёшинари “Англи дахь жүжиглэсэн тоглолт боловсрол” (Орч Г.Батаа), 1998 он.

³² Неменский Б.М. Педагогика искусства. Москва, Просвещение, М.,2007

*орчныг зохион байгуулагч, хичээлийнхээ орон зайг харилцан үйлчлэлийн талбар болгон зохион байгуулдаг найруулагч байх ёстой*³³

Үүнд бид театрын боловсролын арга, аргазүйд суралцсан бүх шатны багш бэлдэх замаар хувь нэмрээ оруулах боломжтой юм. Театрын боловсрол нь театрын сурган хүмүүжүүлэх ухааны нэг хэсэг бөгөөд түүний зарчмын дагуу явах боловч зорилго, зорилтууд нь мэргэжлийн жүжигчин, найруулагчдыг бэлтгэх явдал биш юм. Харин театрын урлагаар дамжуулан сурагчдыг хувь хүн болгож төлөвшүүлэх зорилготой.

Багш-найруулагч бол орчин үеийн сургалтын онцгой асуудал юм.

Театрын боловсрол нь (урлагийн сурган хүмүүжүүлэх ухааны нэг хэсэг) амьд харилцааны нээлттэй бүтээлч орчныг бүрдүүлэхийг санал болгодог. Энэхүү урлаг, бүтээлч орчинд яриа хэлэлцээ нь ямар ч сэдвээр (шинжлэх ухаанаас шашин хүртэл) байж болох ч түүний зорилго нь дэлхийн цогц дүр зургийг бүрдүүлэх, оюутны сэтгэл хөдлөл, оюуны чадварыг нэгэн зэрэг хөгжүүлэх явдал юм.

Театрын боловсрол нь мэргэжлийн жүжигчний болон найруулагчийн сургалтад зориулж боловсруулсан дасгалын арга техникийг энгийн сургалтад нэвтрүүлэх боломжийг олгоно. танд анхаарал хандуулах, сайхан ярих, ангид болж буй үйл явдлын динамикийг мэдрэх боломжийг олгодог.

Театраар сурган хүмүүжүүлэх ухаан бол сургуулийг театрын урлагийн призмээр харах явдал юм. Түүний зарчмуудын нэг бол хичээл дээр хийж байгаа зүйл нь сурагчдад чухал байж тэдний сэтгэлийг нь хөдөлгөх ёстой. Хэрвээ хүүхэд ямар нэгэн сэдвийг сургуулийн сургалтын хөтөлбөрийн нэг хэсэг биш, харин амьдралын тухай яриа гэж үздэг бол тэр сургуулиас гадуур ч ном уншиж, кино үзэж, театрыг зорих болно.

Дүгнэлт:

Соёл урлагийн салбар дахь төрийн бодлого бүхэлдээ хувь хүн болон нийгмийн соёл, оюун санааны чадавхыг хөгжүүлэх, хэрэгжүүлэхэд анхаарлаа хандуулсан байдаг.³⁴ Даяарчлалын эрин зуунд амьдарч буй өнөө үед тайз, дэлгэцийн бүтээлийн олон урсгал чиглэлүүд монголын урлагийн салбарт бий болж, өнөөгийн түвшинд хүрсэн бөгөөд уран бүтээлчид төдийгүй хувь хүнээс гоо зүйн мэдрэмж, нийгмийн болон сэтгэлзүйн дасан зохицох чадвар, харилцааны чадавх, тэр дундаа биеийн эвсэл хөдөлгөөн, уян хатан шинж чанарыг түлхүү хөгжүүлэхийг шаардаж байна.

Уран бүтээлч хандлага нь театрын урлагийн амин чухал зүйлийн нэг юм. Ганц найруулагч биш бүх хамт олны бүтээл байдаг учир бүх оролцогчид сэтгэл зүрхээрээ үнэнчээр хандаж уран бүтээлч хамт олныг бий болгохыг багаас нь эхэлж ойлгуулж эзэмшүүлсэн байх нь чухал юм.

“Жүжгийн дугуйлан”-гаар дамжуулан “Театрын боловсрол”-ыг ЕБС-ийн сурагчдад олгосноор нийгэмд бусадтай чөлөөтэй харьцах /нүүр хагарсан/ чадвартай, урлагийг ойлгодог, урлагаас таашаал авч чаддаг үзэгч болон төлөвшихөөс гадна цаашилбал урлагийн мэргэжлийг сонгон суралцах чадвартай, анхнаасаа суурь мэдлэгтэй уран бүтээлч их сургуульд элсэн орох боломжтой, урлагт хайртай урлагийг ойлгодог, зөв үзэгчдийг төрүүлэн гаргах боломж юм.

Театрын боловсролыг ерөнхий боловсролын сургалтад нэвтрүүлэхэд багш нарыг чадавхжуулах зайлшгүй хэрэгцээтэй байгаа нь харагдаж байна. Театрын урлаг нь шинэ

³³ *Ершов П. М., Ершова А. П., Букатов В. М. Общение на уроке, или Режиссура поведения учителя. Библиотека педагога – практика. М.: Московский психолого- социальный институт, Флинта, 1998*

³⁴ *Монгол улс Хүүхдийн хөгжил, хамгаалалтыг сайжруулах үндэсний хөтөлбөр /2002 – 2010/ УБ. 2002*

цагийн олон талт зан чанарыг хөгжүүлдэг. Театр нь хувь хүнд орчин үеийн нийгэмд зайлшгүй шаардлагатай "зэвсэг"-ийн бүх хэрэглээг өгдөг - өөртөө итгэх итгэл, хүч чадал, өөрийн үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээх, өөрийн үзэл бодлыг хамгаалах чадвар гэх мэт. Энэ бол шинэ цагийн нийгэмд хамгийн эрэлт хэрэгцээтэй тийм л эвсэг зан чанар юм.

Өндөр хөгжилтэй орнууд болох Их Британи, Умард Ирландын нэгдсэн вант улс, Америкийн нэгдсэн улс, Япон улсуудын театрын боловсролын түүхэн хөгжил, төрөөс явуулж байгаа бодлогын талаарх судалгаанаас үзвэл Их Британи, Умард Ирландын нэгдсэн вант улс нь театрын боловсролыг жүжиглэсэн тоглолтын боловсрол (Drama in education) гэж нэрлэж 1. Тоглоом дасгал, хөдөлгөөн 2. Жүжиглэсэн тоглолт хийх. 3. Театр гэсэн гурван хэсгээр театрын боловсролыг олгодог. Мөн үндсэн хичээлийн хөтөлбөр театрын боловсрол олгох сургалт багтсан байна. Харин Америкийн Нэгдсэн улс нь Их Британи, Умард Ирландын нэгдсэн вант улсаас ялгаатай нь жүжиглэсэн тоглолт (бүтээлч ажиллагаа)-г хөгжүүлэн сурагчид жүжгийн зохиолыг өөрсдийн уран сэтгэмжээр баяжуулан бодох, багш нар түүнд дэмжин туслах байдлаар театрын боловсролыг олгодог. Япон улсын хувьд театрын боловсрол олгох асуудлыг төр засгаас дэмжин, судлаачдын хувьд сургалтын үндсэн хичээлд оруулах санал тавьж байгаа ч одоогоор үндсэн хичээлээр заадаггүй бөгөөд хичээлийн бус цагаар тусгай цаг хөтөлбөрийг хэрэгжүүлэн театрын боловсролыг олгож байна. Харин Монгол Улсын хувьд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам нь театрын боловсрол олгох талаар бодлого тодорхойлох, заавар журам батлах эрх зүйн орчин бүрджээ. Энэхүү хүрээнд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийг судалж үзвэл, театрын боловсролыг дэмжсэн төсөл, хөтөлбөр маш цөөн байгаа бөгөөд дэмжигдсэн төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт тааруу байна. Түүнчлэн Ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдын уран зохиолын сурах бичигт театрын боловсролтой холбоотой сонгодог жүжиг, зохиолууд багтсан боловч тус хичээлийн цаг нь хангалттай бус, ихэнх цаг нь монгол хэлний хичээлийг заах хэлбэрээр явагддаг. Ийм учраас Ерөнхий боловсролын хичээлийн хөтөлбөрт театрын боловсрол олгох тусгайлсан хичээлийн хөтөлбөр боловсруулах шаардлагатай. Ингэхдээ дараах хэлбэрээр театрын боловсролыг олгох боломжтой юм. Үүнд:

1. Театрын боловсрол олгох хичээлд бие халаах дасгал, тоглоомын арга зэргийг идэвхтэй сургалтын аргаар дамжуулан явуулах боломжтой байна.
2. Театрын боловсрол олгох хичээлийг Уран зохиолын хичээлээс гадна өөр бусад хичээлийн цаг дээр явуулах боломжтой байна.
3. Хичээлийн хөтөлбөрт тусгах боломжгүй тохиолдолд хичээлийн бус цагаар зохион байгуулах тусгай хичээлийн цагаар олон нийтийг хамарсан театр болон жүжгийн дугуйлан хэлбэрээр театрын боловсролыг олгох боломжтой юм.
4. Театрын боловсрол олгох хичээлийн хүрээнд Ерөнхий боловсролын сургуулиудын багш нарыг бэлтгэх, **Багш-найруулагч**-ийг бэлтгэхийг тулд соёл урлаг, театрын сургуулиас мэргэжлийн заах арга зүйн сургалтыг авах хэрэгтэй.

ЕБС-ийн сурагчдын театрын боловсролын түвшнийг судалснаараа сурагчдын театр урлагийн талаар хэр зэрэг мэдлэгтэй байгааг мэдэх ач холбогдолтойгоос гадна цаашид боловсролын салбарт ямар нэмэлт өөрчлөлт оруулбал зохих талаар санал хүсэлтийг тавих нь чухал юм. ЕБС-д сургалтын ямар систем баримтлах нь зохистой вэ? Хүүхдийг хэрхэн хөгжүүлэх вэ гэдэгт эрдэмтэн багш нар санал тавих цаашид боловсролын салбарынхан үүн дээр анхаарлаа хандуулах хэрэгтэй байна.

Ном зүй:

Монгол хэл дээр:

1. Боловсролын салбарын хууль тогтоомж УБ. 2012
2. Ганбаатар А, Урлагийн салбарт хэрэглэгдэж байгаа зарим гадаад нэр томьёо, үгсийн товч тайлбар УБ. 2012
3. Драммын урлагт хэрэглэдэг нэр томьёоны толь УБ. 2010
4. Ичинхорлоо Ш, Багш боловсролын үндэс УБ. 2010
5. Монголын театрын түүх УБ.2015
6. Монгол улс Хүүхдийн хөгжил, хамгаалалтыг сайжруулах үндэсний хөтөлбөр /2002 – 2010/ УБ. 2002
7. Монгол Улсын Их хурлын 2012 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 52 тоот “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого батлах тухай” тогтоол.
8. Соёл урлаг шинэ нөхцөлд VII УБ. 2012
9. Станиславский К.С, УБ. 2014
10. Театр 80 УБ. 2011
11. Г.Тунгалаг “Монголын суурь боловсрол дахь театрын боловсролын асуудал”, ТУС-ийн багш нарын эрдэм шинжилгээний бага хуралд тавигдсан илтгэл.,2016 он.
12. Кагава Ёшинари “Англи дахь жүжиглэсэн тоглолт боловсрол” (Орч Г.Батаа), 1998

Гадаад хэл дээр:

1. Авров Д. Н. Спектакль и зритель. М.: Просвещение, 1985
2. Афанасенко Е.Х., Ключев С.А. и др. Детский музыкальный театр. Программы, разработки занятий. Волгоград, «Учитель», 2008
3. Внеурочная деятельность школьников. Методический конструктор. М.: Просвещение, 2010
4. Гурков А.Н. Школьный театр. Ростов н/ Д., 2005
5. Ершов П. М., Ершова А. П., Букатов В. М. Общение на уроке, или Режиссура поведения учителя. Библиотека педагога – практика. М.: Московский психолого- социальный институт, Флинта, 1998
6. Ершова А.П. Уроки театра на уроках в школе. М., 1992
7. Ильев В. А. Когда урок волнует (Театральная технология в педагогическом творчестве). Пермь, 2008
8. Ильев В. А. Технология театральной педагогики в формировании и реализации замысла школьного урока. М.: АО «Аспект Пресс», 1993
9. Лаптева Г. В. Игры для развития эмоций и творческих способностей. Речь, 2011
10. Лебедева О. В. Преподавание искусства в школе: из опыта работы учителя музыки и мировой художественной культуры. Учебное пособие. Кострома: КГУ им. Н. А. Некрасова, М.,2008
11. Михайлова А. П. Театр в эстетическом воспитании младших школьников. М.: Просвещение, 1975.
12. Неменский Б.М. Педагогика искусства. Москва, Просвещение, М.,2007
13. Никитина А. Б. Культура древних цивилизаций. Игры. Упражнения. Открытые уроки. Учебно-методическое пособие. Серия «Теория. Методика. Опыт». Международный союз книголюбов, издательство «Книголюб», М., 2000
14. Мирошниченко Л. В. Психология театрального коллектива. Учебное пособие. Кемерово, 2010

Ярилцлага хэлэлцүүлэг:

1. Батсайхан.Ц “Театрын хөгжилд төрийн бодлого хэрэгтэй” Өглөөний сонин 2014.12.03
2. Мөнхдорж.Б “Театрт хүн өөрийгөө олж харна” 2016 оны 05 сарын 29-ний өдөр, Өдрийн сонин
3. МҮОНТ, 2014 оны 9 сарын 7 “Хүүхэд театрын боловсрол” хэлэлцүүлэг

Вэб сайт:

1. www.parliament.mn
2. www.legalinfo.mn
3. www.mecss.gov.mn
4. www.geijutsu.tsukuba.ac.jp
5. www.aate.org

МУЗЕЙН БОЛОВСРОЛЫН АЖЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Д.Мөнхтоогоо*
Г.Уугантуяа**

Хураангуй

Энэхүү өгүүлэлд музейн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийн нэг болох олон нийтийг гэгээрүүлэх, боловсролын ажил, үйл ажиллагааны талаар болон музейд боловсролын ажил хэрхэн хэрэгжүүлдэг, хэлбэр, ангилал, төрөл, ач холбогдлын талаарх ойлголтыг нэгтгэлээ. Монголын музейн боловсролын ажлын өнөөгийн байдлын дэлгэрэнгүй судалгаа, хөгжлийн түвшин, боловсролын ажилтны тоо, тулгамдсан асуудлыг тодруулах зорилгоор асуулгын аргаар улс, аймгийн 33 музейгээс судалгаа авч нэгтгэн гаргав. Музейгээс зохион байгуулж буй боловсролын ажил, олон нийтийг соён гэгээрүүлэх чиг үүрэг хангалттай түвшинд хүрэхгүй байна. Тухайлбал, боловсролын хөтөлбөрт зориулсан төсөв байдаггүй, зарим музейд орон тооны боловсролын ажилтан байхгүй, боловсролын өрөө танхимгүй, мэргэжсэн боловсон хүчин тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрэлдээгүй, цалин, хангамж бага, нийгмийн асуудлаа шийдэхэд музейгээс тус нэмэр болж чаддаггүй гэх мэт олон тулгамдсан асуудал байна. Тус судалгаагаар улс, аймгийн 33 музейн 20 (60%) нь үндсэн орон тооны боловсролын ажилтантай бусад нь өөр ажил хавсран хийдэг. Монголын музейн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлдэг зорилтот бүлэг нь ерөнхий боловсролын сургуулийн сурагчид бөгөөд жилд дунджаар 534 удаагийн давтамжтай нийт 24 099 хүн хамрагджээ. 2019 онд буюу ковидын хөл хорионы өмнө монголын музейг жилдээ 689 600 хүн музей үзсэн³⁵ бол энэний 3.5% нь боловсролын ажилд хамрагдсан байна. Энэхүү судалгааг хийснээр цаашид монголын музейн боловсролын ажлыг хэрхэн хөгжүүлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх ажлын цар хүрээ, хүртээмж чанарыг нэмэгдүүлэх талаар тодорхой санал дэвшүүлээ.

Түлхүүр үгс: музейн үүрэг, гэгээрүүлэх, өнөөгийн байдал, асуудал

Удиртгал

³⁵ Статистикийн мэдээллийн нэгдсэн сан.

https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NS0_2002_004V1&13999001_select_all=0&13999001SingleSelect=T2&SOUM_select_all=0&SOUMSingleSelect=&YearY_select_all=0&YearYSingleSelect=&viewtype=table 2022.03.24.

Эдүгээ дэлхий нийтийн музейн хөгжлийн чиг хандлага нь олон нийтийн оролцоотой, музей ба хүмүүсийн хамтын ажиллагаанд тулгуурласан, амралт танин мэдэхүйн цогц үйлчилгээ бий болгох үйл ажиллагаанд анхаарлаа хандуулж байна. Нийгэм, эдийн засаг, технологийн үсрэнгүй хөгжил дэвшил нь хүний хөгжлийн язгуур ойлголтуудыг бараг бүхлээр нь агшин зуурт өөрчилж буй бидний үед музей нь ард түмний уламжлалт мэдлэг, ухаан, соёл, түүхийн эд өлгийг цуглуулах, хадгалан хамгаалах, уугуул соёл хийгээд хүний мөн чанарыг хүмүүст эргэн сануулах, хүрээлэн буй орчны зохистой харьцааг тэнцвэржүүлэх эрхэм үүрэгтэй болжээ. Чухамдаа даяаршин буй дэлхийд онцгой шинжээ хадгалж басхүү даяаршилд “зөв” нэгдэхэд музейн соён гэгээрүүлэх үүрэг нь амин чухал байна.

Музейн боловсролын ажлын талаар Д.Цэдмаа 2001 онд музейн тулгамдсан асуудал өгүүлэлдээ музей нь танин мэдэхүйн төв болж нийгмийн хөгжилд нөлөөлдөг тухай, Д.Алтаннавч 2016 онд хүний хөгжилд музейн гүйцэтгэх үүргийн талаар, М.Болорцэцэг 2017 онд музейн боловсрол, олон нийтийн хөтөлбөрийн хөгжлийн асуудалд өгүүлэлдээ музейн боловсролын алба нэгжийн үүрэг, АНУ-н жишээ, ЕБС-ийн сурагчид ба музейн харилцаа, олон нийтийн оролцооны талаар, Д.Эрдмаа 2017 онд музейн үзмэрийг ерөнхий боловсролын сургуулийн газарзүйн сургалтад ашиглах нөөц боломж, 2018 онд музейн боловсролын ажилтны хөгжил ба хандлага, 2019 онд музейн боловсролын онолын зарим асуудалд гэсэн сэдвээр судалгаа хийн өгүүлэл бичиж байжээ. Монголын музейн боловсролын ажлын өнөөгийн байдлыг тодруулж, хэрэгжүүлж буй хөтөлбөрийн төрөл, зорилтот бүлэг, давтамж, хамрагдсан хүний тоог гаргаж цаашид хэрхэх талаар хийсэн судалгаа хараахан байхгүй байсныг энэхүү өгүүлэлээр нөхөхийг зорилоо.

“Музей” гэж соёлын үнэт зүйлийг бүртгэх, цуглуулах, хадгалж хамгаалах, судлах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх чиг үүрэг бүхий ашгийн төлөө бус соёл, эрдэм шинжилгээний байгууллага³⁶ юм.

Боловсрол гэж хувь хүний эзэмшсэн тогтолцоот мэдлэг, чадвар, “...мэдлэг боловсрол - сурч мэдсэн зүйлийн хэр хэмжээ юм. Тухайлбал,...хэлний боловсрол а. бичиж найруулах эрдэмд суралцсан байдал, б. гадаад хэл эзэмшсэн байдал³⁷-ийг хэлнэ.

Олон улсын музейн зөвлөл (ICOM-International Council of Museums) 1995 онд хийсэн тодорхойлолтдоо “Музей нь нийгэм, түүний хөгжилд үйлчилдэг, хүмүүст нээлттэй, хүн ба түүний амьдрах орчны бодит гэрч болох эд зүйлийг хүнийг гэгээрүүлэх, боловсрол олгох, оюун сэтгэлийн таашаал өгөх зорилгоор олж авах, цуглуулах, хадгалах, судлан шинжлэх, дэлгэн үзүүлэх, сурталчлах байнгын үйл ажиллагаа бүхий ашгийн бус байгууллага” хэмээн тодорхойлжээ. Тиймээс музей хүнийг гэгээрүүлэх, боловсрол олгох зорилгоор соёлын үнэт зүйлийг цуглуулж, түүгээр дамжуулан хүн төрөлхтний түүх, соёл, шинжлэх ухааны ололт амжилтын талаарх мэдлэг ухааныг олгодог нэг хэлбэрийн боловсролын байгууллага юм.

Орчин үед музейг хоёр үндсэн чиг үүрэгтэй гэж үздэг болсон ба нэг нь баримтжуулах, нөгөө нь гэгээрүүлэх юм. Гэгээрүүлэх чиг үүрэг хэрэгжүүлэхдээ боловсролын ажил, үйл ажиллагаа зохион байгуулж хэрэгжүүлдэг ба энэ талаар хууль, эрх зүйн бичиг баримтуудад дараах байдлаар тусгагдсан.

2015 оны 11 дүгээр сарын 17-нд Парис хотод зохион байгуулагдсан ЮНЕСКО-гийн 38 дугаар Ерөнхий бага хурал “Музей ба цуглуулгууд, тэдгээрийн олон төрөл болон нийгэмд гүйцэтгэх үүргийг хамгаалах, хөхиүлэн дэмжих тухай” зөвлөмжид “Боловсролын үйл ажиллагаа нь музейн үндсэн чиг үүргийн нэг юм. Музей нь боловсролын байгууллагууд, ялангуяа сургуулиудтай хамтран ажиллаж мэдлэгийг

³⁶ “Музейн тухай хууль”-ийн 4.1.1. <https://old.legalinfo.mn/law/details/16131> 2022.03.19.

³⁷ Монгол хэлний их тайлбар толь.

<https://mongoltoli.mn/search.php?opt=1&word=%D0%B1%D0%BE%D0%BB%D0%BE%D0%B2%D1%81%D1%80%D0%BE%D0%BB> 2022.03.19.

түгээх, боловсролын болон сурган хүмүүжүүлэх хөтөлбөрөөр дамжуулан албан, албан бус ба насан туршийн боловсролын үйл ажиллагаанд оролцоно” хэмээн зөвлөжээ³⁸.

Монгол улсын музейн тухай хуулийн музейн үйл ажиллагааны чиглэл бүлгийн 7.1.6. боловсрол, танин мэдэхүйн ажил зохион байгуулах гэж бий. Музейн стандартын 15.1-д музей нь иргэд залуучуудад зориулсан боловсролын ажлын хөтөлбөр, арга зүйг боловсруулж хэрэгжүүлнэ. 15.2-т Боловсролын ажлыг оролцогчдод хүртээмжтэй, үр ашигтай байхаар зохион байгуулна³⁹ гэж заасан байдаг. Тэгэхээр музей олон нийтийг гэгээрүүлэх, боловсрол олгох ажлаа хэрэгжүүлэхдээ төрөл бүрийн боловсролын ажил, үйл ажиллагаа зохион байгуулдаг.

Музейн боловсролын ажлын талаарх ойлголт

Музейн соёл, боловсролын ажлын тухай ойлголт нь Европын орнуудад 1980-1990-ээд оны зааг дээр нийгмийн музей, соёлын өвд хандах хандлага шинэ үе шатанд шилжиж, музейг харилцааны хандлага, боловсролын үндсэн дээр загварчлан үзэх үед гарч ирсэн. Музей нь хүний бүтээлч чадавхыг хөгжүүлэх, түүний үнэ цэнгийн чиг хандлагыг төлөвшүүлэх чухал хэрэгсэл гэж тооцогддог. Бие даасан чиглэл болохын хувьд олон нийттэй харилцах ажил нь 1920-иод оны хоёрдугаар хагасаас соёл, боловсролын ажил гэж нэрлэгддэг байв. Боловсролын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх, тодорхой хэлбэрийн арга, агуулгыг боловсруулахын тулд музей нь үзэгчдийг судалж, үүний дагуу янз бүрийн бүлгийн зочдод ялгаатай хандах хандлагыг бий болгох нь чухал юм⁴⁰.

Дэлхийн олон оронд бүх нийтийн боловсролын түвшинг дээшлүүлэхэд боловсролын байгууллагаас гадна бусад олон хэлбэр боломжийг ашигладаг. Албан бус сургалтын хүрээг өргөжүүлснээр хүн амын боловсролын ерөнхий түвшинг дээшлүүлэх, нэгэнт олж авсан боловсролыг нэмж баяжуулах, хувь хүн бие дааж сурч боловсрох өргөн боломж нээгдэнэ. Хүн сурч боловсроход байнга дэмжиж нөлөө үзүүлдэг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, номын сан, архив зэрэг соёл, шинжлэх ухааны байгууллагуудаас музейн үүрэг нэн чухал байдаг⁴¹.

Музейн үзмэр, цуглуулга нь олон нийт тэр дундаа хүүхэд, залуучууд оюун ухаанаа цэнэглэн баяжуулах, ойлгон ухаарах, дүгнэлт гаргах, сургамж авах маш олон талын мэдээллийг өөртөө агуулж байдаг. Музейд аливаа сэдвийг бодит баримт нотолгоонд тулгуурлан үзүүлж, тайлбарлан таниулдаг нь үзэгчдэд илүү бодитой, сонирхолтой учраас тогтоож ойлгоход хялбар байдаг. Хүн амыг гэгээрүүлэх музейн зорилтоос үүдэн "музейн сурган хүмүүжүүлэх ухаан" гэдэг шинжлэх ухааны шинэлэг салбар хөгжиж байна. Өндөр хөгжилтэй орнуудын музейд сурган хүмүүжүүлэгч гэсэн орон тооны ажилтан ажилладаг бөгөөд боловсрол танин мэдэхүйн тусгай хөтөлбөрийн дагуу цогц арга хэмжээ явуулдаг⁴².

Музейн боловсролын үйл ажиллагааны хэлбэр:

- Сургалт, нүүдлийн болон суурин үзэсгэлэн, лекц, семинар, давтан сургалт, дугуйлан, урлагийн тоглолт, фестиваль, өдөрлөг, үдэшлэг зэрэг байна.
- Хүүхэд, олон нийтэд зориулсан музейн хэвлэмэл сэтгүүл, гарын авлага бэлтгэж, музейд зохион байгуулах ажилд хэрэглэж байна. Түүнчлэн сүүлийн үед гараар барьж, сэтгэлдээ шингээх дадлагын аргыг музейн боловсролын ажилд түлхүү нэвтрүүлж байна.

³⁸ ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний комисс. Баримт бичгийн эмхтгэл, ЮНЕСКО-гийн тунхаглал, конвенц, зөвлөмж. –УБ., 2015. –Х.8.

³⁹ Монгол Улсын стандарт: Гар урлал болон урлагийн зориулалттай зүйлс, музейн үйл ажиллагаанд тавих шаардлага. заалт 12.7.1. MNS5634:2006, -УБ., 2006. -Х. 13.

⁴⁰ Российская музейная энциклопедия. http://www.museum.ru/rme/mb_cult.asp 2022.03.23

⁴¹ Цэдмаа Д. Музейн тулгамдсан зарим асуудалд //Музей судлал Т. I (IV).F-10. Эрхэлсэн Идшинноров.С. – УБ., 2001. –Х. 82.

⁴² Цэдмаа Д. Музейн тулгамдсан зарим асуудалд //Музей судлал Т. I (IV).F-10. Эрхэлсэн Идшинноров.С. – УБ., 2001. –Х. 83.

- Албан ёсны цахим талбарт боловсрол, олон нийтийн үйл ажиллагааг мэдээлэх, холбоо тогтоох, мэдээллийн эх сурвалжийг нийтлэх гэх мэт.

Улс орны хөгжлийг эдийн засгийн хөгжилтөөр нь хэмжих ерөнхий үнэлгээ байх боловч хүний оюун ухааны хөгжил нь юунд ч үл захирагдаггүй хүчин зүйл тул хэзээд нийгмийн хөгжлөөс түрүүлж явдаг жамтай. Монголын музей бидний оюун санааны хөгжилд үлэмж ихийг өгч чадна. Музейг нийтийн хүртээл болгох нь музейн ажилтны эрхэм үүрэг бөгөөд тэдгээрээс суралцах нь иргэдийн оюуны өндөр хэрэглээ болох ёстой⁴³.

Музейн зорилго нь сан хөмрөг түүнд агуулагдаж байгаа мэдээлэл, мэдлэгийг олон нийтэд, бүх насны хүмүүст хүртээх, мэдлэг ба соёлд тэднийг оролцуулахад оршдог. Иймд музейн үйл ажиллагаа олон нийт, тэдний боловсролд зориулагдах нь чухал ач холбогдолтой. Албан бус боловсролын нэг болохын хувьд музей дунд сургууль, дээд боловсролын тогтолцоонд үнэтэй хувь нэмэр оруулдаг ба хүүхдийн мэдлэгийн хүрээг тэлж, тэдэнд суралцах, хөгжилдөн цэнгэх, хэлэлцэх олон төрлийг санал болгодог⁴⁴.

Музей бүх насныханд зориулагдсан, суралцах боломж олгодог, нээлттэй, чөлөөтэй үзэж, бусадтай харилцаж байдаг, нийтлэг бүлгийн сургалтын хэвшмэл орчноос ялгаатай, бие дааж өөрөө таашаан сонирхох, хөгжих боломжтой, мэдээллийг гүнзгийрүүлэн судлах, эрэл хайгуул хийх хүслийг төрүүлж байдаг нийгмийн хөгжилд чухал нөлөө үзүүлдэг танин мэдэхүйн төв юм. Үйл ажиллагааны үр дүн нь хүний оюун санаанд нөлөөлж мэдлэгийг нь дээшлүүлж танин мэдэхүйн цар хүрээг тэлж өргөжүүлэхэд чиглэдэг⁴⁵.

Нийгмийн шинэчлэлт, хүний оюуны хэрэгцээ өсөн нэмэгдэхийн хирээр уламжлалт соёлын өв, түүхээ сонирхох, судлах хүрээ өргөссөөр байна.

Боловсролын ажилтан нь багш нар байж болох бөгөөд гол шаардлага нь музей ба боловсролын чиглэлээр суралцсан байх юм⁴⁶. Музейд олон төрлийн мэргэжилтнүүд ажилладаг ч нийгэмд хандсан энэ үйлчилгээг хөтлөн явуулах “Боловсролын ажилтан”-тай байх нь тухайн музейн хувьд маш их ач холбогдолтой. Магадгүй, музейн боловсролын ажилтан нь багш, сэтгэл зүйч байж болох хийгээд гагцхүү музейн үзүүлэлт, үзмэрийн талаарх цогц агуулгыг хүмүүст танилцуулж чаддаг, мэдлэг, туршлага хуримтлуулсан байх хэрэгтэй билээ.

Музейн боловсролын ажил нь “музейн үзмэр, цуглуулга-музейн ажилтан-оролцогч” гэсэн харилцан хамааралтай явагддаг. Боловсролын ажлыг насны ангилал, гэр бүл, зорилтот бүлэг, ажил мэргэжлийн онцлогт тохируулан хөтөлбөр төлөвлөж хэрэгжүүлдэг. Үүнд:

Зохион байгуулалт

- Музейд
- Музейгээс гадуур

Зорилтот бүлэг

- 2-6 нас
- 6-10 нас /ЕБС-ийн бага анги/
- 10-14 нас /ЕБС-ийн дунд анги/
- 14-16 нас /ЕБС-ийн ахлах анги/
- Их, дээд сургууль, коллежийн оюутан, залуус
- Ахмад настан
- Гэр бүл

⁴³ Цэдмаа Д. Музейн тулгамдсан зарим асуудалд //Музей судлал Т. I (IV).F-10. Эрхэлсэн Идшинноров.С. – УБ., 2001. –Х. 83.

⁴⁴ Музейг эрхлэх нь: Практик гарын авлага. Олон улсын музейн зөвлөл. –УБ., 2014. –Х. 121.

⁴⁵ Алтаннавч Д. Хүний хөгжилд музейн гүйцэтгэх үүрэг. //Музей судлал Т.XVII.F-2. Эрхэлсэн Д.Бумаа. – УБ., 2016. –Х. 9.

⁴⁶ Музейг эрхлэх нь: Практик гарын авлага. Олон улсын музейн зөвлөл. –УБ., 2014. –Х. 122

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэд
- Байгууллага, хамт олон

Хэлбэр

- Байнгын үзүүлэг
- Түр үзэсгэлэнд
- Үзмэрт тулгуурласан
- Цахим буюу Online, Digital

Музейгээс зохиож буй бага, өсвөр насны хүүхдүүдэд зориулсан хөтөлбөр юуны өмнө тэдний насны болон сэтгэл зүйн онцлогийг сайтар судалсны үндсэн дээр хэрэгжих ёстойг тооцох нь чухал.

Сургуулийн өмнөх насны болон бага ангийн хүүхдүүдэд зориулсан хөтөлбөрийг боловсруулах нь чухал байдаг. Учир нь тэдэнд “музей” гэж ямар онцлогтой байгууллага юм, музейг тэдний хэрэгцээ болгож мэдлэг боловсролоо дээшлүүлэх, чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлж болох газар мөн гэсэн ойлголт өгөх шаардлага гардаг. Үүний зэрэгцээ дэлхийн соёлд музейн эзлэх байр суурь, түүх соёлын дурсгалт зүйлийг таньж бусад хэрэглээний зүйлээс ялгаж сургах зорилго тавигддаг. Энэ үедээ хүүхдүүд хийсвэр сэтгэлгээ нь хөгжөөгүй, эд юмсыг байгаагаар нь хүлээж авдаг ажигламтгай, гярхай, сониуч байдаг. Тиймээс эд зүйлийг нарийвчлан харах сонирхлыг нь хөгжүүлэх чухал. Ой санамжийг нь сайжруулах, уран сэтгэмжийг хөгжүүлэх, харьцуулах, ажиглалт хийлгэж нарийн зүйлийг харж сурах дасгал хийлгэснээр дүрслэх урлагийн хэллэгийг ойлгох анхны алхмыг хийдэг. Бага насны хүүхэд хэдий чинээ эрт музейтэй харьцаанд орно нийгэм хүмүүжлийн үр дүн нь төдий чинээ өндөр үр өгөөжтэй байдаг нь практик дээр нотлогддог. Бага насны хүүхдэд зориулагдсан хөтөлбөрийг музей хэрэгжүүлснээр ирээдүйн музейн үзэгчийг бэлдэж музей үзэх нь тэдний хувьд амьдралын зайлшгүй шаардлага болох болно.

ЕБС-ийн дунд болон ахлах ангийн сурагчдад зориулсан хөтөлбөр нь үнэн зөв мэдээлэл өгөхөд тулгуурлана, харж үзсэн зүйлээсээ мэдээлэл авч сурах, харилцаанд орж ярилцаж үзэл бодлоо илэрхийлж сурахад чиглэсэн байна. Үүний зэрэгцээ шилжилтийн насны хүүхдүүд өөрийн мэдлэгээрээ бусдаас ялгарах, байр сууриа илэрхийлж урьд өмнөх үеийнхний хийж бүтээснийг шүүмжлэлт өнцгөөс харах хандлагатай байдаг төдийгүй, дүгнэлт хийж, илүү нотолгоо шаарддаг. Музейн бодит үзмэр энэ бүхний хариулт болдог.

Олон нийтэд зориулсан хөтөлбөр нь музейг нийтийн хүртээл болгох, иргэдийн боловсрол, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, музейтэй хамтран ажиллах, музейн үзэгчдийг өргөтгөхөд чиглэгдсэн байх шаардлагыг хангасан байна. Үүнийг хэрэгжүүлж чадвал үзэгчдийн мэдлэг мэдээллийг баяжуулж, сэтгэл ханамжийг төрүүлж, шинэ үзэгчдийг дуудаж, дахин ирэх хүсэл эрмэлзлийг төрүүлэх болно. Ингэхийн тулд:

- Олон нийтийн эрэлт хэрэгцээнд анхааралтай хандаж судлах,
- Бүтээлч хандлагыг өрнүүлэх хэрэгтэй⁴⁷.

Боловсрол хүмүүжлийн үүргээ эрдэм шинжилгээ судалгааны ажилд үндэслэн музейн эд зүйлс дэх мэдлэгийг үзэгчдэд түгээн хэрэгжүүлэх болсон⁴⁸.

Музей судлаач М.Ю.Юхневич “Хувцасны үндсэн суурь загварт тулгуурлан олон янзын хувцасны загвар буй болдог. Энэхүү загвар зохион бүтээх ажиллагааны нэгэн адил музейн соёл боловсролын ажилд олон суурь хэлбэр байдаг. Үүнд тайлбарт аялал, лекц, зөвлөгөө, эрдэм шинжилгээний бага хурал, чуулган, хурал, клуб дугуйлан, студи, уралдаан тэмцээн, олимпиад, асуулт хариултын тэмцээн, сонирхолтой хүмүүстэй уулзах, концерт, утга зохиолын үдэшлэг, театрчилсан тоглолт, кино үзвэр, баяр ёслолын үйл

⁴⁷ Алтаннавч Д. Хүний хөгжилд музейн гүйцэтгэх үүрэг. //Музей судлал Т-ХVII. F-2. Эрхэлсэн Д.Бумаа. – УБ., 2016. –Х. 15.

⁴⁸ Цэндсүрэн Ц нар, Музей судлалын үндэс. –УБ., 2010. –Х.205.

ажиллагаа, түүхчилсэн тоглолт зэрэг болно” гэж бичсэн байдаг⁴⁹.

Монголын музейн боловсролын ажлын өнөөгийн байдал

Монголын Үндэсний түүхийн музейд анх удаа 2000 оноос албан ёсны, орон тооны боловсролын ажилтан ажиллуулж эхэлсэн⁵⁰. 2006 онд музейн стандартад боловсролын ажилтныг музейд шаардлагатай жишиг орон тоонд оруулснаар Монголын музейн боловсролын ажлын хөгжлийн шинэ шат эхэлсэн. Монголын Улс, аймгийн 33 музейгээс 2022 оны 3 сарын 19-24-ны өдрүүдэд авсан судалгаанаас харахад нийт музейгээс үндсэн орон тооны боловсролын ажилтантай 20 буюу 60%, бусад нь тайлбарлагчийн ажлыг хавсран хийдэг байна. Бүх музейн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлдэг зорилтот бүлэг нь ерөнхий боловсролын сургуулийн сурагчид бөгөөд жилд дунджаар 534 удаагийн давтамжтай нийт 24 099 хүн хамрагджээ. 2019 онд буюу ковидын хөл хорионы өмнө монголын музейг жилдээ 689600 хүн музей үзсэн⁵¹ бол энэний 3.5% нь боловсролын ажилд хамрагдсан байна. Хамгийн олон удаа боловсролын хөтөлбөр зохион байгуулж олон хүн хамруулсан нь Монголын Үндэсний музей, Богд хааны ордон музей, Монгол цэргийн музей байна. Боловсролын хөтөлбөр амжилттай зохион байгуулахад олон хүчин зүйлс нөлөөлдөг. Тухайлбал, музейн байршил, тухайн орон нутгийн хүн амын нягтрал, үндсэн орон тооны боловсролын ажилтантай эсэхээс шалтгаалдаг. Дээрх үзүүлэлтийг хүснэгт 1-д нэгтгэн харуулав.

Хүснэгт 1: Монголын музейнүүдийн боловсролын ажил болон боловсролын ажилтны судалгаа

№	Музейн нэр	Үндсэн орон тооны	Шилдэг боловсролын хөтөлбөрийн нэр	Зорилтот бүлэг	Нэг жилд хийдэг ажлын тоо	Хөтөлбөрт хамрагдсан тоо
Улсын музей						
1	Монголын Үндэсний музей	2	Монгол наадгай, Алтан соёмбо, Ухаант цэцэн хүүгийн музейн аялал	Бүх нас, ЕБС, Гэр бүл	127 удаа	7 633
2	Байгалийн түүхийн музей	1	Бяцхан палеонтологич, Үндэсний бахархалт шувуу	ЕБС	9 удаа	300
3	Богд хааны ордон музей	1	Заан, 12 жил	ЕБС	31 удаа	1 800
4	Чойжин ламын сүм музей		Авдар дахь музей	ЕБС	11 удаа	420
5	Дүрслэх урлагийн музей	1	Хайрцаг дахь музей, Мутарлагаар өөрийгөө илэрхийлэх нь	Бүх нас, ЕБС	10 удаа	500
6	Монголын театрын музей	1	Хүүхэддэйн урлаг	СӨН, ЕБС	8-12 удаа	300
7	Уран зургийн галерей	1	Хөгжимтэй зураг	ЕБС, насанд хүрэгчид	24 удаа	680
8	Монгол цэргийн музей		Монгол улсын тусгаар тогтнол ба Халхын голын дайн, Төрийн далбаа	ЕБС, цэргийн алба хаагчид	13 удаа	1 582

⁴⁹ Цэндсүрэн Ц нар, *Музей судлалын үндэс*. –УБ., 2010. –Х.209.

⁵⁰ Эрдмаа Д. Юмчмаа Г нар. *Музейн боловсролын ажилтны хөгжил ба хандлага. // Музей судлал Т-ХІХ-І. Fask-20, Эрхэлсэн Д.Бумаа*. –УБ., 2018. –Х.199.

⁵¹ *С татистикийн мэдээллийн нэгдсэн сан.*

https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_2002_004V1&13999001_select_all=0&13999001SingleSelect=T2&SOUM_select_all=0&SOUMSingleSelect=&YearY_select_all=0&YearYSingleSelect=&viewtype=table
e 2022.03.24.

9	УБ хотын музей	1	Баатар хот	ЕБС, Гэр бүл	7-10 удаа	420
10	Хөшөө цайдам музей	1	Билгэ хаан, Култегин жанжин нарын тахилын онгон	ЕБС	11 удаа	700
Аймгийн музей						
11	Архангай	1	Түүхийн жимээр	ЕБС, Гэр бүл	8-10 удаа	360
12	Баян-Өлгий		Сүүлийн Пандемиягийн үед	ЕБС, Гэр бүл	7 удаа	200
13	Баянхонгор		Динозавр	ЕБС	6-8 удаа	250
14	Булган	1	Буриад ёс заншил	ЕБС	12 удаа	400
15	Говь-Алтай		Үл хөдлөх дурсгалаа хамгаалцгаая	ЕБС	8 удаа	500
16	Говьсүмбэр	1	Боржигон байшин	ЕБС	15 удаа	397
17	Дархан-Уул	1	Мандала, Уламжлалт наадгай	ЕБС	8-10 удаа	241
18	Дорноговь		Гэр бүлийн өдөр	ЕБС	16 удаа	600
17	Дорнод	1	Бяцхан археологич, Талын амьтад	СӨН, ЕБС	12 удаа	560
19	Дундговь аймгийн музей		Уламжлалт тоглоом наадгай, Эрт галавын амьтан Говь нутагт	СӨН, ЕБС	13 удаа	484
20	Завхан	1	Өв соёлоо дээдэлье	СӨН, ЕБС	15 удаа	500
21	Орхон		Уламжлалт тоглоом наадгай, Урлах эрдэм	ЕБС	9 удаа	349
22	Өвөрхангай	1	Бидний мэдэх Өвөрхангай хөлөгт тоглоом	СӨН, ЕБС	13 удаа	580
23	Өмнөговь	1	Би монгол	СӨН, ЕБС	17 удаа	510
24	Сүхбаатар		Монгол гэр, Эх хэл үндэсний дархлаа	СӨН, ЕБС	18	500
25	Сэлэнгэ		Түүхийн жимээр аялал	Гэр бүл, ЕБС	6 удаа	240
26	Төв аймгийн музей		Соёлын өв гэж юу вэ?, Төв аймгийн түүх болон хөгжил, соёлын өвийн дурсгал, Манзуширын хийд	ЕБС	15 удаа	461
27	Увс аймгийн музей		Улаангом хотны түүх соёлын дурсгалыг танилцуулах хөтөлбөр	Гэр бүл, ЕБС	6 удаа	180
28	Ховд аймгийн музей	1	Олон угсаатны соёлын өв, Уламжлалт тоглоом наадгай	Гэр бүл, ЕБС	8-10 удаа	330
29	Хөвсгөл		Цаа буга, Бяцхан археологич	Гэр бүл, ЕБС	12 удаа	420
30	Хэнтий		Эх түүхээ түгээн дэлгэрүүлэе	Гэр бүл, ЕБС	8-10 удаа	300
31	Хархорин музей	1	Мөнх тэнгэрийн босоо бичиг	Гэр бүл, ЕБС	13 удаа	450
32	Эрдэнэзуу музей	1	Эх түүхийн эзэд, Хархорины ТСД-ыг таниулах аялал	Гэр бүл, ЕБС	10 удаа	520
33	Ялалт музей		Эр цэрэг-Эх орон, Мөнхөд дуурьсагдах алдар	ЕБС, цэргийн албан хаагч	11 удаа	432
		20			534	24 099

МҮМ-н боловсролын ажилтны ажлын байрны тодорхойлолтын зорилгод “Музейн сан хөмрөг, үзүүлэг, түр болон байнгын үзэсгэлэнд түшиглэн соёл, боловсрол, олон нийтийн хөтөлбөр хэрэгжүүлэх, музейн олон нийт, боловсрол, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах, музейн цуглуулгын сурталчилгааны сан бүрдүүлэхэд чиглэнэ” хэмээн заасан байдаг.

2002 онд Монголын Үндэсний музей (МҮМ)-ээс “Монголын амьд түүх” нэртэй дунд сургуулийн 7, 8-р ангийн багш, сурагчдад зориулсан музей дээр хийх сургалтын хөтөлбөр монголын түүхийн багц материал боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн. МҮМ-н боловсролын ажилд байнгын үзүүлэг, тусгай үзэсгэлэн /дотоод, гадаад/, тайлбарт аялал, олон нийт, боловсролын хөтөлбөр, цуврал лекц, дижитал хэлбэрээр олон нийтэд хүргэж буй үзмэр, үзүүлэгийн мэдээлэл зэрэг багтдаг. МҮМ-н боловсролын ажилд 2019 онд нийт 7633 хүн хамрагдсанаас музейгээс гадуур хэрэгжүүлсэн боловсролын хөтөлбөрт 1102, музейд зохион байгуулсан боловсролын хөтөлбөрт 4982, тусгай хэрэгцээт иргэдэд /харааны бэрхшээл/ зориулсан боловсролын хөтөлбөрт 45 хүн хамрагджээ.

Музейн боловсролын ажил нь тухайн сэдэвт холбогдох музейн үзмэр, цуглуулгыг дэлгэрэнгүй тайлбартай үзсэний дараа өөрсдөө хийх, зурж будах, наах, дахин харилцан ярилцах гэх мэт идэвхтэй үйл ажиллагаанд хамрагдаж, үзсэн сонссоноо бататгаж, нэмэлт мэдээлэл авч байдгаараа илүү үр өгөөжтэй мэдлэг болдог. Музейгээс гадуур зохион байгуулах боловсролын ажил нь үзэгчдээ хүлээлгүй тэдэнд хүрч үйлчлэх нь тэдэнд илүү ойртох, музей үзэх хүслийг төрүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой ажлын нэг хэлбэр юм. Ийм төрлийн ажлыг алслагдсан дүүрэг, тусгай хэрэгцээт иргэд, хүүхдийн зуслан, амралт, сургууль цэцэрлэг, албан байгууллага гэх мэт газруудад музейн ажилтнуудад хүрэлцэн очиж зохион байгуулах өргөн боломжтой. МҮМ-н хувьд “Монгол наадгай”, “Алтан соёмбо”, “Монгол гэр” гэх мэт боловсролын хөтөлбөрүүдийг энэ төрлийн үйл ажиллагаанд хэрэгжүүлдэг. Музейн олон нийтийн хөтөлбөр нь боловсролын ажилтай харьцуулбал олон нийтийг хамарсан томоохон арга хэмжээ юм. Монголын музейн зохион байгуулдаг олон нийтийн хөтөлбөрөөс дурдахад МҮМ-н зохион байгуулдаг цуврал лекц, “Өглөөний музей” аян, “Музейн өдөр” арга хэмжээ, Чойжин ламын сүм музейн “Шөнийн музей” зэрэг юм.

Тулгамдсан асуудал

Монголын музейн боловсролын ажлын өнөөгийн байдалд шинжилгээ хийн дараах тулгамдсан асуудал байна гэж үзэж байна. Үүнд:

- Нийт музейд боловсролын хөтөлбөрт зориулсан төсөв байдаггүй,
- Зарим музейд орон тооны боловсролын ажилтан байхгүй,
- Боловсролын ажилтны орон тоо байхгүй шалтгаан нь мөн цалингийн сан нь хүрдэггүй, Эдгээр музейд тайлбарлагч, арга зүйч эсвэл эрдэм шинжилгээний ажилтан боловсролын ажлыг хийдэг, ажлын ачаалал их,
- Боловсролын өрөө танхим байдаггүй учир үзмэрийн танхим эсвэл сургууль дээр боловсролын ажлаа хийдэг,
- Ихэнх музей боловсролын ажлаа түүх соёлын сэдвээр явуулдаг ба ихэнх нь ерөнхий боловсролын сургуульд, цөөхөн тохиолдолд их дээд сургуулийн оюутнуудад зориулсан байдаг,
- Монгол улсад музейг соёлын байгууллага гэж үздэг тиймдээ ч музейг соёлын асуудал хариуцсан яам харъяалж байна. Олон оронд музейг мөн боловсролын байгууллага гэж үздэг. Музей нь бүх насны хүмүүст зориулан боловсролын хөтөлбөр зохиодог насан туршийн боловсролын байгууллага юм⁵². /М.Болорцэцэг, 2017/
- Боловсролын ажлын хүртээмж, ач холбогдлыг үнэлэх механизм байхгүй гэх мэт.

⁵² Болорцэцэг М. Музейн боловсрол, олон нийтийн хөтөлбөрийн хөгжлийн асуудалд //Музей судлал Т.XVIII (I).F-11. Эрхэлсэн Д.Бумаа. –УБ., 2017. –Х.106.

Дүгнэлт

Манай орны хувьд орчин цагийн музей байгуулагдаад өдгөө 98 жил болж энэ хугацаанд тодорхой түвшинд хөгжсөөр ирсэн боловч музейгээс зохион байгуулах боловсролын ажил, олон нийтийг соён гэгээрүүлэх чиг үүрэг хангалттай түвшинд хүрэхгүй байна. Тухайлбал, боловсролын хөтөлбөрт зориулсан төсөв байдаггүй, зарим музейд орон тооны боловсролын ажилтангүй, боловсролын өрөө танхимгүй, мэргэшсэн боловсон хүчин тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрэлдээгүй, цалин, хангамж бага, нийгмийн асуудлаа шийдэхэд музейгээс тус нэмэр болж чаддаггүй гэх мэт олон тулгамдсан асуудал байна.

Тус судалгаагаар улс, аймгийн 33 музейн 20 (60%) нь үндсэн орон тооны боловсролын ажилтантай бусад нь тайлбарлагчийн ажлыг хавсран хийдэг байна. Бүх музейн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлдэг зорилтот бүлэг нь ЕБС-ийн сурагчид бөгөөд жилд дунджаар 534 удаагийн давтамжтай нийт 24 099 хүн хамрагджээ. 2019 онд буюу ковидын хөл хорионы өмнө монголын музейг жилдээ 689600 хүн музей үзсэн бол энэний 3.5% нь боловсролын ажилд хамрагдсан байна.

Цаашид дараах ажлуудыг хийж хэрэгжүүлснээр музейн боловсролын ажлын цар хүрээ, хүртээмж, чанар нэмэгдэх боломжтой. Үүнд:

1. Музейн боловсрол олон нийтийн ажилд зориулсан төсөвтэй болгох: Музей бүр боловсролын өрөө зориулалтын тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүнтэй болох, музейд боловсролын алба нэгжийг бий болгох
2. Музейн боловсролын ажилтныг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх боломжийг яамнаас бодлогоор дэмжих, орон тоо, цалингийн санг шийдвэрлэх, сургалтад хамрагдаж, мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах боломжоор хангаж өгөх,
3. Боловсролын хөтөлбөрийн агуулгыг зөвхөн түүх соёлоор хязгаарлахгүйгээр урлаг, байгаль орчин, шинжлэх ухааны танин мэдэхүйн чиглэлүүдээр өргөжүүлэх, энэ тал дээр бусад салбар шинжлэх ухааны зүтгэлтнүүдтэй хамтран ажиллах
4. Хамтын ажиллагааг дотоод, гадаад бүхий л хэлбэрээр хөхиүлэн дэмжих: Үзэсгэлэн зохион байгуулах ажилд олон нийтийг татан оролцуулах болон сайн дурын ажилтныг музейд сургах нь музейн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангаж буй хэрэг юм⁵³ музейн боловсролын хөтөлбөр ЕБС-ийн хичээлийн хөтөлбөрийн уялдааг сайжруулах, музейн идэвхтний клуб байгуулах,
5. Боловсролын ажлын хамрах хүрээг өргөжүүлэх: Бүх насны сонирхлын бүлгүүдэд зориулсан хөтөлбөртэй болох, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хөтөлбөр, үйлчилгээ бий болгох, харааны бэрхшээлтэй үзэгчдэд зориулсан барьж мэдэрч үзэх үзмэр түүний тайлбар, танилцуулга бэлтгэн тэдгээрт түшиглэсэн танин мэдэхүйн хөтөлбөр боловсруулан түгээх, сонсох тайлбар бий болгох, өөрсдийн гараар урлан бүтээх зүйлсийг музейн сургалтын танхимд хийх, жуулчдад зориулсан эх түүх, соёлоо таниулах үйл ажиллагаа зохиох, соёлын биет бус өвд суурилсан боловсролын хөтөлбөр бий болгох,
6. Боловсролын ажлын төрөл хэлбэрийг нэмэгдүүлэх: музейгээс гадуурх боловсролын хөтөлбөр боловсруулан түгээх, үзүүлэгээс гадна музейн орчинд төрөл бүрийн тоглолт зохион байгуулах, музейн цуглуулга, хөтөлбөрийн хүрээнд ойрын болон холын аялал, тойрон аялал зохион байгуулах хэлбэрийг олшруулах гэх мэт.

⁵³ Болорцэцэг М. Музейн боловсрол, олон нийтийн хөтөлбөрийн хөгжлийн асуудалд //Музей судлал Т.XVIII (I).F-11. Эрхэлсэн Д.Бумаа. –УБ., 2017. –Х.112.

Ном зүй

1. Алтаннавч Д. Хүний хөгжилд музейн гүйцэтгэх үүрэг. //Музей судлал Т-ХVII. F-2. Эрхэлсэн Д.Бумаа. –УБ.,2016.
2. Болорцэцэг М. Музейн боловсрол, олон нийтийн хөтөлбөрийн хөгжлийн асуудалд //Музей судлал Т.ХVIII (I).F-11. Эрхэлсэн .Д.Бумаа. –УБ., 2017.
3. Монгол Улсын стандарт: Гар урлал болон урлагийн зориулалттай зүйлс, музейн үйл ажиллагаанд тавих шаардлага. заалт 12.7.1. MNS5634:2006, -УБ., 2006.
4. Музейг эрхлэх нь: Практик гарын авлага. Олон улсын музейн зөвлөл. –УБ., 2014.
5. Цэдмаа Д. Музейн тулгамдсан зарим асуудалд //Музей судлал Т. I (IV).F-10. Эрхэлсэн Идшинноров.С. –УБ., 2001.
6. Цэндсүрэн Ц нар, Музей судлалын үндэс. –УБ., 2010.
7. Эрдмаа Д. Юмчмаа Г нар. Музейн боловсролын ажилтны хөгжил ба хандлага. // Музей судлал Т-ХIX-I. Fask-20, Эрхэлсэн Д.Бумаа. –УБ., 2018.
8. ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний комисс. Баримт бичгийн эмхэтгэл, ЮНЕСКО-гийн тунхаглал, конвенц, зөвлөмж. –УБ., 2015.

Цахим эх сурвалж

1. Российская музейная энциклопедия. http://www.museum.ru/rme/mb_cult.asp 2022.03.23.
2. Монгол хэлний их тайлбар толь. <https://mongoltoli.mn/search.php?opt=1&word=%D0%B1%D0%BE%D0%BB%D0%BE%D0%B2%D1%81%D1%80%D0%BE%D0%BB> 2022.03.19.
3. “Музейн тухай хууль”-ийн 4.1.1. <https://old.legalinfo.mn/law/details/16131> 2022.03.19.
4. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_2002_004V1&13999001_select_all=0&13999001SingleSelect= T2&SOUM_select_all=0&SOUMSingleSelect=&YearY_select_all=0&YearYSingleSelect=&viewtype=table 2022.03.24.

ГЭР БҮЛИЙН БОЛОВСРОЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВ

Болдуухайн Оюун-Эрдэнэ (Ph), дэд профессор
Хуушааны Баавгай (Ph)

Түлхүүр үг: гэр бүл, гэр бүлийн боловсрол, хүний хөгжил, гэр бүлийн тогтвортой эрүүл байдал,

Хураангуй (Abstract)

The total population of Mongolia reached 3,238,479 in 2018 and increased by 1.91 percent compared to the previous year. Mongolia has 885.6 thousand households were in total, of which 44% live in the capital city- Ulaanbaatar and 56% in rural areas.

The family is a fundamental social group and a unique environment that contains social relations such as psychological, moral, economic, and legal affairs.

In this context, the Government of Mongolia has developed and implemented several policies, programs, laws and regulations on family development and protection. For example, the adoption of the Family Law of Mongolia in 1999, and the adoption of the State Policy on Family Development in 2003 and the State Policy on Population Development in 2016 respectively.

Furthermore, in order to improve the legal environment for population, family, gender, and children, the Law on Child Protection, the Law on the Rights of the Child, the Law on Combating Domestic Violence, the Law on Promotion of Gender Equality, and the Law on Combating Trafficking in Persons have been adopted.

According to the Government Action Program of 2016, the Government of Mongolia has set up a Government agency in charge of Family, Child and Youth Development in 2016, with the goal of establishing a government agency in charge of family, child and youth issues. This enables to make families, and children's policies in a unified way and brings enormous progress in sectoral development.

As a result of this decision, a mechanism to manage the implementation of the state policy on family support has been established.

. Pressing issue

1. State structure and systems are new and human resource is insufficient.

The government's policy papers have included a number of goals and activities on family development issues, but the state's specialized structure, system, budget, and human resources are inadequate. As a result, policy implementation is quite weak and family issues remain out of state policy.

2. Lack of appropriate family-centered services

As a result of the socio-economic transition, there are many issues facing the family as a whole, and there is a breakdown in the Mongolian family. Therefore, the government needs to establish a new law-specific system to support and family-centered services.

1. State services aimed at developing and promoting family are not legalized.

2. Target families with different problems are emerging as a result of inadequate family support.

3. It is necessary to define and regulate in accordance with the needs of the family.

For example, rational policies and state services aimed at target families such as alcohol-dependent families, migrant families, violence relations families, families with jailed or released persons, families with disabilities and disabled citizens, remarried families are missing.

The newly revised Family Law needs to focus on the role of the government in protecting and supporting the fundamental interests of the family, and it is necessary to define and coordinate the services of the government in line with the needs of the family accurately.

Examples include rational policies and state services aimed at target families such as alcohol-dependent families, migrant families, violence relations families, families with jailed or released persons, families with disabilities and disabled citizens, remarried families are missing.

At this time, socio-economic and cultural development is intense, we are confident that the above services will be consistent with family structure and family relations and bring positive changes to family life and society.

It is the best solution to develop a family-oriented service infrastructure or create specialized services centers, NGOs and enterprises, have them work on a contract basis, and volunteer engagement because development determines the quality of life of individuals, families, the progress made and benefits of the family, and not only by the macro-economic indicators.

Оршил

Гэр бүл бол төр улсын үндэс, төр улс дахь “гэр улс” болдог нийгмийн анхдагч орчин билээ. Нүүдэлчдийн анхны төрт улс болох Хүннү гүрний үеэс (одоогоос 2226 жилийн өмнө буюу МЭӨ 209 онд) өрх гэр бүл, хүн ам зүйн асуудал Монгол төрийн бодлогын төвд байсаар ирсэн уламжлалтай.

Их Монгол улсын үед Чингис хаан “өрх гэрээ засаж байж төрөө засна” хэмээн сургасан нь гүн ухааны гүнзгий утга учиртай билээ. Тиймээс Их Засаг хуульдаа “Хүүхэд нь эцэг эхээ, залуус нь ахмадаа, эхнэр нь нөхрөө үл сонсвол хуулийн хариуцлага хүлээнэ. Садар самуун явдал нь гэр бүл сарних, улмаар хэрүүл тэмцэл хагарал гарахын шалтгаан болдог тул шийтгэнэ” хэмээжээ. Энэ нь Нүүдлийн соёл иргэншилтэй малчин монголчуудын хувьд өрх айл нь төрийн болон нийгмийнх мөн агаад айл өрх бат бол төр улс бат бэх байх ёстой болохыг зааж хуулиар хамгаалсан явдал байлаа.

Социалист тогтолцооны үед ч хүн амаа өсгөх бодлогоор дамжуулан гэр бүлийн бат бэх байдлыг бэхжүүлэх бодлого барьж байлаа.

Харин тогтолцооны хувьд авч үзвэл 1990 оноос өмнө гэр бүл, эмэгтэйчүүдийн асуудлыг төр олон нийтийн статустай Монголын эмэгтэйчүүдийн хороо хариуцаж байсан бол Ардчилал зах зээлийн харилцаанд шилжсэн анхны жилүүдэд Монгол Улсын төр засгаас эмэгтэйчүүдийн асуудлаарх үндэсний тогтолцоог шинэчлэн бүрдүүлэх талаар санаачилга гарган анх 1992 онд Хүн амын бодлого, хөдөлмөрийн яаманд эмэгтэйчүүдийн тасаг байгуулагдан гэр бүл, эмэгтэйчүүд, хүүхдийн асуудлаарх төрийн бодлого боловсруулан хэрэгжүүлж байсан. Улмаар 2013 онд Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яаманд Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс байгуулж, Хүүхдийн төлөө үндэсний газрын орон нутаг дахь хэлтсийг "Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэс" болгон чиг үүргийг нь өргөтгөн зохион байгуулсан. 2016 оны 8 сараас Хүүхдийн төлөө үндэсний газрыг "Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар" болгон өөрчилж, бүх аймаг, дүүрэгт ийм нэртэй газар хэлтсүүдийг ажиллуулж эхэлсэн.

Улсын Их Хурлын 2003 оны 16 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого”-д “Гэр бүлийн харилцааны эрх зүйн орчныг одоогийнхоос илүү боловсронгуй болгож, гэр бүлийн харилцаанаас үүссэн маргааныг гэр бүлийн асуудлаар мэргэшсэн шүүгч шийдвэрлэдэг болох”-оор, Улсын Их Хурлын 2004 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”-ын 2.1-д Гэр бүл нь хүний амьдралын анхдагч орчин, нийгмийн үндсэн нэгж гэж үзэж түүний хөгжлийн тухай асуудлыг төрийн бодлогын төвд байлгахад тус тус заасан билээ.

2017 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2015 онд Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хуулиуд тус тус шинэчлэгдэн хэрэгжиж гэр бүл,

хүүхдийн эрх ашгийг төр хамгаалах үйлчилгээ болон механизмыг илүү тодорхой болголоо.

Хүний хөгжилд гэр бүлийн үзүүлэх нөлөө хамгийн чухал болохыг сэтгэл судлал, Социологи-гэр бүл судлал, нийгмийн шинжлэх ухаануудын судалгаа баталж байна.

Хувь хүний төлөвшил, хүмүүжил, нийгэмшил, соёл, ёс суртахуун, зан ааш, дадал зуршил, үзэл хандлага суурь нь гэр бүлийн орчинд бүрэлдэн боловсордог бөгөөд энэ үүднээс хүний хөгжлийн анхдагч хамгийн чухал орчин бол гэр бүл юм. Иймээс ч Монголчууд ураг барилдахдаа удмыг нь хар. Сайн хүний үр, сүүт гүүний унага гэж хэлэлцдэг.

Хүүхэд харсан, сонссон, мэдэрсэн зүйлийнхээ дагуу төлөвшиж, хүмүүждэг учраас хүүхэд бол тухайн гэр бүлийн орчны тусгал юм.

Сүүлийн үед нийгмийн аливаа үзэгдэл, түүний эерэг, сөрөг үзэгдлийн мөн чанарыг оношлох, чиг хандлагыг тогтоохдоо ихэнх судлаачид гэр бүлд хандах, гэр бүлийн хөгжил, зүй тогтол, тогтолцооноос шалтгааныг хайх нь зүйтэй гэж үзэж байна. Тогтвортой гэр бүлийг дэмжих эдийн засаг, эрх зүй, сэтгэл зүйн орчныг бүрдүүлэх, гэр бүлийн харилцаанд жендерийн тэгш байдлыг хангаж, гэр бүлийг дэмжих үйл ажиллагааг гэрлэгчдэд адил, тэгш хүртээмжтэй, ил тод хэрэгжүүлэх асуудал олон улсын түвшинд голлох боллоо. Түүнчлэн гэр бүлийн гишүүдийн харилцан ойлголцлыг дэмжихэд чиглэсэн эрүүл ахуй, сэтгэл зүй, эрх зүй, гэр бүлийн боловсрол олгох сургалт, зөвлөгөө, тусалцаа үзүүлэх үйлчилгээг хөгжүүлэхэд анхаарч байна.

Өнөө үед Монгол гэр бүл хөгжлийн шинэ үед ирээд байна. Гэр бүлийн харилцаа, мөн чанар, бүтэц хэв маягт гарч буй олон асуудалд шинжлэх ухааны судалгааны үндэстэй хандах, судалгаанд суурилсан бодлого хэрэгжүүлэх, гэр бүлийн боловсрол, мэдлэг олгох асуудал нэн тэргүүний хэрэгжүүлэх шаардлагатай алхам болоод байна.

Залуусыг гэр бүлийн амьдралд бэлтгэх, хариуцлагатай хандахад туслах, гэр бүлийн боловсрол олгох нь зайлшгүй нийгмийн хэрэгцээ болж байна.

Зорилго: Гэр бүлийн эрүүл тогтвортой байдлыг хангах, гэр бүлийн хүчирхийлэл, салалт зэрэг сөрөг асуудлуудаас урьдчилан сэргийлэхэд залууст гэр бүлийн боловсрол олгох хөтөлбөр чухал болох саналыг дэвшүүлэх.

Үндсэн хэсэг

Манай улсын хувьд нийгмийн шилжилтээс шалтгаалсан олон өөрчлөлт бий болсны зарим нь гэр бүлд ноцтой өөрчлөлт, сөрөг үр дагавруудыг авчирч байна. “Гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал” 2010, 2018 оны суурь судалгаануудаас үзвэл хотод төвлөрөл нэмэгдэх, хөдөөд хүн ам сийрэгших, ураг төрлийн харилцаа хөндийрөх, цус ойртолт бий болох, гэр бүлийн гишүүдийн үүрэг, эрх мэдлийн хуваарилалт өөрчлөгдөх, хожуу гэрлэлт нэмэгдэх, бэлгийн харилцаанд эрт орох, гэр бүл салах, хүүхдийн эрх зөрчигдөх гэр бүлийн өмнө хуулиар хүлээсэн үүрэгт тавих хяналт суларч байгаа нь харагдаж байна.

Хосууд гэр бүлийн харилцааны зөрчлөө хэрхэн зөв шийдвэрлэх, хүүхдээ яаж зөв хүмүүжүүлэх зэрэг олон асуудлаар мэдлэг дутмаг байна.

Гурван хүн тутмын нэг нь ядуу амьдарч, найман гэр бүлийн нэг нь хамтран амьдрагчид болж, залуус гэр бүлийн амьдралд хангалттай бэлтгэгдээгүйгээс гэр бүлийн хүчирхийлэл нэмэгдэх, гэр бүл салсны дараа эцэг эх нь үр хүүхдэдээ тавих анхаарал халамж сулрах, хүүхдээ авч үлдсэн гурван хүн тутмын хоёрт нь хариуцлага ачаалал нэмэгдэж, гэр бүлийн үүрэг хариуцлага суларч байгаа зэрэг нь судалгаагаар нотлогдож байна.⁵⁴

⁵⁴ Гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал-суурь судалгаа 2004, 2010 он (илтгэгчийн судлаачаар ажилласан)

Гэр бүл салалт, гэр бүлийн хүчирхийллээс шалтгаалж эцэг, эхийн хараа хяналт суларснаас хүүхэд хохирох, хүмүүжил, төлөвшил доголдох, гэр бүлийн гишүүдийн итгэлцэл, бэлгийн амьдрал, ёс суртахуун, эрүүл мэндийн асуудалд ноцтой сөрөг үзэгдлүүд илэрч байгаа, зуучлалын гадаад гэрлэлт нэмэгдэж байгаа гээд олон асуудлууд байна.

Гэр бүлээ цуцлуулсан өрхийн 70.0 хувь нь 0-15 насны дунджаар 2-3 хүүхэдтэй байна. Салсны дараагаар хүүхдэд үзүүлэх эцгийн халамж 11.4 хувь байгаа бол ээжүүдийн хувьд энэ үзүүлэлт 84.2 хувьтай байна. Салалт нь 25-45 насныхнаа дунд нэлээн өндөр хувьтай, амьдралын ид идэвхтэй үе дээрээ салалт өндөр байгаа нь сэтгэл эмзэглүүлэхээр нийгмийн нэгэн хөндүүр асуудал болоод байна.

Гэр бүл салалтын гол шалтгаан нь архидалт, хүчирхийлэл, гадаадад удаан хугацаагаар ажиллах, гэрлэлтээс гадуурх бэлгийн харилцаа, амьдралд бэлтгэгдээгүй зэргээс шалтгаалж байгаа бөгөөд **үүний ноцтой сөрөг үр дагавар бол хүүхдэд үзүүлж буй сөрөг нөлөө юм.**

Хамтран амьдрагчид, олон соёлт гэр бүл, улс дамнасан гэр бүл, гэрээт гэр бүл, дахин гэрлэсэн гэр бүл, өрөөсгөл гэр бүл, нийлмэл гэр бүл гэх мэт гэр бүлийн олон хэлбэр, хэв маяг бий боллоо. **Эдгээрээс хамгийн ноцтой асуудал бол гэр бүлийн хүчирхийллийн асуудал юм.**

“Хүүхдийн эрхийн мэдлэг хандлага хэрэглээ”⁵⁵ 2017 судалгаанаас үзвэл Манай улсын хүүхэд, өсвөр үеийнхэн амьдралын анхдагч орчин болсон гэр бүлдээ хүчирхийлэлд өртөж, айдас хүйдэстэй амьдарч байна. Судалгаанд хамрагдсан 10 хүүхэд тутмын 8 нь ямар нэг байдлаар хүчирхийлэлд өртдөг гэж хариулсан байх бөгөөд тэдний 2 хүүхэд тутмын 1 нь ямар нэг байдлаар бие махбодын хүчирхийлэлд, 4 хүүхэд тутмын 1 нь үл хайхрах хүчирхийлэлд, 5 хүүхэд тутмын 3 нь сэтгэл санааны хүчирхийлэлд, 8 хүүхэд тутмын 1 нь бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан гэж хариулсан байна.

Монгол Улсын нийт хүн амын 35,8 хувийг 0-18 хүртэлх насны хүүхэд эзэлж байна. Монгол Улсын Засгийн газраас хүүхдийн эсрэг хүчирхийллийн суурь шалтгаан ядуурал, нийгмийн тэгш бус байдлыг бууруулах, хууль эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх, хүүхдийн хөгжил, хүмүүжлийг сайжруулахад анхаарч байна.

Нийгмийн бүтэц, орлого, амьдралын нөхцөлөөс нь аваад үзэхэд нийт хүүхдийн 15 хувьд зайлшгүй халамж хамгаалал шаардлагатай байгаа бол, үлдсэн 85 хувьд нь хөгжлийн бодлого хэрэгтэй байгаа гэж хэлж болно.

Хөгжил, хүмүүжил яригдаж байгаа 85 хувийг гэр бүлд нь хамгаалах, хөгжүүлэх, хүмүүжүүлэхэд анхаарах цаг болжээ.

Хүүхэдтэй болж түүнийг төрүүлж өсгөнө гэдэг нь асар их хариуцлагатай ажил юм. Энэхүү ажилд томилогдохоосоо өмнө “Хүүхэд гэж хэн бэ?” гэдгийг мэдэж байх хэрэгтэй.

Цаг үе, нийгэм, хүүхдүүд маань өөрчлөгдөж байна. Энэ хэрээр ээж, аав бид хөгжих, боловсрох, хүүхдийнхээ талаар илүү ихийг мэдэх хэрэгтэй болж байна.

Аав, ээж байх нь аз жаргал, утга учир дүүрэн боловч нэгэн хүнийг өөрийн гараар өсгөн хүмүүжүүлж, насанд хүртэл нь хөтлөн явах том үүрэг хариуцлагыг хүлээсэн амаргүй аялал юм.

Бидний хүүхдийн хөгжил цэцэрлэг, сургууль багшаас биш бидний гэр бүлийн орчноос илүү хамааралтайг ойлгох цаг боллоо.

Өнөөгийн шинжлэх ухаанд 0-6 нас бол хүний хөгжлийн хамгийн чухал үе шат гэж үздэг.

Бага насны хүүхдийн хөгжлийн асуудал бол хүний хөгжлийн суурийг зөв тавих тухай ойлголт юм. Саяхныг хүртэл үйлдвэрлэлийн хурдацтай хөгжил, техник

⁵⁵ “Хүүхдийн эрхийн мэдлэг, хандлага, хэрэглээ” КАН судалгаа. 2016. ХЭҮК, Гүүд Нейборс(илтгэгчийн зөвлөхөөр ажилласан)

технологийн дэвшил, эдийн засгийн өсөлт зэргийг хөгжлийн төвд авч үздэг байсан бол орчин үед хөгжлийн төв нь ХҮН юм гэдгийг тунхагласнаар хүүхдийн хөгжлийн асуудал улс орон, нийгмийн тэргүүн зорилго болон дэвшигдэж байна. Хүүхэд бол хүний хөгжлийн хамгийн чухал үе шат, улс орны ирээдүй хойч үе бөгөөд хөгжлийн тулгуур гэж үзэх хандлага зонхилох боллоо.

Монголчууд бид хүүхдийн хүмүүжлийг төрсөн цагаас бус эхийн хэвлийд байх үеэс нь анхаарч ирдэг сайхан уламжлалтай. Монгол эх хэвлийдээ үрээ тээсэн цагаас эхлэн тайван, уян ухаалаг, болж уурлах уцаарлах, элдэв муу үг сонсох, хэлэх, муу үйл хийхийг цээрлэж хожмын хүүхдийн зан аашинд нөлөөлнө гэж үздэг.

Манай ард түмэн үр хүүхдээ биеэ засаад гэрээ засах, гэрээ засаад төрөө зас гэсэн нь нийгмийн гишүүний хувьд эрдэм номтой элдэвт авхаалжтай, үйлэнд уран, үнэнч шударга, зөв төвшин, даруу төлөв болж хүмүүжээд, дараа нь айл гэрийнхээ голомтыг асааж хань ижил, үр хүүхэдтэй болон төрийн хэрэгт биечлэн оролцож түмэндээ зүтгэх ёстой гэсэн зарчмын утгыг агуулж буй юм.

Ардын ёс зүйн бичигдээгүй хууль, ахуйн дүрэм журамд эцэг, эх үр хүүхдэдээ зөв үлгэр дуурайлалтай байж тэднийг зөв хүн болгодог байлаа. Монголчууд үлгэр туульсын үзэл санаа, тоглоом, дуу хөгжим гээд орчин цагийн шинжлэх ухаанд дэвшигдэн тавигдсан бүхий л арга зүйгээр бага насны хүүхдээ хөгжүүлж ирсэн. Монголчуудын хүнээр хүн хийх ухаан нүүдлийн ахуй амьдралд бүрэн шингэсэн байсан юм. Харин суурин амьдралд шилжсэнээр уламжлал биднээс холдож байна. Тэгвэл бид өнөө цагт шинжлэх ухааны мэдлэгт суралцах ёстой.

Оросын агуу сэтгэл зүйч Л.С.Выготский үзэхдээ хөгжил гэдэг чанарын өөрчлөлтийн гинжин холбоо, хүүхдийн хөгжилд орчны нөлөөлөл чухал энэ нь тухайн хүүхдийн тэрхүү орчинд байсан мэдрэмжээр тодорхойлогдоно гэж үзжээ. Тэгвэл Германы эрдэмтэн Карен Хорни бие хүний нийгэм соёлын онолдоо хүүхэд ахуй цагийн сэтгэгдэл мэдрэмж нь насанд хүрсэн хүний сэтгэцийн бүтэц үйл ажиллагаанд нөлөөлдөг ба эцэг эх хүүхдийн хоорондын харилцаа холбоо нь хүүхдийн хүмүүжилд шийдвэрлэгч нөлөөтэй хүчин зүйл гэж үзсэн.

Өөрөөр хэлбэл эцэг эхийн харилцаа хандлага, хүүхдээ хүмүүжүүлэх арга барил, гэр бүлд тогтсон дэг жаяг, хүүхдэдээ үлгэрлэх байдал, эцэг эхийн үйл хөдлөл, гэр бүлийн орчин нөхцөлд хүүхдийн оюун ухаан дасан зохицож, хүүхдийн хөгжил хэрхэн явагдах эсэх нь шийдвэрлэгддэг байна.

Эцэг эх хүүхдийн харилцаа нь хайр хүндлэл, харилцан ойлголцол дээр суурилсан хамтарсан бүтээлч шинжтэй байх үед илүү хариуцлагатай, хүнлэг, өөрийн амьдрал, үзэл бодолдоо эзэн болсон бие хүнийг төлөвшүүлдэг. Иймд эцэг эхчүүд хүүхэдтэйгээ аливаа зүйлд хамтран ажиллаж, тодорхой цаг хугацааг хүүхдэдээ зорилго, чиглэлтэйгээр зарцуулах, тэдэнд өөрийн үйл хөдлөлөөрөө зөв үлгэрлэх, үүрэг хариуцлага хүлээлгэх, аливаа шийдвэрт тэднийг оролцуулах, бусдыг хүндлэх, бусадтай нийцтэй байх зэрэгт сургах нь ирээдүйд өөрийн байр сууриа зөв олох, биеэ зөв авч явах, нийгмийн амьдралд хөлөө олоход нь нэн тустай гэдгийг шинжлэх ухааны онолууд батлаад буй юм.

Английн сэтгэл судлаач Джон Боулби “Энэгшлийн онол”-доо хүүхдийн хүмүүжил, төлөвшил болон насанд хүрсний дараах бие хүний чадвар, шинжүүдэд эцэг эхийн хүүхдэдээ гаргаж буй үр бүтээмжтэй цаг, анхаарал халамж онцгой нөлөөтэй байдаг гэдгийг нотолжээ.

“Хүүхдийн хөгжлийг дэмжихэд эцэг, эхийн оролцоог нэмэгдүүлэх арга зам”⁵⁶ 2017 судалгаанаас үзэхэд эцэг эхчүүд долоо хоног бүр гэр бүлдээ зориулсан цаг байдаг эсэхэд 60 гаруй хувь нь тийм, үлдсэн хувь нь үгүй гэсэн байна. Хүүхдийнхээ хүсэл сонирхол, бодол санааг ойлгож мэдрэхийн тулд эцэг эхчүүд хүүхэдтэйгээ ойр дотно байж, тэдний үйл хөдлөл, үг яриа, харилцаа хандлага зэргээс олон зүйлийг гярхай

⁵⁶ “Хүүхдийн хөгжлийг дэмжихэд эцэг, эхийн оролцоог нэмэгдүүлэх арга зам” 2017. Нэг сэдэвт судалгаа. “21-р зууны Монгол гэр бүл ЭШБХ” эмхтгэл

ажиглаж хүүхдээ зөв таньж, чиглүүлж байх явдал чухал юм. Энэ нь хожмын өдөр засаж боломгүй алдаанаас хүүхдээ урьдчилан сэргийлэх мөн хүүхдээ ойлгож, хэрэгцээ шаардлагыг нь оновчтой тодорхойлох боломжийг олгодог.

“Гэр бүлийн үнэ цэнэ 2013”⁵⁷ судалгаанаас үзвэл судалгаанд оролцогчдын 1,1хувь нь байнга, 43,7 хувь зарим үед хүүхдийн дэргэд архи дан согтуурдаг, хүүхдийнхээ дэргэд 2,7 хувь нь байнга, 65,7 хувь нь зарим үед муудалцдаг гэж хариулсан нь 68,4 хувьд нь гэр бүлийн зөрчил, маргаан байгааг харуулж байна.

Хүүхдийнхээ дэргэд 1,6 хувь нь байнга, 17,9 хувь нь зарим үед зодолддог гэж хариулсан нь гэр бүлийн зөрчил маргаан хүчирхийллийн хурц хэлбэрт шилжсэн болохыг харуулж байна.

Судалгаанд оролцогчдын 6 хувь нь хүүхдээ байнга зоддог, 37,8 хувь зарим үед зоддог гэж хариулсан нь огт байж болохгүй асуудал бөгөөд хүүхдийг шууд хүчирхийлж буй хэлбэр юм. Өөрөөр хэлбэл судалгаанд оролцогчдын 43,8 хувь нь хүүхдээ бие махбод хийгээд сэтгэл санааны хувьд хүчирхийлдэг байна. Уг судалгаанд дурдсанаар гэр бүлийн зөрчил маргааныг өрхийн орлоготой хамааруулахад орлого санхүү хангалттай болон, дундаж, хангалтгүй хэсгийнхэнд гэр бүлийн зөрчил маргааны эзлэх хувь төдийлөн ялгаатай биш байсан байна. Харин насны байдлыг авч үзвэл маргаан зөрчил 18-40 хүртэлх насныхнаа дунд хамгийн их байна. Архины хэрэглээтэй бүх гэр бүлүүдэд зөрчил маргаан байгаа нь ажиглагдсан нь архидалт гэр бүлийн хэрүүл, маргаан зөрчил, хүчирхийллийн үндэс суурь болж байгааг харуулж буй юм.

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн ихэнх хувь нь гэр бүлийн орчинд үйлдэгддэг байна.

31,9 % ямар ч үед хүүхдэдээ цаг гаргадаг нь сайшаалтай бол 6,6% нь цаг гаргаж чаддаггүйгээс гадна, 47,6 % шаардлагатай үед л цаг гаргадаг гэж хариулсан нь хангалтгүй байна.

“Хүүхдийн эрхийн мэдлэг хандлага хэрэглээ”⁵⁸ 2017 судалгаанаас үзвэл Манай улсын хүүхэд, өсвөр үеийнхэн амьдралын анхдагч орчин болсон гэр бүл, сурч хөгжиж, боловсрохуйн орчин болсон сургууль, нийгэмшихүйн орчин болсон олон нийт, цахим ертөнц, үзвэр үйлчилгээний газруудад ямар нэг хүчирхийлэлд өртөж, айдас хүйдэстэй амьдарч байна. Судалгаанд хамрагдсан 10 хүүхэд тутмын 8 нь ямар нэг байдлаар хүчирхийлэлд өртдөг гэж хариулсан байх бөгөөд тэдний 2 хүүхэд тутмын 1 нь ямар нэг байдлаар бие махбодын хүчирхийлэлд, 4 хүүхэд тутмын 1 нь үл хайхрах хүчирхийлэлд, 5 хүүхэд тутмын 3 нь сэтгэл санааны хүчирхийлэлд, 8 хүүхэд тутмын 1 нь бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан гэж хариулсан байна.

Хүүхдийг алдаа гаргасан, буруу зүйл хийсэн, сайн хүн болгон хүмүүжүүлэх гэсэн шалтгаанаар хүүхдэд гар хүрдэг байна. Томчууд хүүхдийг зодох явдлыг хүмүүжлийн нэг арга гэж эндүүрэх явдал байгаа нь ихээхэн сөрөг үр дагавартай. Хүүхдийн нас бага байх тусам бие махбодын хүчирхийлэлд өртөх эрсдэл илүү байдаг. Бага насны хүүхдийн үндсэн хэрэгцээ бол итгэл-найдвар, аюулгүй байдал байдаг. Өөрөөр хэлбэл тэдэнд насанд хүрэгчдийн зүгээс тавьж буй байнгын анхаарал халамж, хайр энхрийлэл нь хүүхдэд итгэл хэмээх суурь мэдрэмж, өөрийн хүч чадал, эрх мэдэл бие даасан байдлаа мэдрэх хэрэгцээг нь хангадаг. Бага насныхан дуулгаваргүй загнах, дүрсгүйтэх, гэжүүдлэх, дураараа авирлах, болохгүй гэсэн хориглолыг албаар зөрчих зэрэг үйлдлийг хийдэг нь өөрийн бие даасан тусгаар байдлаа ямар нэг хэмжээнд сорьж үзэж буй хэрэг юм. Энэ үед эцэг, эхчүүд хүүхдэдээ аливаа юмны болох болохгүй зааг, хэм хэмжээний анхан шатны төсөөлөлтэй болоход нь тусалж дэмжих нь зүйтэй байдаг.

Хүүхэдтэй буруу харьцах нь хүүхдийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлдэг голлох хүчин зүйл болно. Иймд томчуудын хүүхдэд хандах, тэднийг ойлгох, эерэг аргаар хүмүүжүүлэх асуудал дээр анхаарах, боловсрол олгох шаардлагатай байна.

⁵⁷ “Гэр бүлийн үнэ, цэнэ” асуумжийн судалгаа. 2013. ХТҮГ, УБИС

⁵⁸ “Хүүхдийн эрхийн мэдлэг, хандлага, хэрэглээ” КАП судалгаа. 2016. ХЭҮК, Гүүд Нейборс

Ёс зүйн онолоор ёс суртахуун гэдэг нь хайр энэрэл, хүнлэг ёсны үзэл дээр суурилдаг бөгөөд энэ нь хүүхэд насанд төлөвшөөгүй бол насанд хүрсэн хойно сөрөг үр дагавартай гэж үздэг. Иймд бид хүүхэд насны хүмүүжлийн агуулгад онцгой анхаарах шаардлагатай.

Асуулгад хамрагдсан 2 хүүхэд тутмын 1 нь хэн нэгнээс айдаг гэж хариулсан бөгөөд тэдний 45.3% нь гэр бүлийн орчинд буюу өөрийн төрсөн эцэг эхээс (30.6%), төрсөн ах эгч/хамаатан садан (8.6%), хойд эцэг эхээсээ (5.8%); 38.3% нь сургуулийн орчинд байдаг хэн нэгнээс (багш, сургуулийн атаман, СНА, дотуур байрны багш), хамгийн их айдаг гэжээ. Энэ нь 2015 оны 12 сард ХАХНХЯ, ЖАЙКА, Японы Хүүхдийг Ивээх Сантай (ЯХИС) хамтран хийсэн "Хамтарсан багийн өнөөгийн байдал" судалгаанд оролцогчдын 12.3% нь өөрийн гэр бүлээ, 59.6% нь амьдарч буй орчноо, 44.7% нь сургуулиа айж эмээх зүйлтэй, айдастай, орчин гэж үнэлсэнтэй ойролцоо байна. Гэр бүл, сургууль нь хүүхдийн аюулгүй амьдрах, өсөж хөгжих нөхцөлийг бүрдүүлсэн байх ёстой хамгийн чухал орчин билээ. Харамсалтай нь хүүхдүүд гэр бүлдээ өөрийн төрсөн эцэг эх, ах эгч эсвэл хойд эцэг эхээсээ, сургуульдаа багш, үе тэнгийнхнээсээ айж амьдарч байгаа нь тэдний сурах, хөгжих үйл явцад хортой нөлөөтэй юм.

Харвардын их сургуулийн Хүүхдийн хөгжлийн төвөөс хийсэн судалгаагаар хүүхэд аюулгүй, хамгаалагдсан орчинд өсөх нь түүний бие махбод болон тархины хөгжил эрүүл явагдахад чухал байдаг бол, тогтмол айдастай амьдрах нь тархины хөгжилд сөрөг нөлөө үзүүлдэг болохыг нотолжээ⁵⁹.

Хүүхэд аливаа зүйлээс айдаг байх нь ихээхэн сөрөг үр дагавартай. Психоанализын гол төлөөлөгч Хорни Карен ямар нэгэн айдас түгшүүртэй байдаг хүүхэд өөрийгөө хамгаалж хүмүүс рүү, хүмүүсийн эсрэг түрэмгий ханддаг эсвэл, хүмүүсээс зайлсхийсэн хэв шинжтэй болдог гэж үзсэн байдаг. Өөрөөр хэлбэл айдас нь хүүхдэд хэвийн харилцаа хандлага төлөвшихөд сөргөөр нөлөөлдөг байна. Бие хүний төлөвшилд хүрээлэн буй орчны нөлөөлөл чухал тул хүүхэд айдасгүй орчинд өсөж, хөгжих ёстой бөгөөд энэ нөхцөлийг бүрдүүлэхэд насанд хүрэгчдийн хандлагыг өөрчлөх нь нэн тулгамдсан асуудал болж байна.

“Гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал” 2010 судалгаанаас үзвэл гэр бүлийн орчинд хүүхдэд айдас түгшүүр төрүүлэхүйц үйлдлийг гаргадаг байдал эцэг, эхчүүдийн хувьд дараах байдалтай байжээ. Хүүхдүүдийн айдастай байдалд эцэг эх хоорондын харилцааны таагүй байдал нөлөөлж байх магадлалтай юм.

Хүснэгт 6. Хүүхдийн хүмүүжилд нөлөөлөхүйц сөрөг зан үйлийн хэлбэрүүд

№	Зан үйлийн хэлбэрүүд	Байнга	Зарим үед	Хэзээ ч үгүй	Дундаж үнэлгээ
		1	2	3	
1	Зүй бус үг хэллэг хэрэглэх (хараал хэрэглэх)	2.1	41.8	56.1	2.54
2	Архидан согтуурах	1.5	31.9	66.6	2.65
3	Хүүхдийнхээ дэргэд бусадтай муудалцах	1.3	38.8	60.0	2.59
4	Тамхи татах	12.0	26.8	61.2	2.49
5	Хүүхдээ зодох	1.3	30.9	67.9	2.67
6	Зодолдох	1.0	12.9	86.0	2.85
7	Бие бие ээ бусдын өмнө зэмлэх	0.8	38.6	60.7	2.60
8	Айлгаж сүрдүүлэх	0.9	12.9	86.2	2.85
9	Гэрийн ахмад настныг загнах, буруушаах, үл тоомсорлох	0.7	12.7	86.6	2.86

Хүүхдийнхээ дэргэд зохисгүй үйлдэл гаргахгүй байхыг эцэг эхчүүдийн зүгээс анхааран, үг хэл, үйлдлээ цэгнэдэг болох нь энэхүү судалгаанаас харагдаж байна. Гэвч хүүхдийнхээ дэргэд зүй бус үг хэллэг, хараал хэрэглэх, архидан согтуурах, бусадтай

⁵⁹National Scientific Council on the Developing Child (2010). *Persistent Fear and Anxiety Can Affect Young Children's Learning and Development: Working Paper No. 9.*

муудалцах, бие бие ээ зэмлэх, хүүхдээ зодох зэрэг байдлыг зарим үед хэмээн хариулсан оролцогчдын хувь нь 30-аас дээш байна.

Нийгмийн түгээмэл үзэгдэл болох ажилгүйдэл, ядуурал, хүнд суртал гэх мэт олон хүчин зүйл нь гэр бүлийн амьдралын хэв маягт нөлөөлсөөр байгаа ч эцэг эхчүүдийн хувьд гэр бүлдээ гаргаж буй цаг хугацаа, бүрдүүлж буй тайван амгалан орчин нь үлэмж чухал зүйл гэдгийг ухамсарлаж, тухайн зүйлд ач холбогдол өгч хандах нь туйлын чухал юм.

FTRI аргачлалын дагуу эцэг эхчүүдийн авсан гэр бүлийн өдөр тутмын үйл ажиллагаа буюу амьдралын дадал хэвшил, гэр бүлийн дэг журам, харилцаа хандлагын индексийн боломжит дээд утга нь 96 байх боломжтой ч дундаж үзүүлэлт нь 63.5 байна. Ойрын 5-10 жилд манай оронд өрх гэр бүлийн, түүний дотор өрх гэр бүлийн харилцааны асуудал улам нарийсан төвөгтэй болж, шийдвэрлэх асуудлууд дэвшин гарч ирэх хандлага ажиглагдаж байна. Ээж аав байна гэдэг асар өндөр хүндтэй үүрэг.

Аавтай хүн артай торго мэт

Аавгүй хүн алдуурсан унага мэт гэсэн ардын сайхан зүйр үг бий. Аавтай байх сайхан. Аавын нөмөр их, үг нь үнэн хүчтэй, үйл нь ариун байх ёстой.

Аав сайхан бүхний үлгэр дуурайл байж хүүхэд ааваараа бахархах ёстой. Аавын ухаанаар хүмүүжсэн хүүхэд алддаггүй.

Монгол эр хүн холын хараатай, уужуу ухаантай, тайван түвшин, гэр бүл төрөл төрөгсөд, өвөг дээдсийнхээ өмнө хүлээсэн үүрэгтэй, ханьдаа халамжтай, өрх гэрээ авч явах чадвартай, өтгөсөө хүндэлдэг, үр хүүхдэдээ сайн үлгэр дуурайлтай жудаг төгөлдөр сайхан чанартай байдаг билээ.

Удам залгах ухааныг эцэг хүн л үр хүүхдэдээ өвлүүлдэг.

Монгол гэр бүл бол сурган хүмүүжүүлэх ухааны том их сургууль байсан. Тэгвэл өнөөдөр энэ уламжлал алдагдаж байна.

Эцэг, эхчүүд ажилдаа ихэнх анхаарлаа төвлөрүүлээд үр хүүхэд нь ямар хүмүүжилтэй, үзэл бодолтой, үнэлэмжтэй хүн болж байгааг анзаарахгүй байна.

Түүх шастир арвин Монгол угсаатны он цагийн тэртээгээс газар дэлхийг донсолгон дуурьсагдсан баатарлаг эрс олон боловч тэднийг төрүүлж, өсгөн бойжуулж, мандан бадрахад тэргүүлэх үүргийг хүлээж, чимээгүй түүхийг бүтээгч хатад, эмэгтэйчүүд олон байсан юм.

Бидний эх түүхийн гэрч “Монголын Нууц Товчоо” болон холбогдох сурвалж бичигт Өүлэн ядуу зүдүү амьдрал дунд дээлийн хормойг шууж, олирс мойл түүж, өчүүхэн хөвгүүдээ хайрлан тэжээсэн ба шөнө өдрийг хатамжин өнгөрүүлж ханатал цадтал хооллон, суут хөвгүүдээ өсгөсөн гэж тэмдэглэжээ.

Өүлэн эх өөрийн хүүхдийг өсгөн хүмүүжүүлээд зогсохгүй өрөөлийн өнчин хүүхдүүдийг өсгөн хүмүүжүүлж хожмоо Тэмүжиний бүх Монголын аймгийг хураах аугаа үйлсэд үнэнч найдвартай анд, өрлөг жанжин, хамтран зүтгэх чадварлаг багийн гишүүдийг бэлтгэсэн улс төрийн холч ухаантан байсан юм.

Тиймээс ч элбэрэлт эх Өүлэнийг Чингис хааны багын анд байгаад хожим түүнтэй тэрсэлсэн Жамуха цэцэн хүртэл насныхаа эцэст гэм гэмшлийг тоочин өгүүлэхдээ:

“Сэргэлэн андад

Цэцэн эх заяажээ

Эрэлхэг баатар андад

Эрдэмтэн дүү нар төржээ...” гэдэг.

Өүлэн эх Чингисийг Хавт Хасарыг баривчлахад Хасарын хүлээсийг тайлж хоёр хөхөө гарган Чингис хаанд:

“Үүнийг харж байна уу Хөхсөн хөх чинь энэ байна

Хавиргаа хадран хазагсад

Хүйгээ хүчирхэн таслагчид хэмээн зэмлэхэд:

Чингис хаан: “Эхийг хилэгнэсэнд би айхын ихээр айж, ичихийн ихээр ичив. Бид одоо ингэхээ больё” гэдэг.

Чингис газар нутаг, хил хязгаартай, бичиг үсэг, өвөрмөц хэл соёлтой Монгол үндэстний эх суурийг тавилаа. Түүний хамгийн дотно зөвлөгч хүмүүжүүлэгч, ухааныг хайрлагч ээж нь хорвоогоос хальж түүний орон зайг ухаант хатан Бөртэ нь үргэлжлүүлж улс төрийн зөвлөхийн үүргийг гарамгай биелүүлж байсан нь түүхэнд баримт болон хөвөрдөг.

“Бүтээхийн урьд учирсан Бөртэ үжин их хатан минь Эрдэнэ эцгийн минь зөөсөн эх мэт гэргий бөлгөө” хэмээн Чингис хаан авааль гэргий, төрийн их хатнаа магтсан байдаг.

Бөртэ Үжин Тэмүүжингийн агуу их үйлст хүчин чадлаараа тусалж дэмжсэнээр барахгүй, онч мэргэн холч ухаанаараа төр улсыг нэгтгэн эе эвийг сахих стратегийн санаа боловсруулах, хэлэлцэхэд нь томоохон үүрэг гүйцэтгэж байлаа.

Тухайн үеийн нийгэм, улс төрийн амьдралд манлайлан оролцож байсан их Бөртэ Үжин хатны хүмүүжүүлсэн хөвгүүд, охид монголын эзэнт гүрний түүхэнд томоохон гавьяа байгуулсан билээ.

Өүлэн хатан, Бөртэ Үжиний гүйцэтгэсэн үүрэг Алтан ургийнханд бичигдээгүй хууль болон өвлөгдсөнөөр төр эзгүйрээгүй төдийгүй ганц сэрэмж алдан гэр бүл эв үгүй болоход улс орон эв нэгдэлгүй болдог гашуун үнэнийг сургамжилсан юм.

Ийнхүү монгол гэр бүлийн түүхэн уламжлалд эх хүний гүйцэтгэх үүрэг нь үр хүүхдээ төрийн хүн, улс орныг удирдан залах эзэд нь болгон өсгөн хүмүүжүүлэх, эр нөхрийн үнэнч түшиг, мэргэн зөвлөх нь байх явдлаар тод илэрч буй юм.

“Гэр бүлийн үнэ цэнэ” 2013 судалгаанаас үзвэл хүүхдэдээ анхаарал тавих байдалд ээжүүд 57% байхад аавууд дөнгөж 7% тай байгаа нь анхаарах асуудал болно. Эцэг, эхийн үүрэг, хариуцлага адил түвшинд байх нь хүүхдийн хөгжил төлөвшилд эерэг сайнаар нөлөөлдөг байна. Учир нь гэр бүл тогтолцоо болохынхоо хувьд эцэг, эх болон гэр бүлийн гишүүдийн үүрэг оролцоо нөлөөллийг адил тэгш байлгаж чадсанаар хүүхэд өөртөө итгэлтэй бие даасан хандлага төлөвших боломжтой. Иймээс хүүхдийн хөгжилд гэр бүлийн бусад гишүүдийн оролцоог нэмэгдүүлж, ялангуяа аавуудын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх нь чухал байна.

Саяхныг хүртэл гэр бүл нь гаднын оролцоогүй, хаалттай систем гэгдэж үүссэн асуудлаа дотроо шийдвэрлэх ёстой гэж үзэх хандлага байсан бол сүүлийн үед гэр бүлийн асуудлыг шинжлэх ухаанчаар судалж нийгмийн томоохон асуудал болгож тавих шаардлага зүй ёсоор бий болж байна.

Дүгнэлт

1. Монгол гэр бүлийн хөдөлшгүй нийтлэг үнэт зүйл нь :

Үр хүүхдээ хайрлаж зөв хүн болгох,

Эцэг, эхээ ачлан дээдлэх,

Гэрийн дотор хүндэтгэх ёсны хүнлэг харилцаатай байх,

Гэр бүлийн уламжлал, ёс заншлаа эрхэмлэх,

Өвөг дээдэс, үр хүүхдийнхээ өмнө хүлээсэн энэ насны үүргээ биелүүлэх,

Удам, угсааныхаа нэр төрийг хамгаалахад оршдог байв. Гэвч судалгааны үр дүнгүүд нь монгол гэр бүлийн үнэт зүйл алдагдаж байгааг харуулж байна. Гэр бүлийн үнэт зүйл нь гэр бүл эрүүл тогтвортой оршин тогтох суурь үндэс юм. Залуус амьдралаа эхлэхдээ алдаж, гэр бүлийн өмнө хариуцлагагүй байгаагаас гадна аав, ээж байх эрхэм алдрыг хөсөрдүүлж байгаа нь гэр бүл цуцлалтын статистик өсөлтөөр нотлогдож байна.

2. Гэр бүлийн амьдралын уур амьсгал, гэр бүлийн гишүүдийн харилцаа хандлага, бие бие ээ хайрлах, хүндэтгэх байдал хүүхдэд шууд нөлөөтэй. Зөрчил маргаан, хүчирхийлэлтэй тайван бус гэр бүлд өсөж буй хүүхэд сурлага, хүмүүжлийн доголдолтой, зан чанарын хувьд ууртай, хэдэр, эсвэл аймхай, өөртөө итгэх итгэл сул, хэн нэгнийг үзэн ядаж өширхсэн, амиа хичээсэн хүн болж өсөх магадлал

- нэмэгддэг. өсдөг. Хүүхэд өсвөр үеийн хүмүүжил боловсролд анхаарахдаа эцэг, эхчүүдийн үүрэг хариуцлага, ёс суртахууныг дээшлүүлэх, гэр бүлийн боловсрол олгох ажлыг хамт анхаарах шаардлагатай байна.
3. Дэлхийн ихэнх улс орнууд өсвөр үеийнхэн болон залуусыг гэрлэлтэд бэлтгэх сургалтыг албан ёсны сургалтын тогтолцоондоо багтаан оруулсан байхаас гадна гэр бүлийн сөрөг асуудлыг бууруулахын тулд иргэддээ гэр бүлийн боловсрол олгодог төвүүдийг олноор байгуулсан байдаг. Монгол улсын хувьд Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хүрээнд залуучуудын хөгжлийн төвийн үзүүлэх үйлчилгээний нэг нь “Гэр бүлийн боловсрол” хичээлийн тодорхой сэдвүүдээр бэлтгэгдсэн сургалт байж болох юм.
 4. Гэр бүлийн тогтвортой хэвийн байдлыг хангах нь нэг ёсондоо нийгмийн тогтвортой байдал болон хүний хөгжлийг дэмжиж байгаа хэрэг юм. Иймээс боловсролын бодлогын төвд гэр бүлийг тавьж залуучуудад гэр бүлийн боловсрол олгох замаар монгол хүүхдийн хөгжлийг дэмжих хэрэгцээ бий боллоо.
 5. Гэр бүлийн бодлого, үйлчилгээ, эрх зүйн шинэчлэл нь монгол гэр бүлийн үнэт зүйлийг хамгаалах, сурталчлах, таниулах, өвлүүлэхэд онцгой анхаарах шаардлагыг бий болголоо. Гэр бүлийн хүрээнд ирээдүйд гарах эрсдэлийг бууруулах хамгийн оновчтой үйл явц бол залуу үеэ гэр бүлийн амьдралд бэлтгэх юм.
 6. Залуучуудыг гэрлэлтийн баталгаа хийлгэхийн өмнө зайлшгүй сургалтад хамруулах, гэрлэлтийн баталгааг ёслол төгөлдөр гардуулдаг байх нь гэр бүлийн амьдралын үнэ цэнэ, үүрэг хариуцлагыг ойлгуулахад чухал үр нөлөөтэй гэж үзэж байна.
 7. Олон Улсын хүний эрхийн тогтсон хэм хэмжээний дагуу хүүхдүүд бол эрх эдлэгчид, харин насанд хүрэгчид үүрэг хүлээгчид юм. Насанд хүрэгчдийн хүүхдийн өмнө хүлээх үүргийг нэмэгдүүлэхэд гэр бүлийн боловсрол нэн чухал. Хүүхэд хамгааллын үйлчилгээнд бус хөгжлийн үйлчилгээнд мөнгөө зарцуулдаг болох шаардлагатай.

Үүний тулд цаашид:

- Гэр бүлийн боловсрол болгох сургалтын модуль боловсруулж, насан туршийн боловсролын хүрээнд сургалтыг тогтмол зохион байгуулах,
- Залуусыг гэрлэлтэд бэлтгэх, (Тухайлбал Олон Улсын Улаанбаатар Их Сургуулийн Гэр бүл судлалын тэнхим сургуулийн бүх оюутнууддаа “Гэр бүлийн боловсрол” 30 цагийн хичээл орж буй туршлагыг бусад сургуулиудад түгээх)
- Гэр бүлийн тогтвортой байдлыг хангах салбар дундын бодлогыг боловсруулах,
- СӨБ олгох, бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих, үнэлэхэд эцэг, эх хэмээх субъектийн хамтрах, оролцох үүргийг хуульд тусгах,
- Цэцэрлэгт суурилсан эцэг эхийн боловсролын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх,
- СӨБ-ын багш бэлтгэдэг сургалтын хөтөлбөрийн агуулгад эцэг, эхийн боловсролын талаарх хичээлийн агуулгыг илүү дэлгэрэнгүй оруулах,
- Гэр бүл дэх хүүхдийн хөгжил, хамгааллын асуудлыг иргэд олон нийтэд тогтмол ухуулан таниулж байх мэдээллийн орон зайг нэмэгдүүлэх,
- Бага насны хүүхдийн сэтгэл зүйн талаарх эцэг, эхчүүдийн мэдлэг, ойлголтыг байнга дээшлүүлэх,
- Гэр бүлийн орчинд гарч байгаа хүүхдийн эсрэг аливаа хүчирхийллийг таслан зогсооход бодитой алхам хийх,
- Эцэг, эхчүүдэд хүүхдийн эрх, хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргуудын талаарх мэдээллийг байнга хүргэх,
- Гэр бүлийн орчинд хүүхдийн эрх, аюулгүй байдал хангагдаж байгаа эсэхэд хяналт тавихад эцэг эхчүүдийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх,

- Хүүхэдтэйгээ өдөрт болсон үйл явдлынх нь талаар цаг зав гарган ярилцаж хэвших, хүүхдээ ойлгох, сэтгэл санаагаар байнга дэмжин урамшуулахыг уриалах,
- Гэр бүлийн нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, гэр бүлийн орчныг хүүхдийн аз жаргалтай амар тайван өсөж хөгжих орчин болгохыг үүрэгжүүлэх,
- Хүүхдийн хүсэл мөрөөдөл, итгэл найдварыг батжуулж, хүүхдээ сонсох, цаг гаргах боломжийг нэмэгдүүлэх,
- Гэр бүл эв найрамдалтай байж, үр хүүхдээ элэг бүтэн өсгөх нийгмийн уриалгыг дэвшүүлэх,
- Үр хүүхдэдээ зөв үлгэр дуурайлал үзүүлж буй гэр бүлийн сайн туршлагыг дэмжин урамшуулж, гэр бүлийн үнэт зүйлийг бэхжүүлэх
- Гэр бүлийн уламжлалт соёл, ёс заншил, эрхэмлэн дээдэлдэг үнэт зүйлтэй байхад анхаарах,
- Эцэг, эхчүүд гэр бүлийн боловсрол мэдээлэлд өөрийн санаачилгаар суралцах сэдлийг бий болгох,
- Үндэсний хэл, соёл, ёс заншил, язгуур соёлоо бага наснаас нь өвлүүлж оюуны тусгаар тогтнолыг бэхжүүлэх шаардлагатай байна.

Ашигласан эх сурвалж

1. Гэр бүлийн боловсрол. Б.Оюун-Эрдэнэ. УБ., 2017
2. Гэр бүл судлалын онол арга зүй. Т.Намжил. УБ., 2006
3. Монгол гэрийн ёс уламжлал. Т.Намжил. УБ., 1999.
4. Монгол гэр бүлийн сурган хүмүүжүүлэх зүй. Т.Намжил. УБ., 2005
5. Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал. Суурь судалгааны тайлан. УБ., 2010, 2018
6. Гэр бүлийн ёс суртахуун. Д.Тунгалаг.УБ., 2002
7. Гэр бүлийн социологи. Т.Бүрэнжаргал.УБ., 2006
8. Гэр бүлийн харилцааны зарим асуудал. Ө.Байгал, Б.Нандинцэцэг. УБ., 2012
9. Гэрлэлтийн талаар мэдвэл зохих101 зүйл. Ч.Б.Линда, УБ., 2011
10. Сэтгэл зүйд өөрөө суралцах нь. Д.Доржжав. УБ., 2005
11. Бие хүний сэтгэл зүй, сэтгэц заслын өрнөдийн онол, гол төлөөлөгчид. Б.Туяа, 2003
12. Гэр бүлийн боловсрол сэтгүүл. УБ., 2017, 2018 № 1,2,3
13. Хүний бэлгийн амьдрал. Д.Алтанцэцэг нар. УБ.,2005
14. Өрх гэрийн монгол ёсон. Х.Сампилдэндэв. УБ., 1999
15. Ангарагаас эрчүүд сугараас бүсгүйчүүд. Жон Грей. УБ., 2007
16. Гэр бүлийн эрхзүй. Ч.Отгонбаяр. /Лекцийн гарын авлага/ УБ., 2006
17. Гэр бүлийн ёс суртахуун. Д.Тунгалаг. УБ., 2000
18. Гэр бүлийн эрх зүй. А.Дугармаа. УБ., 2008
19. Гэр бүлийн эрх зүйн товч гарын авлага. Т.Мөнхжаргал.УБ.,1995
20. Боловсрол гэр бүлээс эхэлдэг. Ф. Калькынг. УБ., 2006
21. Гэр бүлийн эдийн засаг. Б.Оюунсүрэн УБ., 2015
22. Жаргалтай гэр бүлийн хөтөч. Б.Оюун-Эрдэнэ УБ., 2017
23. XXI зууны монгол гэр бүл эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл. УБ., 2017
24. Хүүхдийн хөгжил. Нчинхорлоо Ш. УБ., 2008
25. Ханиа хэрхэн сонгох вэ? Н. Самоукина. УБ., 2015
26. Семейная психология. Шнейдер Л.Б. М.,2005
27. Семья в психологической консультации. В.В. Столин. М.,1999
28. Психология семейных отношений. С.В Карабанова. М., 2005
29. Өрхийн хөгжлийг дэмжих арга зүй. Сурах бичиг. УБ.,2013

ФОКУС БҮЛЭГ ЭКСПЕРТҮҮДИЙН ЯРИЛЦЛАГЫН УДИРДАМЖ

“Бүх нийтийн соёлын боловсрол” стратеги төлөвлөгөө боловсруулахтай холбоотойгоор Монгол Улсын соёлын бодлогын онцлог, ирээдүйн үйл ажиллагааны зорилго, чиглэлийн талаар соёл, урлагийн салбарын бодлого тодорхойлогч болон экспертүүдтэй хийх уулзалт, фокус бүлгийн ярилцлага

Модератор: *Зөвлөх Проф. Ж.Долгорсүрэн (Ph.D)*
Зөвлөх Проф. Б.Пүрэвсүрэн (Ph.D)

Экспертийн судалгаанд хамруулах нийгмийн төлөөлөл:

1. Соёл, боловсролын сайдаар ажилласан хүн – А.Цанжид (Sc.D), Г.Чулуунбаатар (Sc.D), Ё.Отгонбаяр (Ph.D), Ц.Оюунгэрэл, С.Чулуун (Sc.D),
2. Соёлын бодлогын эрхзүйн үндсийг тодорхойлж, боловсруулагч – С.Төмөр-Очир (Ph.D), Н.Багабанди (Sc.D), Г.Занданшатар
3. Соёл, урлагийн газрын дарга нар – Б.Наранзун, Н.Батмөнх (Ph.D), З.Баянзул, Д.Гантөмөр (Sc.D),
4. Зөвлөхүүд (Ерөнхийлөгчийн шашин, соёлын зөвлөхүүд) - Д.Бум-Очир, М.Батаа (Ph.D), С.Цэдэндамба (Ph.D),
5. Боловсрол судлал, ёс зүй, гэр бүлийн социологийн судлаач – Н.Бэгз (Sc.D), Б.Галиндэв (Ph.D), ОУУБИС-н Гэр бүл судлалын тэнхимийн эрхлэгч
6. Нийгмийн эрүүл мэндийн судлаач – Д.Нарантуяа, Б.Цогтбаатар,
7. Олон нийт, төрийн бус байгууллагын төлөөлөл – О.Зулцэцэг, Х.Дамдинсүрэн,
8. Нийтийн тээвэр, цагдаагийн төлөөлөл – Хурандаа Баатарзориг /цахим гэмт хэрэг/
9. Бусад: Б.Цэцэнцолмон (Ph.D), Э.Энхжаргал, Ц.Цэцэгжаргал (Ph.D) – болон боломжтой бол чанарын судалгааны багийн нийт гишүүд нь сонсогчоор оролцоно.

Чиглүүлэх асуулт:

11. Засгийн газрын батлагдсан мөрийн хөтөлбөр, соёлын яамны бодлого, стратеги, соёлын тухай хууль зэрэг эрх зүйн баримт бичгүүдэд тусгалаа олсон ч гэсэн өнөөдөр Монгол Улсад соёлын бодлого, үйл ажиллагааг чухам юунд илүү их анхаарч төвлөрөх хэрэгцээ шаардлага байгаа хэмээн Та үзэж байна вэ?.
12. Засгийн газрын мөрийн хөтөлбөрт “Бүх нийтийн соёлын боловсрол”, “Цахим соёл” зэрэг монгол хүний хөгжлийг дэмжсэн хөтөлбөрүүд тусгагдсан. Үүнийг Соёлын яам ямар байдлаар хэрэгжүүлж, бодит ажил хэрэг болгох нь зүйтэй хэмээн үзэж байна?
13. Монгол Улс дахь соёл, гэгээрэл, боловсролын чанар, хүртээмжийн тэгш бус байдлыг хэрхэн бууруулах вэ?
14. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн баримт бичиг болох Алсын хараа – 2050-г та мэднэ. Түүний “Үндэсний нэгдмэл үнэт зүйлс” хэмээх бүлэгт тусгагдсан нийтлэг зорилгыг хэрхэн хангах талаар Та ямар байр суурьтай байдаг вэ? Монгол хүн бүрийн зайлшгүй мэдэх, дагаж мөрдөх үнэт зүйл юу вэ?
15. Тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд соён гэгээрлийн ямар бодлого, зохицуулалт хэрэгтэй вэ?
16. Эерэг хандлагатай, ёс суртахуунтай, бүтээлч монгол хүнийг төлөвшүүлэхэд нэн даруй бид юу хийвэл зохистой вэ?
17. Монголын түүх, өв, соёлын уламжлалыг хойч үедээ өвлүүлэхэд монгол айл өрх, гэр бүл яг юу хийх шаардлагатай?

18. Монгол Улсад соёлын олон янз байдлыг хөхиүлэн дэмжих нь хэр оновчтой вэ? Тухайлбал монгол-казах, монгол-англи хэл зэрэг хос хэлний бодлого, шашны олон янз байдал гэх мэт.
19. Нийслэл Улаанбаатар хотын төвлөрөл, хүн амын нягтаршлаас үүдсэн сөрөг үр дагаврыг соёлын боловсролоор дамжуулан хэрхэн сайжруулах боломжтой вэ? зэрэг асуултыг тавьж экспертүүдийн саналыг сонсож хэлэлцүүлэг хийнэ.

2022.01.30

“БҮХ НИЙТИЙН СОЁЛЫН БОЛОВСРОЛ” ФОКУС БҮЛЭГ ЭКСПЕРТҮҮДИЙН УУЛЗАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ

2022.04.21

Соёлын яам. Хурлын танхим

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. “Бүх нийтийн соёлын боловсрол” стратеги төлөвлөгөө боловсруулахтай холбоотойгоор Монгол улсын соёлын бодлогын онцлог, ирээдүйн үйл ажиллагааны зорилго, чиглэлийн талаар...

УУЛЗАЛТАД ОРОЛЦСОН:

1. Соёлын дэд сайд М.Батбаяр
2. Соёлын яамны Соёл, гэгээрлийн газрын дарга Д.Наранцэцэг
3. А.Цанжид /Sc.d/
4. С.Төмөр-Очир /Ph.D/
5. Д.Гантөмөр /Sc.d/
6. Б.Галиндэв /Ph.D/
7. Батаа /Ph.D/
8. Б.Цэцэнцолмон/Ph.D/
9. Б.Наранзун СУБЗГ-ын дарга
10. Б.Анара /Ph.D/
11. З.Баянзул /Соёлын яам/
12. Ж.Долгорсүрэн/Ph.D/
13. Б.Пүрэвсүрэн/Ph.D/

Б.Пүрэвсүрэн: Сайн байцгаана уу. Бидний урилгыг хүлээн авч хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа.

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн Зорилт 1.2, Засгийн газрын 2020-2024 үйл ажиллагааны хөтөлбөр, Соёлын яамны Стратеги зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээний баримт бичиг боловсруулах ажлын хэсгийг Соёлын сайдын тушаалаар 2021 онд байгуулсан. Ажлын хэсэг нийслэлийн 9 дүүрэг, 21 аймагт тоон болон чанарын судалгааг зохион байгуулан, дүн шинжилгээ боловсруулах ажил хийгдэж байгаа.

Соёлын салбарын бодлогыг тодорхойлж байсан үе үеийн сайд, газрын дарга нараа урьсан байгаа. Өнөөдрийг хэлэлцүүлгийг нээж өгнө үү хэмээн Соёлын дэд сайд М.Батбаяр таныг урьж байна.

М.Батбаяр: Сайн байцгаана уу. Хүрэлцэн ирсэн та бүхэнд талархал илэрхийлье.

Монгол Улсын засгийн газрын 2020-2024 үйл ажиллагааны хөтөлбөр, Соёлын яамны стратеги зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээний баримт бичиг боловсруулах ажил хийгдэж байна.

2021 оны Соёлын сайдын А/24 дүгээр тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж, улсын хэмжээнд судалгаа хийсэн. Судалгааг ЮНЕСКО-ийн суралцахуйн 4 суурь зарчим дээр тулгуурлан авсан. Бүх нийтийн соёлын боловсрол” стратеги төлөвлөгөө боловсруулахтай холбоотойгоор Монгол улсын соёлын бодлогын онцлог, ирээдүйн үйл ажиллагааны зорилго, чиглэлээ тодорхойлолтод та бүхний санал бодлыг сонсохоор өнөөдрийн фокус хэлэлцүүлгийг зохион байгуулж байна. Хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа. Хэлэлцүүлгийн ажилд амжилт хүсье.

Б.Пүрэвсүрэн: М.Батбаяр сайдад баярлалаа. Одоо та бүхэнд Соёл, гэгээрлийн газрын дарга Д.Наранцэцэг “Бүх нийтийн соёлын боловсрол” үзэл баримтлал, судалгааны явцын талаар товч мэдээлэл өгнө.

Л.Наранцэцэг: Сайн байцгаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Үзэл баримтлалаа: Үндэсний нэгдмэл үнэт зүйл бүхий “Эрчист Монгол” хүнийг бүтээх, төлөвшүүлэх гэсэн байгаа. Эрх зүйн холбогдох баримт бичиг нь:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Соёлын тухай хууль
- “Алсын хараа-2050” Урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг
- Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал
- Хүний хөгжлийн зорилгот хөтөлбөр /төсөл/
- Соёлын яамны стратеги төлөвлөгөө удирдлага болгосон.

“Соёлын боловсрол” бид Үндэсний болон хүн төрөлхтний соёлын үнэт зүйлийг хүртэх, эзэмших мэдлэг, ур чадвар, цогц чадамж олгох үйл явц, түүний үр дүн” гэж тодорхойлсон.

Энэ нь ЮНЕСКО-н баримталж буй суралцахуйн 4 зарчимд тулгуурласан. Үүнд:

1. Хүн байх, Монгол хүн байх соёлд суралцах
2. Танин мэдэхүйн соёлд суралцах
3. Хийж бүтээх соёлд суралцах
4. Хамтдаа хийж бүтээх соёл суралцах

Нөхцөл байдлын судалгааны асуулгаас товч дурдсан байгаа. Судалгаанд нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн 3247 иргэн хамрагдсан. Судалгааны завсрын үр дүнгээс товч танилцуулбал:

Монголчуудад дутагдаж буй соёлын түвшин:

1. Харилцааны соёлын гажуудал- 59 хувь
2. Сэтгэлгээний доройтол- 45 хувь
3. Эрүүл аж төрөх, соёлын орчин нөхцөл-40 хувь
4. Биеэ авч явах соёл-37 хувь
5. Ахуйн соёл-27 хувьтай

Монголын нийгэм, соёлын орон зайд соёлын түрэлт ихэссэн нь анхаарах асуудал байна.

1. Гаднын соёлын нөлөөлөл -70 хувь
2. Үндэсний нэгдмэл байдлын түвшин-49 хувь
3. Үндэсний сэтгэлгээний соёл-46 хувь байна. Энэ бүгдээс харахад бид бодлогын баримт бичиг боловсруулахдаа анхаарал татсан асуудлуудаа авч үзэх нь зүйтэй.

Иргэд өөрийгөө тодорхойлсон байдлыг авч үзвэл:

1. Монгол хүн 80,9 хувь
2. Нүүдэлчдийн удам-25 хувь
3. Жирийн иргэн-24 хувь

Иргэдийн эзэмшсэн ур чадвар

1. Мөнгө санхүүгээ зохицуулах -80,9 хувь
2. Амьдралаа төлөвлөх-28 хувь
3. Гэр бүл төлөвлөх нь -11 хувь байгаа нь гэр бүлийн боловсрол, түүнд чиглэсэн бодлогыг түлхүү анхаарахыг харуулж байна.

Тэгвэл бусдад сургахыг хичээдэг ур чадвар:

1. Аж амьдралын эерэг хандлага-22 хувь
2. Амьдрах арга барил-13 хувь
3. Гэр бүлийн уламжлал, ёс заншил-11 хувь байгаагаас бусдаас эерэг хандлагыг хүлээж байгаа нь харагдаж байна.

Ур чадвараараа өвлөж, суралцсан эх үүсвэрийг авч үзвэл:

1. Эцэг эхээс-80,9 хувь
2. Багш, сурган хүмүүжүүлэгч-13,5 хувь
3. Найз нөхөд-26 хувь
4. Соёл, урлагийн байгууллага-6,1 байгаа нь бид эдгээрт чиглэсэн бодлого арга хэмжээ авах нэн шаардлагатай байгааг харуулж байна.

Соёлын боловсролын олон улсын туршлагаас товч танилцуулсан. Та бүхэн мэдэж байгаа.

ОХУ : Урлагийн боловсролыг улсын тогтсон стандарт хөтөлбөрөөр үнэ төлбөргүй, албан боловсролоор олгодог систем, Төрийн болон хувийн өмчийн музей, галерейнуудыг түшиглэн урлагийн боловсролын төвүүдийг байгуулж, төрөөс дэмжлэг үзүүлдэг.

Герман: Албан бус боловсролын системээр дамжуулж соёлын боловсрол олгох Соёл, урлагийн байгууллагуудын үйлчилгээний агуулгыг соёлын боловсрол олгоход чиглүүлдэг. Музей, номын сан, театр, соёлын төвүүд соёлын олон талт үйл ажиллагаа явуулж, соёлын боловсролын хөтөлбөр хэрэгжүүлдэг.

Франц: 1789 оны Хувьсгалын “Эрх чөлөө, тэгш эрх, ахан дүүгийн ёс” гэх уриа нь өнөөгийн Франц улсын албан бичиг баримтад тусч, өдөр тутмын амьдралд нь мөрдлөг болж байна.

Япон: Хүүхдийн болон насанд хүрэгчдийн нас бие, оюун санааны онцлогт тохирсон ёс суртахууны сургалт явуулахын зэрэгцээ, хүнд насан туршийн дадал хэвшил суулгах, хувь хүний ёс суртахуун бүрэлдэн төлөвшихөд сургууль, багш, гэр бүл, орон нутаг, нийгэм хэрхэн нөлөөлж, ямар үүрэг гүйцэтгэх зэргийг нарийн тусгаж, бүх нийтийн ёс суртахууны боловсролын асуудлыг бүрэн цогцоор нь авч үзэх, бодлого, боловсруулах, хэрэгжүүлэх

Солонгос: соёл урлагийн эдийн засгийн ач холбогдолд илүү анхаарч, бүтээлч сэтгэлгээг дэмжих, соёлын үйлдвэрлэл, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, соёлын бүтээгдэхүүнээр дамжуулан солонгосын соёлыг гадаадад сурталчлахад чиглэсэн үйл ажиллагааг өргөжүүлэх нь олон нийтэд соёлын боловсролын үүрэг, ач холбогдлыг ойлгуулах, тэдний оролцох сонирхол

Хятад: БНХАУ-ын туршлагаар соёлын уламжлалыг сэргээж, өнөөгийн дэвшилтэт ойлголттой уялдуулан нэгтгэж хүн амд соёлын боловсрол олгох “Шинэ үеийн монгол хүн”, “Монгол мөрөөдөл” гэх зэрэг нэгдмэл үзэл санаа, хэм хэмжээг бий болгож сурталчлах нь олон нийтийн соёлын боловсролын талаарх ойлголтыг төлөвшүүлэх ач холбогдолтой.

“Эрчист Монгол” Соёлын боловсролын стратегийг:

Тодорхойлох үе -2021-2022 он

❖ *Нөхцөл байдлын болон чанарын судалгаа хийх*

- ❖ *Бодлогын баримт бичгээ боловсруулах*
- ❖ *Стратеги төлөвлөлт хийх*
- ❖ *Үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв боловсруулах*
- ❖ *Төр хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх*
- ❖ *Соёлын боловсролын дэд бүтцийг тодорхойлох*
- ❖ *Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим орчинд соёлын боловсрол олгох агуулга, хэлбэрийг тодорхойлох*

Хэрэгжүүлэх үе: 2022-2027 он

- ❖ *Соёлын боловсролын дэд бүтцийг бүрдүүлэх*
- ❖ *Албан болон албан бус сургалтын хөтөлбөрийн агуулга боловсруулах*
- ❖ *Албан боловсролын сургалтын тогтолцоог боловсронгуй болгох*
- ❖ *Албан бус боловсролын төвүүд, нүүдлийн соёлын цогцолбор, Хөдөлмөр зуслангуудыг бий болгох*
- ❖ *Соёл, урлагийн байгууллагуудад соёлын боловсролын хөтөлбөр бий болгох*
- ❖ *БНСБ-ын хүний нөөцийг чадавхжуулах хөтөлбөр хэрэгжүүлэх, сургагч багш бэлтгэх*
- ❖ *Эрх зүйн орчныг боловсронгуй болгох*
- ❖ *Албан бус боловсролын нэгдсэн стандартыг бий болгох*
- ❖ *“Би монгол хүн” хөтөлбөр хэрэгжүүлэх*
- ❖ *Зорилтот бүлэг, тусгай хэрэгцээт хүмүүст зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх*
- ❖ *Гэр бүлд ээлтэй боловсрол, танин мэдэхүйн хөтөлбөр, цахим болон мэдээллийн боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх*
- ❖ *Соёл, урлагийн байгууллагуудын менежментийг боловсронгуй болгох, санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх*
- ❖ *Аж ахуйн нэгж байгууллага бүр хүний хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлж, соёлын боловсрол олгох*

Төлөвшүүлэх үе: 2027-2037 он

- ❖ *Соёлын боловсролын төвүүдийн үйл ажиллагааг тогтмолжуулж, жигдрүүлэх*
- ❖ *Сургалтын хөтөлбөрүүдийг магадлан итгэмжилж, стандартжуулах*
- ❖ *Соёлын боловсролын мэргэжилтэн бэлтгэх тогтолцоог бүрдүүлж, төлөвшүүлэх*
- ❖ *Соёл, урлагийн мэргэжлийн хяналтыг төгөлдөржүүлэх*
- ❖ *Ур чадварыг нэмэгдүүлэх*
- ❖ *Эдийн засгийн эргэлтэд оруулах*
- ❖ *Цахим болон мэдээллийн боловсролыг төлөвшүүлэх*

Б.Пүрэвсүрэн: Соёлын яамны тусгай захиалгаар хийсэн судалгааны завсрын үр дүн, амьдралын зураг авалтыг МУИС-ийн багш Б.Цэцэнцолмон удирдан явуулсан.

Орон нутагт дэд бүтэц буюу Соёл, урлагийн газар байгуулагдсан нь бас сайшаалтай байгаа. За ингээд та бүхний санал бодлыг сонсьё.

С.Төмөр-Очир: Эрчист Монгол гэж ямар хүнийг хэлж байна бэ.

Б.Пүрэвсүрэн: Бидний судалгааны зорилго бол тэр тодорхойлолт бишээ. Наранцэцэг дарга хариулна аа.

Д.Наранцэцэг: Үндэсний нэгдмэл үнэт зүйл бол Алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн хөтөлбөрийн том зорилго, “Эрчист” гэдгийг өнгөрсөн Засгийн газраар танилцуулагдсан брэндиг бий болгох “Energetic Mongolia” Эрчист Монгол гэдгээс санаа авсан гэхдээ энэ нэрээр тогтоогүй байгаа.

С.Төмөр-Очир: Та нар нэг юмыг ойлгоорой. Гадаад үг шууд орчуулж авахаар яг тохирсон агуулгатай оновчтой байх нь төдийлөн байдаггүй. Жишээ нь: Хөдөө очоод тэр үгийг хөдөөгийн хүмүүс ойлгож байвал эрдэмтний үг гээд үг байдаг даа.

А.Цанжид: Санаа зөв байна. Хэтэрхий өргөн хүрээтэй санагдлаа. Соёл өөрөө өргөн хүрээтэй. Арга хэмжээ үйл ажиллагаагаа зааглаад, бодлого зорилгоороо нэгдмэл байх хэрэгтэй. Ганц соёлын яамны ажил биш шүү дээ. Боловсрол, спорт бүгд оролцох нь зөв.

Соёлын боловсрол ажлаа тодорхой болгох, үзүүлэлт гаргах, яаж чиг хандлагаа тодорхойлох, яаж хүрээгээ тодорхой болгох бэ гээд бодох хэрэгтэй. Монгол орон өвөрмөц, хот хөдөө соёлын хувьд ялгаатай. Улам л ялгаа зааг их болж байна.

Хар баасан гариг гэвэл хотынхон нэг өөр, хөдөөгийнхон аав ээжийн бурхан болсон өдөр гэж ойлгох жишээний. Хот хөдөөгийн зааг соёл иргэншлийн хямрал үүсэж байна. Сайн муу байраа сольж байна энэ нөхцөл байдалд яах бэ. Судалгааны чиг хандлагаа, баазаа зөв гаргах. Хотын хүүхдүүдэд өрөм загсах, чөдөр зангидах хэрэг байна уу. Уугуул соёл юу байх бэ, сүүлийн үед цахим соёл түлхүү орж байна.

Засгийн газар долоон зуу гаруй үйлчилгээг цахимаар өгч байгаа гээд байдаг, иргэдэд мэдээ мэдээлэл өгөхгүй, зааж чиглүүлэхгүй болохоор яаж тэрийг ашиглах бэ. Хийж байгаа төрийн бодлого үр дүн рүү хандсан байх хэрэгтэй.

Хот хөдөөгийн асуудлыг яаж уулзуулах бэ? Шашны асуудал байна?

Гаднын соёлын түрэлтийг яаж хүлээн авах вэ? гэдгийг бас бодох асуудал. Бид гэр бүлийн бодлогоо өнөөг хүртэл нарийн гаргаж чадаагүй. Телевиз, радио үзэхэд барууны гэр бүлийн соёл, хүүхдийн хүмүүжил л ярих болж, гэтэл тэр Европын гуравны нэг гэр бүл салсан, гэр бүлээс гадуур төрөлт гээд гэр бүлийн хүмүүжил доголдсон судалгаа бий шүү. Хуульд өөрсдийн соёлыг зөв тусгах ёстой, хэлний асуудалд онцгой анхаарах хэрэгтэй, төрөөс зохицуулах, их нарийн хандах. Жишээ нь: архи пивоны реклам үзээд хүүхэд юу боддог бол?

Тэр судалгаан дээр гарсан сэтгэлгээ гэж. Монгол сэтгэлгээ гэж юу вэ? Судалгаа авч байгаа би юу гэж ойлгож байна бэ, судалгаанд оролцогч юу гэж ойлгож байгаагаас дүгнэлт их өөр гарна.

Б.Пүрэвсүрэн: Танд баярлалаа. Төмөр-Очир та санал бодлоо хуваалцаач:

С.Төмөр-Очир: Бүх нийтийн соёлын боловсрол гэдэг бол Монголд тулгамдсан асуудал. Боловсруулахдаа тунхаглал болгочих вий. Анхаарах ёстой. Үгээр хөөцөлдөөд уриа лоозон лугаа болж байна, амьдралд хэрэгжээсэй.

Соёл, боловсрол, шинжлэх ухаан болохгүй байна л гээд байдаг. Цогцоор шийдэхгүй бол дангаар хөгжих боломжгүй. ЮНЕСКО-ийн 4 зарчим гэлээ дээр, сүүлийн үед 5 дахь зарчим “Суралцахуйд суралцахуй” өөрөө боловсрол олох гэж бий болоод байгаа. Боловсрол ямар нэгэн зүйлийг танин мэдэх шүү дээ.

Сүүлийн үед сургалтын чанар сайжруулна гээд сургалтын хөтөлбөртөө л зууралдах болж, боловсролыг төр анхаарах хэрэгтэй. Боловсролын парадигм гэж бий соёлоор боловсрол олгох, гэр бүлээр боловсрол олгох, хамт олноор боловсрол олгох гээд үүнийг анхаарах. Гол юм бол Монголын үнэт чанар юу вэ? Нэг жишээ дурдъя. Дээр үед Япон хаалттай байгаад нэг доголдоод болохгүй гадагшаа туршлага судлахаар болоод АНУ-хүүхдийн хүмүүжлийг, Англиас ёс суртахууныг, Францаас хатуу чангыг, Германаас сонгодог их сургуулийг авч эзэн хаан “Япон үнэт чанар” гэдгийг бий болгосон байдаг.

Боловсрол гэхээр л сургууль гэж ойлгодог. Боловсролд гэр бүл маш чухал. Хүүхэд муу байхаар л багш руу, сургууль руу түүнийг түлхдэг болсон. Японы хүний үндэс “Япон ээж” байдаг. Японд гадаадад төгссөн хүнийг ажилд авдаггүй, японы хүний үнэт чанар үгүй гэж тэр. Ичишо Кобото гэж япон 1996 оноос Монголд олон удаа ирж олон төсөл дээр ажиллаж байсан хүн хэлэхдээ: Танай боловсролын өөрчлөлт бол 12 жилд шилжсэн өөр юу ч байхгүй гэж байсан.

Үндэсний аюулгүй байдлын гол зүйл бол соёл. Бас нэг асуудал бол буддын шашин бид мэдэхгүй ч амьдралд тогтсон зан үйл. Шашны гол зүйл: Хүнийг хайрла, эцэг эхээ хайрла, байгалиа хайрла гэж сургадаг.

Б.Пүрэвсүрэн: баярлалаа танд. Соёл урлагийн газрын дарга нараар ажиллаж байсан Наранзун, Гантөмөр гээд хүмүүс байна. Наранзун дарга үг хэлнэ үү.

Б.Наранзун: Би өчигдрөөс хойш энэ тухай бодлоо. Ер нь ээжтэйгээ л ажиллах ёстой юм байна гэж бодож байтал Төмөр-Очир багш хэллээ. Бид асуудлаа макро түвшинд авч үзэх ёстой. Тоон болон нөхцөл байдлын судалгааны шалтгааныг олж үр дүнг хамт тооцох хэрэгтэй. Ирээдүй рүү хөрөнгө оруулалт хийх хэрэгтэй, байгаа чиг хандлага, үр дүнг шинжлэх ухаанчаар ирээдүй рүү хандуулах хэрэгтэй. Бид ямар ирээдүйг тооцохгүй нүүр тулаад ирэхээр гал унтраасан бодлого авч хэрэгжүүлээд байна. Миний бодлоор шалтгаан, өнөөгийн цаг үе, ирээдүй рүү чиглэсэн байх. Миний анзаарснаар социалд сөрөг коммент бичсэн, хараасан хүмүүсийн 90 хувь нь эмэгтэйчүүд ээжүүд байна. Ертөнцийг гурав, эрийн гурван наадам гээд бодоод үзэхээр надад гурван зарчим байна.

Төгс бурхан, төгөлдөр хүн, тунгалаг харилцаа тэгэхээр “Төгөлдөр Монгол хүн”-ийг бий болгох юм болов уу. Мөн үнэлгээ тодорхой болгомоор байна, үнэлэмжид анхаармаар байна. Шинэ хуучны хосолмол байх хэрэгтэй байх. Соёлын яам соёлын бүтээлч үйлдвэрлэл гэж их ярих болж, гол нь материаллаг мэдээллийг бий болгох хэрэгтэй, сэтгэл судлал байхгүй болж, цахимд суурилсан сэтгэлзүйн мутант бий болж байна. Өнөөдөр үндэсний соёл, нүүдлийн ахуй үнэ цэнгүй болж байна.

Б.Пүрэвсүрэн: Ээж эх, байгаль эх гэж, 1000 дууны 30 хувь нь эхийн тухай дуу байсан. Эх гэдэг бол элэг. Сонирхуулахад элэг шилжүүлэн суулгасан зөөлөн зан чанартай залуу элэгний донор болсон дүүгийнх нь хатуу зан чанар нь илрээд байна гэсэн сонирхолтой кейс байсан.

Д.Гантөмөр: Бүх нийтийн соёлын боловсрол ямар үзэл баримтлалтай байх вэ?, Ямар менежментээр зохион байгуулах бэ?, үр дүн санхүүжилт нь ямар байх вэ гэдгийг тооцох нь зөв. Хэл нь агуулгаа тодорхойлох уу? Монголын нууц товчоонд нүүрэндээ цогтой, нүдэндээ галтай гэж гардаг. Үндэсний соёлын боловсрол гэж ойлгож байна.

Соёлыг нь ахуйтай холбох, Монголд ирж байгаа жуулчдын 80 хувь нь нүүдэлчдийн ахуй соёлыг үзэх гэж ирдэг гэсэн судалгаа байдаг. Тэнд нэг юм байгаад байна шүү дээ. Энэ бол Соёлын яамны ажил биш, хүрээгээр авч үзвэл гадаадад байгаа Монголчууд, ижил төстэй монгол туургатнууд гээд бүхэлд нь харах хэрэгтэй. Надад “Монгол Тэмүүлэл” байвал зүгээр санагдаж байна.

Бид монгол хамтдаа байхын тулд би ямар байх вэ гэж бодогдож байна. Хүүхдэдээ ямар соёлыг өвлүүлэх бэ?, техникийн хүчин зүйл, шинжлэх ухаанч ирээдүй рүү чиглэсэн байх ёстой.

Олон соёлт байдал соёлын бодлогын тулгуур, олон соёлын уулзвар соёлын дахин хуваарилалт. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд оруулах хэрэгтэй чухал асуудал дурдсан.

Манай хамаатнууд дунд нэг хэлж зөвлөдөг хүн байдаг , айл өрх, хамаатан дунд соёлын хөтөч байх хэрэгтэй. Түүнээс гадна хэлний боловсрол маш чухал хэлний бодлогын зөвлөлтэй хамтрах хэрэгтэй.

Өнөөдөр уургатай малчин, мотоциклтой малчин, дронтой малчин гэсэн гурван хүний төрх бий болсон байна.

М.Батбаяр: Цаг заваа гарган бидэнд үнэтэй санал, зөвлөмж хэлж байгаад баярлалаа. Нэг удаагийн уулзалт хэлэлцүүлгээр хязгаарлахгүй байхаа. Дараагийн хурлын цаг болсон байна.

Б.Пүрэвсүрэн: МУ ерөнхийлөгчийн шашин соёлын зөвлөх асан, соёл иргэншлийн гол төлөөлөгч доктор Батаа та саналаа хэлнэ үү.

М.Батаа: Бодлогын шинжлэх ухааны хамгийн гол нь соёлын асуудал, хоёрдугаарт боловсролын тогтолцоо манайд сүүлийн 30 жил хамгийн их савлагаатай байна.

Соёлын боловсролын үзэл баримтлалыг энгийн гаргах нь зөв байх. Тэгэхгүй бол хэрэгжих хэцүү, хэрэгжилтийг дүгнэх хэцүү болно. Үндэсний соёл, хүн төрөлхтний соёл алийг нь хадгалж, алийг нь хөгжүүлэх үү гэдэг чухал.

Бодлогоор хориглох ямар соёл байна вэ? Ингэвэл боловсролын хөтөлбөр болгоход хялбар болно.

Арга нь албан бус байдлаар хүргэх Гаднын бодлогоор орж ирж байгаа соёл байна Күнзийн институт, гаднын хэрэглээний соёл, гаднын хүмүүнлэгийн соёл гээд

Ер нь үзэл баримтал зөв байж бодлого зөв, үр дүн тодорхой болно. Монгол соёл, монгол соёл иргэншил асар хурдацтай өөрчлөгдөж байна. Тоон судалгаа чухал гэхдээ бүрэн итгэж болохгүй, шинжлэх ухааны чанарын судалгаагаа голлох нь зөв.

Ахмад, дунд, залуу үеийн төлөөллийн үзэл бодол саналыг сонсох нь чухал. Өнөөдөр инфлюсер гээд нэг зүйл бий болж, тэднийг бас оролцуулбал.

Б.Пүрэвсүрэн: Өнөөдөр бодлого тодорхойлогчид цаашид өөр бүлэгт явуулах байх. Галиндэв доктор санал бодлоо хуваалцах уу.

Б.Галиндэв: Олон эрдэмтэд оролцлоо. Би 2,3 санал хэлье. Сүүлийн үед сонгодог уран зохиол уншихаа больсон байна. Аль ч улс үндэстэн ямар ч цаг үед сэтгэлгээний соёлыг сэргээж өгдөг зүйл бол үлгэр зохиол байдаг.. Би их сургуульд хичээл орохдоо анх ирсэн оюутнуудаас сүүлийн 10 жил судалгаа авч байна ямар ном зохиол уншсан бэ? гэж тэд ногоон нүдэн лам, жаран цагаан хонь тэгээд л зуун жилийн ганцаардал гэж байна. Унших нь гэгээрэх чухал ач холбогдолтой. Надад нэг санаа байдаг юм Соёлын яам энэ арилжааны телевиз, радиогоор долоо хоногийн 1 өдрийг сонгодог дуу, хөгжим, сонгодог зохиол, уран баримал гээд хөтөлбөр бодлогоор явуулж болдоггүй юм болов уу гэж.

Одоогийн хүүхдүүдийг цахимаас салгаж чадахгүй тиймээс агуулгыг яаж өөрчлөх бэ? гэдгийг бодох асуудал. Бас нэг асуудал бол шашны асуудал нэг талаас мухар сүсэг, нөгөө талаас соён гэгээрэл шүү дээ. Шашныг гэгээрэл тал руу чиглүүлэх хэрэгтэй.

М.Батаа: Шашнаас битгий ай, соёлын бодлогодоо тусгаарай. Бурханы шашин бол шинжлэх ухаан, түүхэн үүргийг нь авч үзэх хэрэгтэй. Дэлхий дээр 7.9 тэрбум хүн амьдарч байна тэдний 85 хувь нь тодорхой хэмжээний шашин шүтлэгтэй. Монгол туургатныг нэгтгэж байгаа бас нэг зүйл бол шашин

Б.Наранзун: соёлын боловсролыг төлөвшүүлэхэд жижиг зүйлээс эхлэх хэрэгтэй ахуйн соёлыг түгээе, стандарт тогтоох хэрэгтэй үйлчилгээний байгууллагын ч гэдэг юм уу дагаж мөрдөх, 3 жилийн дараа үр дүн нь гарна.

Б.Пүрэвсүрэн: би бол 100 хувь дэмжинэ.

З.Баянзул: Үндэсний үзэл баримтлалд шашны, соёлын заалт байгаа. Өөрсдийн орон зайг бий болгох яаж хэрхэн хэрэгжүүлэх бэ?, ямар арга замаар, нөөцөө тодорхойлох, ямар боломж байна вэ гээд эхний 5 жилд эхлүүлэх нь чухал.

Одоо л бид соёлын яамтай болж нөхцөл бүрдэж эхэлж байна. Соёлын бодлого бидэнтэй бидэнгүй явж байна, төр түүнийг чиглүүлэх үүрэгтэй.

Эрчист гэж дайчин, хөдөлмөрч, идэвхтэй гэсэн утгатай

М.Батаа: үгийн сонголт тиймхэн байна аа.

Б.Цэцэнцолмон: Өнөөдөр би та бүхний санал бодлыг сонсож, ажиглагчийн байр сууринаас оролцож байгаа. Судалгааны үр дүн бол та бидний ярилцаж байгаа эдгээр зүйлс. Үндэсний соёл ахуйгаас холдуулаад байна, бахархал, билэг тэмдэг төдий болж байна. Та дээр хэлсэн хот хөдөөд ялгаатай бодлого байх хэрэгтэй гэж би бол ялгааг салгахгүй баймаар байна.

А.Цанжид: Би жижиг сажиг зүйлээс эхлэх гэдэг тал дээр эсрэг байна.ерөнхий тусгайгаа ялгах хэрэгтэй. Монгол хүн монголоороо байх гол асуудал.

Б.Пүрэвсүрэн: Цаг зав гарган бидэнд үнэтэй санал бодлоо хэлэхээр ирсэн та бүхэнд баярлалаа. Та бүхний саналыг бодлого боловсруулахдаа чухалчлан авч үзэх болно. Баярлалаа.

ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:

Д.НАРАНЦЭЦЭГ

Б.ПҮРЭВСҮРЭН

Ж.ДОЛГОРСҮРЭН

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

СОЁЛЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ

ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГА

ЗӨВЛӨХ, МОДЕРНАТОР

ЗӨВЛӨХ, МОДЕРНАТОР

Я.ОРЛОМСҮРЭН

**Бүх нийтийн соёлын боловсролын арга хэмжээг хилийн чанадад буй
монголчуудын чуулган, хуралдаанаар хэлэлцүүлж саналыг
тусгасан байдал**

Бүх нийтийн соёлын боловсролыг хилийн чанадад байгаа монголчуудад түгээхэд тулгамдаж буй асуудал, өнөөгийн нөхцөл байдалтай танилцахаар 2021 онд зохион байгуулагдсан соёлын бүтээлч сарын хүрээнд:

1. 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Монгол Улсын Гадаад хэргийн яамны их танхимд “Хилийн чанад дахь монгол хүүхдүүдэд олгох соёл, урлагийн боловсрол” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн соёл шашны бодлогын зөвлөх Д.Бум-Очир хэлэлцүүлэгт амжилт хүсэж нээлт хийж, Соёлын яам, Соёл гэгээрлийн газрын дарга Д.Наранцэцэг, Соёлын өвийн газрын мэргэжилтэн Д. Мэндсайхан, Соёл гэгээрлийн газрын мэргэжилтэн Т.Пүрэвсүрэн нар болон ХЧМЗ НҮТББ-ын Тэргүүн, ХЧМЗ НҮТББ-ын боловсролын хорооны гишүүн эх хэл соёлын төвүүдийн тэргүүд, Бүс бүсийн төлөөллүүд, Германы ЭСЯ-ны зөвлөхүүд, орон орны соёлын элч, эх хэл соёлын төвийн багш нар, соёлын боловсролын эрдэмтэн судлаачид оролцсон үр дүнтэй хэлэлцүүлэг боллоо.

Хэлэлцүүлэгт давхардсан тоогоор 20 орчим улсаас цахим болон танхимаар 100 орчим хилийн чанад дахь соёл боловсролын төлөөлөл, соёлын элч нар, багш, салбарын судлаачид оролцсон ба хэлэлцүүлгийн үеэр гарсан гол асуудлууд, санал, дүгнэлт:

✓ Соёлын боловсрол сэдвээр:

1. Хилийн чанад дахь монголчуудад зориулсан соёлын боловсрол олгох нэгдсэн хөтөлбөрийг хамтран гаргах;
2. Хилийн чанадад эх хэл соёлын төвд багшилж буй багш нарыг бодлогоор дэмжин соёлын боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх боловсон хүчин бэлтгэх ажлыг хамтран эхлүүлэх, ур чадвар олгох багшийн нэгдсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх;
3. Хилийн чанадад соёлын боловсролыг хэрэгжүүлэхэд шаардлагатай ном сурах бичиг гарын авлага бэлтгэх ажлыг хамтран хэрэгжүүлэх;
4. Бидний хэрэгжүүлээд сайн туршлага гарган ажиллаж буй “Нүүдлийн соёлын боловсрол” хөтөлбөрийг яам бодлогоор дэмжлэг үзүүлж хамтран ажиллах,
5. Хилийн чанадаас нутагтаа амрахаар ирж буй иргэдийн хүүхэд багачуудад нүүдлийн мал аж ахуйн соёлыг танилцуулах хөтөлбөрийг Бүх нийтийн соёлын боловсрол хөтөлбөрийн дэд хөтөлбөр болгож оруулж хүртээмжийг нэмэгдүүлэх;
6. Хилийн чанад дахь хүүхдийн язгуур урлагийн их наадмыг бүсчилсэн хэлбэрээр Соёлын яам албан ёсоор хамтран зохион байгуулдаг байх;
7. Хилийн чанад дахь эцэг эхэд зориулсан соёлын боловсрол олгох дэд хөтөлбөрийг зохион байгуулах;
8. Хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах ажлын хэсэг гаргаж ажиллах.

2. 2022 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Монгол Улсын Гадаад хэргийн яамны ДБҮЭГ байранд "Хилийн чанад дахь Монгол соёлын сурталчилгаа" хэлэлцүүлэгт оролцон тэдний саналыг сонсон саналаа танилцуулсан болно. Үүнд:

✓ Соёлын сурталчилгааны чиглэлээр:

1. Соёлын элч нарын нөөц бололцоог ашиглаж нэгдсэн платформ үүсгэж хамтын ажиллагааг эрчимжүүлэх;
2. Монголын экспортын бараа бүтээгдэхүүн, мэдээллийн төвийн үйл ажиллагааг түшиглэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хамтран хөгжүүлэх;
3. Хилийн чанад дахь Монгол хэл соёлын төвүүдийн үйл ажиллагааг бодлогоор дэмжин жишиг төвүүдийг хамтран хөгжүүлэх;
4. Соёлын элчийг сонгон ажиллуулах журмын төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах, үр дүнг хэмждэг тогтолцоонд оруулах;
5. Монгол Улсын ерөнхийлөгчийн дэмжлэгтэй хэрэгжих Нүүдэлчдийн их наадам, Нүүдэлчдийн спортын наадмыг хамтран зохион байгуулах ажлын хэсэг гарган ажиллах;
6. Мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгож гадаад дотоод соёлын бүтээлч үйлдвэрлэлийн платформыг үүсгэн оюуны экспорт хийх.

3. 2022 оны 07 дугаар сарын 03-ны өдөр Боловсролын ерөнхий газрын байранд "Хилийн чанад дахь монголчуудын нэгдсэн чуулга уулзалт-2022"-ын салбар хэлэлцүүлэг "Хилийн чанад дахь эх хэл, соёлын багш нарын зөвлөгөөн" сэдвийн хүрээнд зохион байгуулагдахад СБХЗГ-ын дарга Д.Наранцэцэг "Бүх нийтийн соёлын боловсролын талаар баримталж буй бодлого" сэдэвт илтгэл хэлэлцүүлж, 2021 оны дээр дурдсан хэлэлцүүлэг, зөвлөгөөний саналыг хэрхэн хэрэгжүүлж буй мөн бүх нийтийн соёлын боловсролын бодлогын баримт бичигт хэрхэн тусгаж буй талаар тус тус танилцуулж, санал авав.


Хэлэлцүүлэгт оролцсон төлөөлөл "Бүх нийтийн соёлын боловсрол" арга хэмжээнд хилийн чанадад буй монголчуудын эх хэл, соёлын боловсрол олгох асуудал бүрэн туссаны зэрэгцээ энэхүү бодлогын баримт бичиг батлагдсанаар доор дурдсан асуудлуудыг шийдвэрлэх боломжтой болж, хууль эрх зүйн орчин бүрдэж буйд талархлаа илэрхийлээд цаашид хамтран ажиллах чиглэл улам тодорхой болж, байгааг сайшаан хүлээн авлаа.

Хилийн чанадад монгол хэл, соёлын боловсрол олгож буй талаарх нөхцөл байдлын түүвэр судалгааг 2022 оны 05 дугаар сард **Хилийн чанад дахь монголчуудын зөвлөлөөс НҮТББ -ын Боловсролын хорооноос** хийсэн байна. Судалгаагаар нийт 15 оронд 41 монгол хэл, соёлын сургалтын байгууллага бүртгэгдсэн байна. Тус судалгааны дүнгээс үзэхэд:

1. **Монгол хэл, соёлын байгууллагуудаас авсан судалгаа 2021.10 сарын байдлаар** 15 монгол хэл, соёлын сургалтын байгууллага нь монгол соёлын сургалт давхар явуулж байгаа гэж бүртгэлээ өгсөн байна. Нарийвчилбал, давхацсан тоогоор дараах төрлийн сургалт явуулж байна. Үүнд:

- Хөгжмийн сургалт 10
- Бүжгийн сургалт 8
- Ёс заншлын сургалт 7
- Дуу 7
- Зураг 1

Хилийн чанад дахь монгол хүүхдүүдэд урлаг соёл, өв заншлын сургалт явуулахад зайлшгүй шаардлагатай зүйлсийг дарааллаар нь сонгоно уу.



Хилийн чанадад монгол хүүхдүүдэд урлаг соёл, өв заншлын сургалт явуулахад хамгийн хүндрэлтэй асуудал юу вэ?



2. Хилийн чанадад амьдарч буй уран бүтээлчдээс авсан судалгаа:

Гадаадад амьдарч буй монгол хүүхдүүдэд мэргэжлийнхээ дагуу хичээл заах боломжтой юу?
28 Antworten



Хилийн чанад дахь монгол хүүхдүүдэд урлаг соёлын ямар боловсролыг зайлшгүй олгох ёстой гэж та үзэж байна вэ?


28 Antworten



3.Хилийн чанадад амьдарч буй монгол эцэг эхчүүдээс авсан судалгаа:

Хилийн чанад дахь монгол хүүхдүүдэд урлаг соёлын ямар боловсролыг зайлшгүй олгох ёстой гэж та үзэж байна вэ?

117 Antworten



Хилийн чанад дахь монголчуудын зөвлөлөөс НҮТББ-ын Боловсролын хорооноос хийсэн судалгаа болон 2021 он болон 2022 онд хийсэн нэгдсэн чуулган, хэлэлцүүлэг, зөвлөгөөний саналаас харахад дараах асуудлуудыг нэн тэргүүнд шийдвэрлэх, зохицуулах шаардлагатай гэж гарч ирж байгаа ба эдгээр нь төрөөс болон холбогдох төрийн захиргааны байгууллагаас авч буй бодлого, төлөвлөлтөд тусаж хууль эрх зүйн орчин бүрдүүлж, зохицуулалт хийх шаардлагатай байна. Үүнд:

Дэвшүүлж буй санал:

1. Эх хэл, соёлын байгууллагуудын статус, шалгуурыг тодорхой болгох;
2. Эх хэлний цахим сургалтын нэгдсэн жишиг хөтөлбөр, сургалтын хэрэглэгдэхүүн, сан бүрдүүлэх (хүүхэд болон аав ээжид зориулсан, кирилл бичгийн сургалт явуулдаг боловч үндэсний бичгийн сургалт байхгүй, энэ чиглэлд онцгойлон анхаарах);
3. Монгол соёлын боловсролын сургалтын нэгдсэн жишиг хөтөлбөрийг боловсруулан батлуулах, сургалтын материал боловсруулах, цахим гарын авлага, сургалтын эх хэрэглэгдэхүүн, сан бүрдүүлэх (хүүхэд болон аав ээжид зориулсан);
4. Хилийн чанадад монгол соёлын сургалт явуулах багш нарыг бэлтгэх, ингэхдээ хилийн чанадад амьдарч, ажиллаж буй уран бүтээлчдийг хамруулах;
5. Нүүдлийн соёлын боловсрол олгох арга хэмжээг хэрэгжүүлэх явц, боломж, хууль эрх зүйн орчин, зохицуулалтын талаар тодорхой баталгаатай болгох;
6. Нүүдлийн соёлын боловсрол олгох зуслангийн стандартын асуудлыг шийдвэрлэх.

